

***О.БАЯРЖАРГАЛ***
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш, ахмад

## НИЙГМИЙН АЖЛЫН ЁС ЗҮЙН ХӨГЖИЛ ХУВЬСГАЛ

Орчин үеийн нийгмийн ажлын үнэт зүйлс болон ёс зүйн талаар авя үзэхийн тулд мэргэжлийн суурь үнэт зүйл, практикт тулгардаг ёс зүйн хоёрдмол байдал, нийгмийн ажил дахь ёс зүйн шийдвэр гаргах, мэргэжилтнүүдийн мэргэжлээ урвуулан ашиглах буюу мэргэжлийн ёс зүйн алдаа, зөрчлийн талаарх түүхэн хөгжлийг судлах нь чухал юм. Нийгмийн ажлын мэргэжлийн үнэт зүйлс болон ёс зүй нь сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц боловсронгуй болж байна.

Нийгмийн ажлын үнэт зүйлс болон ёс зүй нь нийгмийн ажлын хөгжлийн явцад хувьсан хөгжсөөр ирсэн бөгөөд 1992 онд судлаач Ф.Риймэр ёс суртахууны үе, үнэт зүйлсийн үе, ёс зүйн онол ба шийдвэр гаргах үе, ёс зүйн стандарт ба эрсдэлийн менежментийн үе гэсэн үндсэн үе шатуудад ангилжээ. Үүнд:

1. Ёс суртахууны үе: 19-р зууны төгсгөл, 20-р зууны эхэн үеэс нийгмийн ажил нь мэргэжлийн үйл ажиллагаа болон хөгжиж эхлэх үед нийгмийн ажилтнуудын ёс зүй, ёс суртахуунаас илүүтэйгээр үйлчлүүлэгчийн ёс суртахуунд илүү анхаарлаа хандуулж байв. Тухайн үеийн судлаачид бүтээлүүдэд үйлчлүүлэгчдэд хандах эерэг харилцааны талаар тодорхой хэмжээгээр тусгагдаж байлаа. М.Ричмонд, Ж.Адамс нарын бүтээлүүдэд нийгмийн ажлын эрхэм зорилго, ёс зүйн зарчмуудын талаар тусгагдсан нь хожимоо Ф.Риймэр, М.Пэйн, В.Робинсон, Р.Долгоф, М.Лювенберг, Д.Харингтон нарын бүтээлийн эх сурвалж болсон төдийгүй орчин үеийн нийгмийн ажлын ёс зүйн хөгжлийн эх суурь болсон юм.

Энэ үед ихэнх нийгмийн ажилтнуудын зорилго болон үнэт зүйлсийн баримжаалал нь ёс суртахуунлаг эсвэл ёс суртахуунлаг бус зүйлийн талаар санаа зовохоос илүү орон байр, эрүүл мэндийн тусламж, эрүүл ахуйн байдал, ажил эрхлэлт, ядуурал, боловсрол гэх мэт нийгмийн өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэхэд дэвшилттэй нийгмийн өөрчлөлтийг хийх хэрэгцээнд чиглэж байсан байна. АНУ-д 1930-1940 оны үед үйлчилгээнд баримтлах ёс суртахууны ололтуудыг тусгасан нийгмийн олон бодлого, хөтөлбөрүүд бий болоход нийгмийн ажилтнуудын нөлөө их байжээ. Өөрөөр хэлбэл, энэ үеийн онцлог нь нийгмийн ажлын мэргэжлийн ёс зүйгээс илүү үйлчлүүлэгчийн ёс суртахууны асуудалд анхаарлаа хандуулж байв.

2. Үнэт зүйлсийн үе: 20-р зууны эхэн үеэс дунд үед үйлчлүүлэгчийн ёс суртахууны асуудалд анхаарлаа хандуулах нь зарим талаараа буурч халамжийн сургуулиуд, сургалтын хөтөлбөрүүд, интервенцийн стратеги, арга

техникийг бий болгох, хөгжүүлэх, нийгмийн халамжийн бодлого болон удирдлага, сэтгэл засал, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээний талаар мэргэжлийн ур чадварыг бий болгоход анхаарлаа хандуулах болов. Энэ мэргэжлийн үнэт зүйлсийн талаарх асуудлыг хөндөхөд хүргэжээ. Энэ үеийн бүтээлүүдэд мэргэжлийн суурь үнэт зүйлсийг авч үзэхдээ мэргэжилтнүүдийн хувийн үнэт зүйл болон мэргэжлийн үйл ажиллагааны хоорондын холбоог судлахад түлхүү анхаарлаа хандуулах болсон. Үнэт зүйлсийг тайлбарлах хандлага нь ялангуяа ядуурал, үр хөндөлт, ижил хүйстний бэлгийн харьцаа, архи мансууруулах бодисын хэрэглээ, гарал угсаагаараа ялгаварлах зэрэг асуудлуудад зарим нийгмийн ажилтнууд өөрсдийн хувийн үзэл бодол болон мэргэжлийн үйл ажиллагааны хоорондын хил хязгаарыг зохиостой түвшинд ажиллахад мэргэжлийн үнэт зүйлийг эрхэмлэн ажиллах шаардлага бий болж байна.

Мэргэжлийн үйл ажиллагаа болон хөгжиж эхэлсэн үеэс 50 орчим жилийн дараа нийгмийн ажил нь мэргэжлийн үнэт зүйлст суурилсан ёс зүйн ерөнхий чигийг мэргэжилтнүүдийн дунд бэхжүүлэн хөгжиж эхэлжээ. 1920-иод онд АНУ-ын Нийгмийн ажилтны ёс зүйн дүрмийн анхны хувилбар гарч, мөн энэ чиглэлээр мэргэжлийн сэтгүүлүүдэд өгүүллэгүүд ихээр хэвлэгдэж эхлэв. Тус дүрэм 1960 онд батлагдсан байдаг. Энэ нь тухайн цаг үеийг хүртэл нийгмийн ажилтнууд энэхүү сэдвийг үл ойшоож байсан гэсэн санаа мэдээж биш юм. Нийгмийн ажилтнууд нь хувь хүний язгуур эрх ашиг, үнэ цэнэ, өвөрмөц шинж, өөрийгөө тодорхойлох эрх, бие даасан байдал, шударга ёс, тэгш байдал зэргийг үргэлж дэмжиж ирсэн (Ричмонд 1917, Бистек 1987, Кабот 1973, Хамилтон 1951, Жозеф 1989). Ялангуяа, 1960-аад онд нийгмийн ажилтнууд нийгмийн шударга ёс, хүний эрхийн асуудалд анхаарлаа хандуулах болсон нь жам ёсны үйл явц байлаа (Эммит 1962, Ливес 1972, Риймэр 1994, Вилилэнт 1974). Мөн 1922 онд Америкийн Гэр бүлийн Халамжийн Нийгэмлэгээс энэ салбар дахь ёс зүйн маргаантай асуултуудад хариу өгөс Ёс Зүйн Хороо байгуулсан нь мэргэжлийн ёс зүйн талаарх маргааныг шийдвэрлэх анхны томоохон алхамуудын нэг байсан юм. Мөн нийгмийн ажлын үнэт зүйлс, ёс зүйн тулгамдсан асуудлыг хөндсөн томоохон бүтээл бол Ливигийн Нийгмийн Ажлын Ёс шинжилгээ, судалгааны ажил өргөжин хөгжжээ.

3. Ёс зүйн онол ба шийдвэр гаргах үе

1970-1980-аад оны дунд үед нийгмийн ажлын мэргэжил нь үнэт зүйлс болон ёс зүйн асуудлуудад чиглэсэн өөр нэгэн чухал ач холбогдол бүхий шилжилтийг туулсан юм. Судлаачид 1970-аад оноос хэрэглээний болон мэргэжлийн ёс зүйг өргөн хүрээнд судлах болов. Анагаах ухаан, сувилахуй, эрх зүй, бизнес, сэтгүүл зүйл, сэтгэл зүй, нийгмийн ажил зэрэг олон мэргэжлүүд ёс зүйн онолуудыг судлах, шийдвэр гаргах үйл явцад анхаарлаа хандуулж эхэлжээ. Төгсөлтийн өмнөх болон

төгсөлтийн дараах сургалтын олон хөтөлбөрт хэрэглээний болон мэргэжлийн ёс зүйн төлөөр хичээлүүд нэмэгдэж, мэргэжлийнн хурлуудад энэ талаар тавигдах илтгэлүүдийн тоо өсч, мэргэжлийн ёс зүйн талаар хэвлэгдэх бүтээл эрс нэмэгдсэн байна (Абрамсон 1982). Нийгмийн ажлын ёс зүйн шийдвэр гаргахад баримтлах баримт бичгүүд, стандарт, хэм хэмжээ, дүрэм журам, удирдамжууд бий болж эхэлсэн нь энэ үеийн онцлог юм. Тухайлбол, Био ёс зүйн нэвтэрхий толь, Хэрэглээний ёс зүйн нэвтэрхий толь гэсэн хоёр томоохон бүтээлд ёс зүйн онолууд болон холбогдох ойлголтуулыг тайлбарласан нь өндөр ач холбогдолтой байлаа. Энэ үе АНУ, Герман, Австрали зэрэг дэлхийн олон улс оронд нийгмийн ажилтны ёс зүйн дүрмүүд шинээр болон шинэчлэгдэн батлагдсан байна.

Мэргэжлийн ёс зүйн шийдвэр гаргах үйл явцыг анхааран судлах болсон нь олон хүчин зүйлсээс шалтгаалж байв. Тухайлбал, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээн дэх үр хөндөлт, эрхтэн шилжүүлэн суулгах, генийн инженерчлэл, сэтгэц идэвхит эмийн асуудал зэрэг нь ёс зүйн асуудлыг бий болгосны зэрэгцээ эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын болон анагаах ухааны ёс зүйд олон тулгамдсан асуудлыг буй болгожээ. Эдүгээ эрхтэн шилжүүлэн суулгах шаардлагатай байгаа үйлчлүүлэгчийг сонгохдоо эмнэлгийн зүгээс ямар шалгуур хэрэглэх ёстой вэ, хөнгөвчлөх тусламжийг зогсоохыг хэзээ зөвшөөрөх вэ, үр шилжүүлэн суулгах нь зохимжтой юу, төрөлхийн зүрхний гажигтай нярайн биед амьтны зүрх суулгах нь ёс зүйн хувьд зөвтгөх зүйл мөн үү зэрэг олон асуудлууд тулгамдсан хэвээр байна. Зарим эмч, сэтгэл зүйч, хуульч, лам хуврага, нийгмийн ажилтан, сувилагч, эм зүйч нар тусламж дэмжлэг шаардлагатай хүмүүсийн нөхцөл байдлыг ашиглан үйлчдүүлэгчиддээ нийгэм-сэтгэлзүй, бие махбодь, санхүүгийн хувьд хүндрэл учруулах явдал ч тохиолдож байна. Эдгээр мэргжилтнүүд хүний эрхийн үзэл баримтлалд илүү анхаарлаа хандуулж, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээх мэргэжлийн ёс зүйн үүрэг хариуцлагын талаар асуудлыг хөндсөн бүтээлүүд туурвиж, их сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгаж, нийгмийн ажилтнуудад сургалтуудыг зохион байгуулах ажлууд АНУ, Орос, Англи, Герман, Австрали зэрэг орнуудад эрчимтэй өрнөсөн байна.

Нийгмийн шинжлэх ухааны ихэнх тайлагдаагүй зүйлсийн түлхүүр, өнөөдрийн мэргэжилтнүүдийн хариулж чадахгүй байгаа асуултуудын үндэс суурь нь угтаа ёс зүйн шинжтэй гэдэгтэй судлаачид санал нэгддэг (Слоан 1980). Иймээс нийгмийн ажил зэрэг мэргэжилүүд ёс зүйн боловсролд анхаарлаа хандуулах болсон юм (Хаустон-Вега 1997, Риймэр 2003). Хэрэглээний болон мэргэжлийн ёс зүйн хөгжилд мэдэгдэхүйц нөлөөлжээ. (Маннинг 2003, Матисон 2000). 1980-аад оны эхээр нийгмийн ажлын зарим судлаачид, тухайлбол, ёс зүйн

онолууд, нийгмийн ажлын шууд ба шууд бус практикт тохиолдох ёс зүйн хоёрдмол байдлын нийтлэг шинж, түүнийг шийдвэрлэх боломжуудын талаар тууршиж эхэлжээ. Энэ үед нийгмийн ажилтууд мэргэжлийн үйл ажиллагаандаа ёс зүйн үүднээс хандах хандлага нь илүү онолын үндэстэй болж, ёс зүйн шийдвэр гаргах загваруудаар улам баяжигдсан гэж үзэж болно.

4. Ёс зүйн стандарт ба эрсдэлийн менежментийн үе

1980-аад оны дунд үеэс нийгмийн ажлын ёс зүйн хөгжлийн орчин үе хамрагдах бөгөөд энэ нь эрс шилжилтийн үе юм. Нийгмийн ажилтнуудын практик удирдамж болох ёс зүйн стандартууд бий болж, мэргэжлийн үүрэг хариуцлагад хайхрамжгүй хандахгүй байх мэдлэг нэмэгдсэн нь энэ үеийн гол онцлог юм. Энэ үед мэргэжлийн талаарх ёс зүйн дүрэм, стандартууд улам боловсронгуй болж, ёс зүйн холбогдолтой бүтээлүүдэд мэргэжлийн алдаа, зөрчил үүрэг хариуцлагаас үүдсэн эрсдэл, үйлчлүүлэгчийг хамгаалахад чиглэсэн эрсдэлийн менежментийн стратеги, ёс зүйтэй холбоотой зарга, гомдолоос урьдчилан сэргийлэх талаар авч үзэх болсоныг онцлон тэмдэглэх хэрэгтэй (Баркер 2000, Хаустон-Вега 1997, Риймэр 2003). ОУНАХ-оос Нийгмийн ажилтны ёс зүйн зарчим, стандарт баримт бичгийг 1994 онд баталсан нь нийгмийн ажилтнууд ёс зүйн алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх томоохон алхам болсон юм. Энэхүү баримт бичгийг 2004 онд Нийгмийн ажлын ёс зүйн зарчмын тунхаглал нэртэйгээр шинэчлэн баталсан байдаг. Гэсэн хэдий ч сүүлийн үеийн тоо баримтаас үзэхэд АНУ-д нийгмийн ажилтнуудын ёс зүйн алдаа, зөрчилтэй холбоотой гомдол саналууд нэмэгдсээр байна (Бэрлинер 1989, Баллис 1995). Сүүлийн үед эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажлын мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол нэмэгдсээр байна ( Риймэр 2003): Нийгмийн ажилтнуудад хандсан гомдол нэмэгдсэний улмаас ямар төрлийн алдаа, зөрчил гарч байгаад чиглэсэн олон тооны нийгмийн ажлын хөтөлбөр, нийгмийн үйлчилгээний агентлаг, мэргэжлийн үйлчилгээний эрх олгох зөвлөл, мэргэжлийн нийгэмлэг нь ёс зүйн эрсдэлийн менежмент, ялангуяа үйлчлүүлэгчийн нууц мэдээлэл, таниулсан зөвшөөрөл, сонирхолын зөрчил, давхар харилцаа болон мэргэжлийн хил хязгаарын асуудал, үйлчигээг хаах, баримтжуулах зэрэгтэй холбоотой тусгай сургалтууд, болон бусад боловсрол олгох үйл ажиллагаануудыг дэмжсээр байна.

Түүнчлэн АНУ, Орос, Англи, Герман, Австралийн нийгмийн ажлын судлаачид болон практик ажилтнууд ёс зүй болон үүрэг харуцлагатай холбоотой эрсдэлийг хэрхэн зөв зохион байгуулахад анхаарлаа хандуулах боллоо (Риймэр 2001, Сторм-Готпрэйд 1998). Мөн сүүлийн үед өсөн нэмэгдэж буй төлөвлөгдсөн тусламж үйлчилгээ нь даатгалын үйлчилгээний компани, үйлчилгээ үзээлэгч байгууллагуудаас хамгийн үр ашигтай сэтгэцийн эрүүл мэндийн болон нийгмийн үйлчилгээг

хүргэх шаардлагыг бий болгосон байна. Төлөвлөгдсөн тусламж үйлчилгээний нэг онцлог нь нийгмийн ажилтнууд үйлчилгээ эхлэхээс өмнө нийгмийн үйлчилгээний байгууллагуудаас заавал дэмжлэг авах ёстой гэж үздэгт оршино. Энэ үйл явц нь нийгмийн ажилтнуудаас үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг илрүүлэхийг шаарддаг. Нийгмийн үйлчилгээний байнууллагын нийгмийн ажилтнууд нь мэдээллийг илрүүлэхтэй холбоотой нууцыг хадгалах, эрсдэлийн талаар мэдлэгтэй байх ёстой. Үйлчилгээг хугацаанаас нь өмнө дуусгах нь ёс зүйн болон үүрэг хариуцлагын томоохон эрсдэлтэй зүйл юм. Дээрх ёс зүйн асуудлууд нь ёс зүйн дүрэм, стандартыг нарийвчлан боловсруулах, үйлчлүүлэгч, түүнчлэн нийгмийн ажилтанд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар чармайлтыг улам их шаардсаар байна.



**О.ЖАРГАЛСАЙХАН**
*МУБИС. Нийгмийн ажил арга зүйн тэнхим*

**Т.БУЛГАНЗАЯА**
*МУБИС. Нийгмийн ажил арга зүйн тэнхим*

# ХОРИХ БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

**Abstract:** This study presents the results from a study on current situation and improving needs for child protection services toward juveniles confined in correctional facilities. Secondary data analysis, semi standardized interview and observation have been used to collect the information from practitioners, psychologist, doctor and juveniles in correctional facilities.

The research findings show that it is urgently required to improve the service to address the bullying and abuse among children in correctional facilities. There is a lack of standards, service provision plan and methodology for child protection in both women`s prison and children correctional facilities in Mongolia.

The originality of this study lays in the fact that it is the first time that current situation on child protection services in correctional facilities and prison in Mongolia is analyzed and discussed specifically from the perspective of children. The authors has tried to determine whether child protection services exists in correctional facilities in Mongolia.

**Түлхүүр үг.** Хүүхэд хамгаалал, үйлчилгээний стандарт, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийнхний дарамт

**Хорих байгууллага дахь хүүхэд хамгааллын холбогдолтой эрх зүйн зохицуулалтаас**

Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийг бууруулах, холбогдох харилцааг зохицуулах зорилгоор МУ-ын УИХ-аас 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиудыг тус тус батлан хэрэгжүүлж эхлээд байна. Өнөөдрийн байдлаар манай улсад гэмт хэргийн улмаас хорих ял эдэлж байгаа хүүхдийг хамгаалах явдал нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль дор дурдсан бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, олон улсын гэрээгээр зохицуулагдаж байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль
- Хорих ангийн дотоод журам
- Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар
- Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын харилцааны хэм хэмжээ гэх мэт.

Дээр дурдсан үндэсний хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдээс гадна Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцуудад насанд хүрээгүй ялтан, хоригдогчдыг хамгаалах асуудлыг тусгасан байдаг. Үүнд, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенц, Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/ зэргийг дурдаж болно.

**Хорих ял эдэлж буй хүүхдийн эсрэг үе тэнгийнхний дарамт**

Судалгааны мэдээллээр хорих ял эдэлж буй хүүхдүүдийн дунд үе тэнгийнхний дарамт, шахалтын хэлбэрүүд далд байдлаар байсаар байна. Хоригдож буй хүүхдүүдийн дунд хорих ангийн албан хаагчдаас илүү нэг нэгнээ дарамталж дээрэлхэх хандлага гардаг байна. Бие биенийхээ хувцас, хувийн эд зүйлийг дарамтлан ашиглах, нүднээс далд орчинд биед гэмтэл учруулах, айлган сүрдүүлэх, хорлох зэрэг хэлбэрээр үе тэнгийнхний дарамт түгээмэл илэрдэг байна.

*... Хорих ангид байхад хүүхдүүд нэг нэгнийгээ дээрэлхэж дарамтлах явдал байдаг байсан. Хоол идэж байхад хоол руу шүлсээ хийх, хүнгүй газар, камераас нуугдаж нуруу бөөр руу цохих, мөнгө нэхэх зэргээр дарамталдаг байсан. 00-д орохоор араас орж ирээд өшиглөдөг. Гэхдээ бүх хүүхдүүд биш. Ганц хоёр тийм хүүхдүүд байдаг. Бусад нь тэднээс айдаг. Бараг бүгдийг нь дээрэлхдэг. (Хүүхэд насандаа хорих ял эдлээд суллагдсан хүний ярианаас)*

Хорих ангид ял эдэлж байгаа хүүхдүүдийн дундах үе тэнгийнхний дарамт дээрэлхэлт нь далд хэлбэрээр оршдог учраас тухайн нөхцөл байдал хүндэрч, ноцтой хэмжээнд очих хүртэл эсвэл дарамтанд өртсөн хүүхэд өөрийн байдлаа мэдээлэх хүртэл үргэлжлэх хандлагатай байдаг. Өөрөөр хэлбэл хорих ангид хүүхэд хүүхдээ дарамтлах буюу үе тэнгийнхний дарамт шахалтыг илрүүлэх, олж тогтооход чиглэсэн арга, механизм дутагдалтай байна. Ийм учраас үе тэнгийнхний дарамтад өртсөн хүүхэд өөрт учирч буй дарамтыг мэдээлэхгүй өнгөрөх, тэвчих хандлагыг баримталдаг байна.

*...Өөрийгөө дарамтлаад байгаа хүүхдийг албан хаагчид хэлж мэдээлье гэхээр "гөрөө хийлээ" гээд улам дарамтална. Улам л байдал хэцүүддэг. (Хорих ангид ял эдэлж буй хүүхдийн ярианаас)*

Хэдийгээр хүүхдүүдийн дунд нэг нь нөгөөгөө дарамталж дээрэлхэх явдал байдаг ч түүнийг бүртгэж тэмдэглэсэн тэмдэглэл хорих ангийн жижүүр, албан хаагчдын дунд байдаггүй нь энэ явдал далд хэлбэрээр оршсоор байгааг илтгэх

нэг үзүүлэлт юм. Хорих ангийн албан хаагчдын зүгээс голдуу хорих ангиас оргохоор завдсан болон албан хаагчидтай маргасан, архи, тамхи хэрэглэсэн зэрэг дотоод журам зөрчсөн тохиолдлыг бүртгэлд тэмдэглэн арга хэмжээ авдаг байна.

*Одоогийн хүүхдүүд хувцсаараа их өрсөлддөг болчихсон. Нэгнийх нь ар гэр эргэлтээр ирэхдээ гайгүй пүүз өгдөг. Хүүхдүүд л болсон хойно шохоорхоно. Тэгээд нэг овгор хүүхэд нь пүүзийг нь хэд хоног өмсөөд өгье гээд гуйгаад өмсчихдөг. Нөгөө хүүхэд маань үгүй гэж хэлж чаддаггүй. Буцаагаад өгье гэсэн хугацаандаа өгдөггүй. Пүүзээ өгсөн хүүхэд нь хараад байдаг. Шууд хэлээд авчихья гэхээр чаддаггүй. ...(Хорих ангийн албан хаагчийн ярианаас)*

Хорих ял эдэлж буй хүүхдүүдийн дунд үе тэнгийнхний дарамт, шахалт хүүхдийн тоо нэмэгдэхийн хирээр өсөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

*...Өсвөр насны хүүхдүүд болохоор хүүхэд хоорондын дарамт шахалтын асуудал байдаг л юм байна лээ. Одоохондоо цөөхөн хүүхэдтэй болохоор гайгүй байна. Арваад жилийн өмнө 100 гаруй хүүхэдтэй байхад бие биенээ дарамтлах, хүчирхийлэх, яргалах зэрэг асуудлууд нэлээд гардаг байсан. (Хорих ангийн албан хаагчийн ярианаас)*

**Хорих байгууллага дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний өнөөгийн байдал**

Судалгаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хүүхдийн хорих анги болон эмэгтэйчүүдийн хорих ангийн мэргэжилтнүүд хамрагдсан. Хүүхэд хамгааллын үйлчилгээг системтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тусгайлсан хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан, мөрдөж ажиллах нь чухал нөлөөтэй боловч бодит байдал дээр тухайн чиглэлээр дорвитой ажил хийгдэхгүй байна. Эдгээр хорих ангийн аль алинд хүүхдийг аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, ялгаварлан гадуурхалд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээний хөтөлбөр төлөвлөгөө байдаггүй, байгууллагын цаашилбал салбарын хэмжээнд ч холбогдох эрх зүйн орчин сайн бүрдээгүй хэмээн судалгаанд оролцогчид тайлбарлажээ. Харин хорих байгууллагын зарим баримт бичгээс харахад нааштай алхмууд хийгдэж байна. Учир нь хүүхдийн хорих ангид мөрдөгдөх ... ДУГААР БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ-ыг төслийн саналын хэмжээнд боловсруулан, тус журамд хүүхэд хамгааллын холбогдолтой хэд хэдэн заалтыг тусгаж өгчээ. Тэдгээрээс иш татвал,

Ес. Сургалтын харилцаанд оролцогчдын үүрэг.

9.3.2. Багш нь багшийн ёс зүйн хэм хэмжээг хүндэтгэн сахиж, биелүүлж ажиллах

Арав. Суралцагчаас хориглох зүйл.

10.1.2. Бусдыг хүч түрэмгийлэх, заналхийлэх, зүй бусаар харьцах, доромжлох.

Арван нэг. Багш, ажилтнаас хориглох зүйл.

11.9. Сурагчидтай зүй бусаар харьцах, бие махбодын шийтгэл үзүүлэх.

Өнөөдрийн байдлаар дээрх байгууллага, мэргэжилтнүүд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дарамт, зөрчил, асуудлыг шийдвэрлэх зорилгоор тусгайлан хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, мөрддөггүй ба шаардлагатай тохиолдолд хорих ангийн дотоод журам, дээд шатны байгууллага, удирдлагаас ирүүлсэн тушаал, зааврыг үндэслэн ажил үйлчилгээ явуулж байна. Үүнээс гадна хорих ял шийтгэгдсэн эмэгтэй хүүхдүүдийн хувьд онцгойлон анхаарах шаардлагатай байна. Учир нь насанд хүрээгүй эмэгтэй ялтанд зориулсан тусгай бодлого зохицуулалт, үйлчилгээний хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, тэднийг байршуулах өрөө тасалгаа, орчин нөхцөл ч бүрдээгүй зэрэг шийдэх шаардлагатай асуудал цөөнгүй байна.

*...Эмэгтэй хүүхэд гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ял эдлэх тохиолдол харьцангуй цөөн гардаг. Манайд жилийн өмнө нэг хүүхэд хоригдож байгаад 18 нас хүрээд насанд хүрэгчдийн хэсэг рүү шилжсэн. Насанд хүрээгүй эмэгтэй ялтныг байршуулах тусгай өрөө ч байхгүй. Дээрх хүүхдийн хувьд насанд хүрэгчидтэй хамт байх боломжгүй тул хорих ангийн эмнэлгийн нэг өрөөнд байлгадаг байсан. Хүүхдэд зориулсан бодлого хөтөлбөр гэж бараг үгүй. Бусад ялтны хамт үйл ажиллагаанд оролцуулах ч боломжгүй. (Хорих ангийн албан хаагчийн ярианаас)*

Хүүхэд хамгааллын үйлчилгээний чухал хэсгүүдийн нэг нь тусламж үйлчилгээ хэрэгцээтэй байгаа хүүхдийг судалж илрүүлэх, цаашилбал бүртгэл мэдээллийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Гол төлөв ял эдэлж байгаа хүүхдийн эцэг эх, ар гэрийнхний зүгээс гаргасан санал, гомдлыг харгалзан асуудлыг шийдвэрлэдэг ба цөөн тохиолдолд хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүд өөрсдөө хандаж ирэх эсвэл хорих ангийн албан хаагчдын зүгээс мэдээллэдэг байна. Үүний зэрэгцээ тодорхой хугацааны давтамжтайгаар хийгддэг үзлэг шалгалтын үеэр хүүхдүүдийн байр байдал, зөрчил асуудлыг илрүүлэн ажилладаг талаар судалгаанд оролцогчид мэдээллэсэн. Харин нийгмийн ажилтнууд мэргэжлийн чиг үүргийнхээ хүрээнд шинжлэх ухааны тодорхой арга, аргачлалыг ашиглан тухайн

асуудлыг судалж шинжлэх ажилд төдийлөн ач холбогдол өгч ажиллахгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Өнөөдрийн байдлаар манай улсын хорих байгууллагад ял эдэлж байгаа хүүхдэд, үзүүлэх хамгааллын үйлчилгээний нэгдсэн аргачлал, нийтлэг жишиг загвар гэж хараахан үгүй байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын үзэж байгаагаар холбогдох хууль, хорих байгууллагын дотоод журам, нийгмийн ажлын заавар зэрэг эрх зүйн акт, баримт бичигт энэ талаар тусгасан байдаг ч, шаардлагатай тохиолдолд ямар тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар тогтсон аргачлал загвар байдаггүй, улмаар юу хийх нь тодорхойгүй байдаг гэж хариулжээ.

Хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь янз бүрийн таагүй үр дагаваруудыг үүсгэх ба тэдгээрийг арилгаж багасгахад чиглэсэн тусламж үйлчилгээ нь ч үйлчлүүлэгчийн хэрэгцээнд нийцсэн олон төрөл хэлбэртэй, сонголт хийх боломжтой байхыг шаарддаг. Хорих ангийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, эмч мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас харахад шаардлагатай үед тодорхой хэмжээгээр тусламж үйлчилгээ үзүүлдэг ч холбогдох эрх зүйн зохицуулалт, хөрөнгө төсөв, бусад шалтгааны улмаас төдийлөн хангалттай түвшинд байж чаддагүй гэж үзжээ. Тухайлбал, нийгмийн ажилтнуудын ажлын ачааллын дийлэнх хэсэг нь хүүхдийн эрх, хамгааллын асуудалд анхаарахаас илүүтэй ахуй хангалт, зохион байгуулалтын шинжтэй ажлуудад чиглэдэг байна.

Хорих байгууллагад хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг багасгаж бууруулах нь дан ганц тухайн байгууллага, мэргэжилтнүүдийн шийдвэрлэх асуудал бус, боловсрол, эрүүл мэнд, хууль эрх зүй, халамж хамгаалал, засаг захиргааны нэгж гэх мэт олон салбарын үйлчилгээ, үйл ажиллагаанд тулгуурласан салбар хоорондын асуудал байдаг. Өөрөөр хэлбэл, дээрх салбаруудын мэргэжилтнүүдийн харилцаа, хамтын ажиллагаа, дэмжлэг оролцоотойгоор шаардлагатай тусламж үйлчилгээг зохистой, цогц байдлаар хүүхдэд үзүүлдэг. Иймд нэг талаас тухайн харилцаанд оролцож байгаа талуудын буюу мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг нарийвчлан тогтоож тодорхойлох нөгөөтэйгүүр тэрхүү үүрэг хариуцлагын талаар салбарын болон байгууллагын хүрээнд баримталж буй бодлогын баримт бичиг, эрх зүйн акт, заавар зөвлөмжүүдэд тодорхой, ойлгомжтой байдлаар тусгах нь чухал юм. Судалгаанд хамрагдсан эдгээр хорих ангийн хувьд хүүхдийн хөгжил, хамгаалал,

асрамж халамжийн тодорхой чиглэлүүдээр төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, мэргэжилтнүүдтэй тогтмол хамтран ажилладаг ч, энэхүү харилцаа хамтын ажиллагааг зохицуулж чиглүүлсэн удирдамж зааврын талаарх мэргэжилтнүүдийн ойлголт зөрүүтэй байна. Тодруулбал, тэдний зарим нь энэ тухайд холбогдох дүрэм, журамд маш тодорхой тусгасан байдаг хэмээн үзэж байхад, нөгөө хэсэг нь огт мэдэхгүй байх жишээтэй.

Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбогдох бүртгэл мэдээлэл, баримт бичгийг хөтлөх тодорхой аргачлал бүхий удирдамж зааврыг хэрэглэх тал дээр хорих анги тус бүрт ялгаатай дүр зураг ажиглагдаж байна. Нэг хорих ангид нь тухайн байгууллагын хэмжээнд боловсруулсан удирдамж, заавар, аргачлалын дагуу баримт бичгээ хөтөлж явуулж байхад нөгөөд нь дээрхтэй адил тодорхой, тогтсон аргачлал одоогоор алга байна.

Үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, хэрэгцээтэй уялдуулан чанартай тусламж үйлчилгээг хүргэж, асуудлыг үр дүнтэй, бүрэн дүүрэн шийдвэрлэх зорилгоор хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхдийн эрсдлийн түвшинг үнэлж тогтоодог. Тус судалгаанд оролцогчид бүгд энэхүү үнэлгээ чухал болохыг хүлээн зөвшөөрч байсан ч үнэлгээг хийж буй тоо давтамжийн хувьд харилцан адилгүй байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээнд сайтар анхаардаг зарим улс орны стандартад үйлчилгээний эхэнд, дунд, төгсгөлд гэсэн наад зах нь гурван удаа эрсдлийн түвшинг үнэлж тохирох тусламж үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байдаг. Харин бидний энэхүү судалгаанд оролцсон мэргэжилтнүүдийн зарим нь дээд тал нь 1-2 удаа үнэлдэг гэж хариулсан бол, зарим нь үнэлгээ хийдэг эсэх талаар тодорхой хариулт өгсөнгүй.

Хорих ангиудад хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар үр дүнг үнэлэх нийтлэг жишиг аргачлал байдаггүй. Харин асуудал, зөрчил шийдвэрлэгдсэн эсэх, үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээг хүргэж чадсан эсэхэд тухайн тусламж үйлчилгээг үзүүлсэн нийгмийн ажилтан, мэргэжилтнүүд өөрсдөө үнэлгээ хийж хариуцдаг байна. Мөн уг асуудалд хяналт, шинжилгээ хийдэг мэргэжилтнүүдээс бүрдсэн баг ажилладаггүйн зэрэгцээ хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын оролцоо ч дутмаг байна.

Ер нь хорих байгууллагад хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартыг боловсруулж хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой болохыг мэргэжилтнүүд онцолсон.

Судалгаанд оролцогчид хүүхэд хамгааллын үйлчилгээний стандартад дараах зүйлсийг

зайлшгүй тусгах шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:

- ✓ Хорих анги дахь сургууль буюу сургалт хүмүүжлийн байгууллагын орчин нөхцөл, тавигдах шаардлага
- ✓ Багшид тавигдах шаардлага, эрх, үүрэг
- ✓ Хүүхэдтэй ажиллах мэргэжилтэнд тавигдах шаардлага /тухайлбал, эмэгтэйчүүдийн хорих ангид нярайн эмч/ ажиллуулах
- ✓ Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааны төрөл чиглэл
- ✓ Хүүхдийн хорих анги анги дахь дэглэм, орчин нөхцөл
- ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх аргачлал
- ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээний төсөв санхүүжилт
- ✓ Хүүхэд хамгааллын үйлчилгээний орчин, материаллаг нөхцөл

Мөн судалгаанд оролцогчид үйлчилгээний төрөл хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх үйлчилгээг онцлон анхаарах, хүүхдийн насны онцлог, ялгаатай байдлыг хэрхэн харгалзаж үйлчилгээг хүргэх /тухайлбал, 0-1 настай хүүхдэд үзүүлэх үйлчилгээний стандарт гэх мэт/, хүүхэд хамгааллын үйлчилгээнд хэн, ямар үүрэг оролцоотой байх, үйлчилгээг ямар дарааллаар ямар хугацаанд үзүүлэх зэргийг нарийвчлан тусгах нь зүйтэй үзжээ.

**Дүгнэлт**

Хорих ангид ял эдэлж буй хүүхдийн хамгааллын асуудалд үе тэнгийнхний дарамт, хүчирхийлэлтэй асуудал тулгамдаж байна. Үе тэнгийнхний дарамтыг илрүүлэх, таслан зогсоох талаар оновчтой арга хэмжээ хэрэгжихгүй байгаа нь үүнийг зохицуулсан дүрэм журам байхгүй байгаатай холбоотой байна. Иймд хорих байгууллагын ажилтан албан хаагчдын зүгээс үе тэнгийнхний дарамтын асуудалд төдийлөн ач холбогдол өгдөггүй ба хорих ял дэлэж буй хүүхдүүдийн дунд үе тэнгийнхний дарамтыг хүлээн зөвшөөрөх, тэвчих хандлага ажиглагдаж байна.

Өнөөдрийн байдлаар хорих анги, тэнд ажиллаж байгаа мэргэжилтнүүд хүүхэд хамгааллын үйлчилгээний хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, цаг үеийнхээ хэрэгцээ шаардлага, нөхцөл байдалтай уялдуулан хөтөлбөр төлөвлөгөөгөө шинэчлэн сайжруулах асуудалд учир дутагдалтай ханддаг, улмаар тухайн чиглэлээр баримтлах тодорхой бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөлт байдаггүй болохыг тус судалгаа харуулж байна.

Эмэгтэйчүүдийн болон хүүхдийн хорих ангийн аль алинд нь хүүхэд хамгааллын үйлчилгээний тогтсон аргачлал, нийтлэг жишиг загвар үгүйлэгдэж байна. Тодруулж хэлбэл, ял эдэлж байгаа хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээний нэгдсэн аргачлал, загвар гэж байхгүй, гагцхүү хорих

байгууллагын дотоод журам, зааварт нийцүүлэн ажиллаж байна.

Хорих байгууллага, мэргэжилтнүүд хүүхдийг хүчирхийлэл дарамтад өртөхөөс урьдчилан сэргийлэн, зөрчил асуудлыг таслан зогсоох үүднээс зарим нэг тусламж үйлчилгээ, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ч холбогдох эрх зүйн зохицуулалт, хөрөнгө төсөв, бусад шалтгааны улмаас хангалттай түвшинд байж чадахгүй байна.

Хүүхдийн хөгжил, хамгаалал, асрамж халамжийн чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, мэргэжилтнүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна. Харин энэхүү харилцаа хамтын ажиллагааг зохицуулж чиглүүлсэн удирдамж зааврын талаарх хорих ангийн мэргэжилтнүүдийн ойлголт зөрүүтэй байна. Иймд байгууллага мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлага цаашилбал үйлчилгээг эхлэх цаг хугацаа, төлөвлөлт, үнэлгээ зэрэг хүүхэд хамгаалын үйлчилгээ, түүнтэй холбогдох бусад харилцааг тусгасан хэм хэмжээ бүхий тодорхой бодлого зохицуулалт шаардлагатай байна.

Хорих байгууллага дахь хүүхэд хамгаалын үйлчилгээнй чанар, үр дүн уялдаа холбоог сайжруулах үүднээс үйлчилгээний үе шат, үйл явц, төрөл хэлбэр, орчин нөхцөл, хариуцах эзэн тэдгээрийн эрх үүрэг гэх мэт дээр дурдсан болон холбогдох бусад асуудлыг зохицуулсан нийтлэг шаардлага хэм хэмжээ бүхий хүүхэд хамгаалын үйлчилгээнд тавигдах стандарт зүй ёсоор шаардагдаж байна.

**Ашигласан эх сурвалж.**


1. УИХ. (2016). *Хүүхдийн эрхийн тухай МУ-ыг хууль.* Төрийн ордон.
2. УИХ. (2016). *Хүүхэд хамгааллын тухай МУ-ын хууль.* Төрийн ордон.
3. УИХ. (2002). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай МУ-ын хууль.* Төрийн ордон.
4. УИХ. (2002). *Эрүүгийн байцаан шийтгэх МУ-ын хууль.* Төрийн ордон.
5. МУ-ын Хууль зүйн сайд (2014). *Хорих ангийн дотоод журам.* А230 тоот тушаалын хавсралт. Улаанбаатар хот
6. НҮБ. (1989). *Хүүхдийн эрхийн конвенц.*
7. ШШГЕГ. *Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар.*
8. ШШГЕГ. *Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын харилцааны хэм хэмжээ.*
9. НҮБ. (1990). Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм
10. НҮБ. (1966). *Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт*
11. НҮБ. (1985). *Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм* /Бээжингийн дүрэм/

12. Гэрэлмаа, С. (2008). *Хүний эрх ба хорих байгууллага.* Амарбаясгалан, Б., Эрдэнэбат, Г., Алтантуяа, Б. (2006). *Хорих, цагдан хорих газарт хийх мониторинг.* Улаанбаатар хот



**СЕРЫХ.А.Б**
И.Кантын нэрэмжит Балтийн Улсын их сургуулийн Сэтгэл судлал-Нийгмийн ухааны сургуулийн эрхлэгч, сэтгэл судлал сурган хүмүүжүүлэх ухааны доктор, профессор



**М.ЦЭНД**
ШШГЕГ-ын ХӨТЯЭГ-ын бүртгэл хяналтын тасгийн дарга, хурандаа

# ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН АЖИЛТНУУДЫН МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ

**Түлхүүр үг:** Хорих байгууллага, нийгмийн ажил, мэргэжлийн үйл ажиллагаа

**Хураангуй:** Энэхүү өгүүллэгт хорих байгууллагад ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааны тодорхой онцлогуудыг дурдах болно.

Ардчилал, хүмүүнлэгийн өөрчлөлт шинэчлэлтийн эрин үед хорих байгууллагын систем мөн адил нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдөж, ялтанд туслалцаа үзүүлэх үр ашигтай тогтолцоо, хорих байгууллагын орчин нөхцөлд тэднийг нөхөн сэргээх технологи бий болгох зайлшгүй шаардлага, хорих байгууллагын үйл ажиллагаанд нийгмийн ажлын үүрэг, ач холбогдлын талаар яригдаж эхэлсэн.

Хорих байгууллагад явагдах нийгмийн ажлын ердийн болон тусгайлсан онцлогийн талаар С.А.Лузгин, М.И.Кузнецов, В.Н.Казанцев нар онцлон тэмдэглэсэн байдаг.

Эдгээр эрдэмтэд зохиол бүтээлүүддээ шоронгийн өвөрмөц заншил, гэмт хэрэгтнүүдийн этгээд харилцаа, ердийн харилцааны хязгаарлагдмал байдал, гэмт хэргийн ертөнцийн гаж үг хэллэгийн тархалт, хүчирхийлэл болон дэглэлтийн хэлбэрүүд, тэдний амьдралын нийгэм-сэтгэхүйн тааламжгүй хэв шинж, хүний нэр төрийг гутаан доромжилж хүчирхийлсний улмаас учрах эсдэлийн өсөлт зэрэг олон онцлог нөхцөл байдлын талаар дурджээ.[1]

Эрдэмтэн М.В. Сорокин олон улсын байгууллагын төлөөлөгчдийн зүгээс шоронд нийгмийн ажил явуулахад учирдаг бэрхшээлүүд, ялтны эрхийг хангаж, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд тулгардаг хүндрэлийн тухай асуудлыг дэлгэн харуулсан.[2]

С.А. Лузгин хорих байгууллагын нийгмийн ажлыг хөгжүүлэх үндсэн зорилгыг "Ялтан болон хорих газраас суллагдагсдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангах, тэдний хүн гэсэн нэр төрийг хүндэтгэх үндсэн шаардлагыг бэхжүүлэх явдал юм" хэмээн тодорхойлжээ.

---

[1] Лузгин С.А. Оросын ялтнуудтай явуулах нийгмийн ажил: Түүхэн уламжлал, өнөө үе, ирээдүй. Рязань. 2006 он

[2] Сорокин М.В. ОХУ-ын гяндангийн ялтнуудад нийгмийн ажил зохион байгуулах онцлог \Владимирын хууль зүйн их сургуулийн сэртгүүл 2008 №3

Хорих газрын амьдралын хүнд нөхцөлийг даван туулахад ялтнуудад туслалцаа үзүүлэх, тэдний хувийн болон нийгмийн идэвхи сонирхол, дахин төлөвших субьектив шалтгааныг өдөөх, тэдэнд тулгарсан бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх, эрх зүйн зөрчил болон гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нийгмийн ажил явуулж байх ёстой.

Хорих байгууллагын нийгмийн ажил нь сурган хүмүүжүүлэх болон сэтгэл заслын ажилтай хослон явагддаг.

Ялтны өөрийгөө өөрчлөх хүсэл тэмүүллийг дэмжих, амьдралын хэвшил дадалд нөлөөлөх, асуудлыг гэмт бус аргаар шийдвэрлэх сонголт хийдэг нөхцөлийг бий болгоход анхаарлаа чиглүүлэх нь зүйтэй.

Хорих байгууллагын нийгмийн ажлын онцлог нь ялтныг засан хүмүүжүүлэх болон дахин ийгэмшүүлэх хөтөлбөр боловсруулах шаардлагатай байдаг.

Ялтнуудад сурган хүмүүжүүлэх болон сэтгэл заслын арга хэмжээ зохиох, нийгмийн ажлын зорилтыг хангахад ялтны ар гэр, гэр бүлийн гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоо чухал юм.

Хорих байгууллагын нийгмийн ажлыг зохион байгуулахад шинжлэх ухааны болон сурган хүмүүжүүлэх аргачлал, эрх зүйн, боловсон хүчний, материал техник хангамжийн гэх мэт олон төрлийн хүчин зүйл хамаарна.[3]

Нийгмийн ажилтан нь дараах үүргийг биелүүлэх ёстой гэж М.Шоу үзжээ. Үүнд:

1. Ялтнуудын зүгээс бусдад учруулж болох эрсдэлийн аюулыг тооцох, ялтны хувийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, бусад ажилтнуудтай хамтран рецедив гэмт хэрэгтнүүдийн учруулж болох эрсдэлийг үнэлэх;
2. Хэтийн төлөвлөгөө боловсруулах;
3. Ялтны гэр бүлийн гишүүд, нийгмийн хүрээнд тэдэнтэй холбоотой бусад хүмүүстэй ажиллах, ялангуяа нийгмийн ажлын чиглэлээр бусад мэргэжилтнүүдийн туслалцааг авах. /Тухайлбал хорих байгууллагын гадна тусгай мэргэжлийн үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтний хэрэгцээ шаардлага гарч болно/.
4. Хорих байгууллагын мэргэжилтнийг тэдэнд зориулсан сургалт явуулдаг байгууллагад давтан сургах;
5. Ялтныг суллахад бэлтгэх үйл ажиллагаа явуулах үед тэдний дунд бүлгээр болон ганцаарчлан ажил зохион байгуулах;
6. Дахин давтан гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг төрөл бүрийн байгууллагын хөтөлбөр, арга хэмжээнд хамрагдах;
7. Хорих байгууллагад явагдаж байгаа нийгмийн ажлын чанар байдалд үнэлэлт өгч, дүн шинжилгээ хийх;[4]

[3] Хорих байгууллагын нийгмийн ажил /Ю.И. Калинины удирдлагаар бүтээв. Рязань 2006. 355 дахь хуудас/

[4] Shaw.M. 1974. Social woqrk in prison. HORS 22. London. HMSO

Хорих байгууллагын нийгмийн ажилтан нь дээр дурдсан үүрэг, зорилгыг биелүүлэхийн тулд мэргэжлийн чухал арга барил, шинж чанаруудыг эзэмшсэн байх ёстой.

Нийгмийн ажилтан нь ялтантай маш нарийн хүнд нөхцөлд ажиллах шаардлагатай болдог. Тухайлбал: Нийгэм-сэтгэл зүйн хувьд эвдэрсэн хүмүүстэй харьцдаг, шоронгийн өвөрмөц заншил, этгээд үг хэллэг, тухайн орчин нөхцлийн стресс, дарамт, эрүүл мэнд, сэтгэл санаанд маш ноцтой аюул учруулж, урьдчилан төсөөлшгүй нөхцөл байдал хэдийд ч гэнэт үүсч болзошгүй, нийгмийн ажилтнуудын хүрэлцээгүйгээс шалтгаалж ажлын өндөр ачаалал ирэх ба хорих байгууллагын нийгмийн ажил нь бусад төрлийн нийгмийн ажлуудаас илүү онцлогтой хэрэгждэг бөгөөд шийдвэрлэж буй асуудлын ач холбогдол, зорилго, зорилт, хүрээлэн буй орчны нөлөө гэх мэт маш олон зүйлээр ялгаатай байдаг.

Хорих байгууллагад ялтнуудтай ажиллах нийгмийн ажилтныг бэлтгэхдээ хорих байгууллагын үйл ажиллагааны стресстэй ачаалалтай нөхцөлийг амжилттай даван туулах, ялтнуудтай ажиллах хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх, тэдний хувийн зан чанар, үйл ажиллагааны өөрчлөлтийг соргогоор мэдэрч, ажилдаа тусган ашиглах мэдлэг, ур чадвар суулгах хэрэгтэй.



**Ч.МӨНХ-ЭРДЭНЭ**
Начальник раздела Охраны безопасности Отдела Исполнения наказания Глав Управление судебно исполнительной системы Монголии
Подполковник



**ГОРКИНА.С.А**
кандидат юридических наук, доцент, заместитель начальника кафедры управления и организации деятельности УИС (Академия ФСИН России),

# ПОНЯТИЕ И ОСНОВНЫЕ ПРИНЦИПЫ ПОСТРОЕНИЯ ОРГАНИЗАЦИОННЫХ СТРУКТУР УПРАВЛЕНИЯ (НА ПРИМЕРЕ ГЛАВНОГО УПРАВЛЕНИЯ ИСПОЛНЕНИЯ СУДЕБНЫХ РЕШЕНИЙ МОНГОЛИИ).

**Аннотация:** в статье рассмотрена организационная структура Главного управления исполнения судебных решений Монголии, основные направления деятельности и функции. Уделяется внимание принципам построения организационных структур управления.

**Abstract:** the article considers the organizational structure of the Main Department of execution of judgments of Mongolia, the main activities and functions. Attention is paid to the principles of construction of organizational management structures.

**Задачи и функции правоохранительных органов, как и любых социальных систем, определяют их функциональную и организационную структуры, т.е. внутреннее смысловое содержание.**

Организационную структуру можно сравнить со скелетом живого организма, с каркасом, с несущей конструкцией, которая связывает воедино все части системы. Она выявляет и устанавливает взаимосвязи и иерархию взаимоотношений сотрудников внутри социальной системы. Уяснение сущности организационной структуры управления в правоохранительных органах целесообразно начать с понятий «структура» и «организационная структура». Структурность является условием существования любых систем – биологических, технических, социальных и др. Понятия «система» и «структура» соотносятся как целое и части, т.е. структура есть составная часть системы.

В научной литературе структура определяется как «строение и внутренняя форма организации системы, выступающая как единство устойчивых взаимосвязей между ее элементами» [1]. Элементами организационной структуры выступают должности и связи между

[1] См: Философский словарь. – М.,1975.С. 395.

ними. Под должностями понимаются совокупности прав и ответственности, требований к знаниям, опыту и квалификации работников правоохранительных органов.

Связи организационной структуры можно подразделить на три основных вида:

1) организационно-предметные, возникающие между работниками по поводу использования ими различных средств;

2) организационно-функциональные взаимосвязи между работниками по степени их участия в совместном профессиональном труде;

3) организационно-административные, обусловливаемые субординацией работников, т.е. связи руководства и подчинения;

Таким образом, организационную структуру социальной системы можно определить как совокупность должностей, объединенных с помощью организационных связей[2].

Для правильного построения организационных структур управления необходимо знать и учитывать факторы, обусловливающие наличие в данных структурах тех или иных элементов, связей. Различаются факторы, влияющие на характер организационной структуры непосредственно и косвенно. К первым относятся цели, задачи, функции, принципы и методы управления. Ко вторым–кадры, техника, технология управления, организация труда[3].

В зависимости от цели деятельности правоохранительных органов, ради которой создается система, определяется общая направленность организационной структуры управления. Одна и та же цель может быть достигнута путем выполнения различных задач и функций. Это определяется условиями, в которых приходится функционировать системе, объемом ее работы. Таким образом, в зависимости от того, какие функции данной системы наиболее важны или требуют наибольшего внимания, появляются те или иные особенности и в ее организационной структуре.

На характер построения организационной структуры управления влияют принципы и методы управления. В условиях жесткого централизма, использования исключительно административно-командных методов воздействия в вышестоящих органах концентрируются службы, решающие все вопросы управления, а нижестоящие, по существу, лишаются права участия в его процессе, т.е. самостоятельности. При реализации принципа демократизма предусматривающего широкое применение экономических, социально-психологических, педагогических методов, значительная часть объема функций управления возлагается на

[2] См.: Теория управления в сфере правоохранительной деятельности. Учеб. /Под ред. д.ю.н., профессора В.Д. Малкова. М., 1990. С. 139-140.

[3] См.: Там же. С. 145-146.

его нижние структуры. Аппарат управления при этом существенно сокращается, в подчиненных органах создаются совещательные, коллегиальные звенья, с помощью которых коллективы активно участвуют в подготовке и принятии управленческих решений.

Опосредовано влияют на формирование организационной структуры управления используемые технология, организация труда и качественные характеристики работников аппарата. Так, используемая в процессе управления техника во многом обусловливает структуру подразделений, занимающихся получением, обработкой, учетом и хранением информации. В частности, применение АСУ (автоматизированных систем управления) неизбежно приводит к образованию новых служб, связанных с программным обеспечением ЭВМ, с подготовкой и решением на математической основе управленческих задач.

Многосторонность содержания структур управления предопределяет множественность принципов их формирования. В разных литературных источниках даются различные перечни принципов формирования структуры управления. Наиболее полный их перечень синтезирован на основе исследований М. Разу, Ю. Якутина, А.Г. Поршнева, З.П. Румянцевой, Н.А. Саломатина. Это:

1) принцип единства распорядительства и персональной ответственности исключает двойственность подчинения и возможность получения противоречивых указаний;

2) соответствие звеньев управления функциям управления;

3) принцип четкого функционального разграничения – каждое звено должно иметь четко очерченные функции, не затрагивающие функций других подразделений;

4) принцип установления точных границ между линейным и функциональным руководством. Линейное руководство – управление производством, функциональное – помощь линейному руководству;

5) принцип распространенности контроля, т.е. правильное определение нормы управляемости;

6) принцип минимизации ступеней управления: чем меньше ступеней в структуре, тем более гибко и оперативно будут приниматься меры на случай любых осложнений, а следовательно, эффективнее будет работа органа в целом;

7) сосредоточение на каждой ступени всех необходимых функций управления;

8) принцип соответствия прав, обязанностей и ответственности каждого звена управления и должностного лица;

9) принцип рационального сочетания централизации и децентрализации выполнения функций. При децентрализации руководства повышается активность низовых звеньев управления. При централизации создаются условия

для эффективного применения современных средств управленческой техники, специализации подразделений и исполнителей, однако при этом может пострадать оперативность принятия и реализации решений, значительно понизятся активность и ответственность нижестоящих звеньев;

10) принцип гибкости, в том числе желание модифицировать себя, так как система сопротивляется изменениям, касающимся способа ее организации и экономичности – реагировать на изменения внешней и внутренней среды с наименьшими затратами.

Наряду с принципами используются определенные методы проектирования организационных структур управления, которые являются также методами их совершенствования. В литературе встречаются различные мнения по вопросу методов формирования организационных структур[4].

По нашему мнению, целесообразной является классификация методов, предложенная профессором В.Н. Парахиной, включающая[5]:

1) системный подход и как его логическое продолжение – синтез элементов организационной структуры, структуризация целей, программно-целевой;

2) нормативный метод, составляющими которого являются методы функционального моделирования и аналогий;

3) метод организационного моделирования;

4) метод рационализации технологии организационных процессов;

5) метод организационных изменений системы управления;

6) экспертный метод;

Цель организационной структуры заключается в успешном решении стоящих перед организацией задач. В связи с этим проектирование структуры должно основываться на стратегии организации, учитывать условия, в которых она находится (характеристики внешней среды, технологии организации, ее размер и др.). Далее рассмотрим структурное построение и основные задачи Главногоуправленияисполнениясуде бныхрешений Монголии.

Принцип разработки структурной организации. Структурная организация Главного управления исполнения судебных решений разработана в соответствии с принципами:

- Приоритета закона;
- Уважения прав и свобод человека;
- Обеспечения справедливостии равно правия;
- Система рабочей структуры, организационная структура Главного управления исполнения судебных

[4] См., например: Франчук В.И. Основы построения организационных систем. – М.: Экономика, 1991; Старобинский Э. Мотивация (Размышления на заданную тему) //Управление персоналом. – 1999. № 50 и др.

[5] См.: Теория управления в сфере правоохранительной деятельности. Учеб. /Под ред. д.ю.н., профессора В.Д. Малкова. М., 1990. С. 247-248.

решений должны синхронизированы со стратегическими задачами деятельности учреждения;

- Точное разграничение полномочий;
- Доверительность;
- Ориентированность видимых услуги стратегического управления;
- Простая в отношении понимания структура;
- Сбалансированность границ контроля;
- Конкретность и эффективность проводимых действий;
- Политкорректность.

В основную обязанность руководителя Главного управления исполнения судебных решений вменяется руководство действиям и принудительного характера при исполнении решений судебных органов в соответствии с судебными постановлениями, решениями о наказании в виде лишения свободы, о принятии иных от лишения свободы мер по уголовным делами по взысканию имущественных требований, средств всчёт погашения ущерба, средств по собий погражданским делам, покоторымотимени монгольского государства вынесены решения, а также по заверенным в судебном порядке решениям иных организаций, обеспечение профессионально-методологическим руководством, контроля.

Управление ежедневно обеспечивает профессиональное руководство собственными подразделениями, отделами для оценкии повышения эффективности работ организации мер реализации задач законо положений Монголии, международных договорови конвенций по правам человека лиц, несущих уголовную ответственность, исполнение судебных решений об аресте подозреваемых, заключении обвиняемых подстражу, также руководит на должном профессиональном уровне исполнение судебных постановлений об аресте, заключении подстражу, мест азаключения, регулярную службу специальных подразделений полицейских органов, исполняющих некоторые виды судебных постановлений по уголовным делам, обеспечивает качественную организацию курсов тренировок, обучений совместно с отечественнымии иностранными специальными службами.

*Основные функции:*

- Профессиональное руководство, контроль работы охранной части в местах заключений при осуществлении мер по аресту подозреваемых, заключении подстражу, содержании в заключении, обвиняемых лиц;
- Организация согласно инструкциям, контроль действий по вооруженному конвоированию, перевозке осуждённых;
- Выявление совершенных прежде, так же происшедших в местах заключения преступлений осуждённых и заключённых;
- Регулярное проведение розыскных мер повыявлению сбежавших, также не задержанных сбежавших в предыдущиего

дыосуждённых, уделяя особоевниманиена устранение факторо в формирования условий, способствующих побег у заключённых;

- Организация исполнительной деятельностии сотрудничество с иными исполнительными службами в соответствии с обоснованиями и в рамках проведения данной деятельности, предусмотренной в Законе Монголии “Об исполнительной деятельности”
- Профессиональное руководство, инструктаж социальных работников, специалистов-психолого в мест заключений, исполнительных служб;
- Вывести на новый уровень с учётом тенденций развития со временной социальной инфраструктуры меры по социальной адаптации, проводить научно-исследовательские работы в направлении социальной адаптации, расширение связей, осуществление совместных проектов и программ с профильными государственными, не государственными и международными организациями;
- Подконтрольное осуществление мер, связанных с профилированным обучением, то есть профессиональной ориентацией, лиц, от бывающих наказания в местах заключения, исполнительных службах и отделах, с их социальной адаптацией, с оказанием таким лицам психологической помощи, способствуя мобилизации внутренних ресурсов;
- Профессиональное руководство и контроль службы лечебных учреждений, под ведомственных ГУИСР;
- Вести сводный статистический учёт данных по мерам исполнений решений судей об аресте, заключении под стражу подозреваемых, осуждённых лиц, а также судебных постановлений овменении меры наказания в виде ареста, заключения;
- Вести сводный статистический учёт данных по исполнительной деятельности, связанной с исполнением полицейскими органами не которых видов судебных постановлений по уголовным делам.

В функции Управления исполнения решений входят: реализация целей и задач законодательства Монголии, международных договоров и конвенций по правам человека, связанных с процессом исполнения судебных решений по делам гражданского и административного характера, по вышения результати вности данных мер; обеспечение профессиональным руководством и оценка деятельности аймачных, столичныхслужб исполнений; ведение на основе сбора месячных, квартальных и годовых данных отпод

Ведомственных служб сводного учёта судебных постановлений об аннулировании прав на определённые виды должностей, виды деятельности, о мерах наказаний, в том числе принудительного характера, с составлением единого в масштабах

страны сводного статистического учёта.

*Основные функции:*

- Контроль и профессиональное руководство процесса реализации причастных законодательств, положений и инструкций об исполнительной деятельности;
- Ведение единого контрольного статистического учёта граждан без допуска к пересечению государственной границы, избегающих от уплаты соответствующих платежей;
- Проверка заявлений по исполнительным мерам, проводимы маймачными, столичными исполнительными службами, службами по погашению задолженностей банков, сберегательно-заёмных кооперативов, принятие мер по устранению выявленных нарушений;
- Для оптимизации исполнительной деятельности организация в рамках страны единых мер и курсов обучения составов исполнителей, старших исполнителей;
- Изучение опыта других стран, проводящих подобную политику исполнительной деятельности;
- Организация мер по возмещению ущербов, понесённых гражданам и в результате некоторых типов преступлений;
- Организация по возмещению ущербов, возникших в следствие неправильных действий государственных учреждений и государственных служащих;
- Полностью отвечать перед начальником ГУИСР за осуществление в принудительном порядке судебного постановления, по которому вменен о иные от заключения виды наказания, планирование указанных мер и их исполнение;
- Обеспечение профессиональным, профильным руководством исполнительной деятельности, осуществляемой иными учреждениями, по некоторым видам судебных решений;
- Выполнение судебных решений по принудительному лечению, принудительному труду в административном режимелиц, подверженных алкоголизму, наркомании.

Структура есть совокупность взаимосвязанных элементов. Эффективность функционирования каждого правоохранительного органа зависит от согласованности действий его подсистем, т.е. служб и подразделений, соблюдения ими общих принципов всей системы. Связующим и координирующим звеном системы выступает ее организационная подсистема. Именно с ее помощью достигается объединение всех компонентов, обеспечивается целостность системы. Структура данной подсистемы и понимается как организационная структура.



**НЕШАТАЕВ В.Н**
преподаватель кафедры криминологии, психологии и педагогики Омской академии МВД России, капитан полиции

# ЭТАПЫ РАЗВИТИЯ УЧЕНИЯ О КВАЛИФИКАЦИИ ПРЕСТУПЛЕНИЙ

В статье проводится анализ развития учения о квалификации преступлений в науке российского уголовного права. Подводится итог о том, что учение о квалификации в своем развитии прошло три этапа: первый – конец 19 века – середина 20 века, второй – 1950-ые – 1990-ые годы, третий – 1990-ые годы – по настоящее время.

***Ключевые слова:*** квалификация преступлений, учение, этапы, состав преступления, общие признаки преступления.

Первое упоминание о квалификационном процессе встречается в работах известного русского юриста, криминалиста и государственного деятеля – Н. С. Таганцева. Термин «квалификация» он не употреблял, но говорил о его сущности: «применение закона к конкретным жизненным случаям предполагает выяснение объема и существенных признаков данного запрета, а также выяснение наличности этих существенных признаков в деянии, подлежащем судебному разбирательству, так как только при установлении тождества между обеими группами признаков возможно применение к обвиняемому тех последствий, которые должны следовать за неповиновением велениям закона»[1].

Правила и порядок установления наличия требуемых нормами закона признаков в совершенном деянии полностью относил к процессуальному праву, объясняя это тем, что данное установление может быть выполнено при каждом отдельном судебном разбирательстве. По его мнению, установление признаков состава преступления в совершенном деянии, в большинстве случаев, совершается еще до судебного разбирательства, так как суд, состоящий из научно подготовленных юристов, вносит с собой в процесс уже готовые, твердо установленные представления о характерных признаках отдельных преступлений. Разъяснение содержания и смысла норм закона, подведение его для применения к отдельным случаям называл толкованием закона. Задачи толкования уголовного закона

[1] Таганцев Н. С. Русское уголовное право. Часть общая. Том I. Тула. Автограф, 2001. С. 148.

сводил к установлению той нормы, посягательство на которую хотел воспретить законодатель и к определению объема воспрещенного посягательства или к установлению признаков и условий преступности и наказуемости воспрещенного законом посягательства[2].

Следует указать, что хотя в этот период в правоприменительной сфере термин «квалификация» тоже не употреблялся, но обозначался иными словосочетаниями. Так, например, выдающийся юрист-правовед, адвокат В. Д. Спасович при рассмотрении уголовных дел в суде, защищая своих клиентов, употреблял такие выражения, как: «факт, который вменяется подсудимому», «направлено обвинение в том, что … », «может быть подведен под статьи Уложения о наказаниях»[3].

Возникновение указанных первоначальных идей о квалификации именно в этом период, на наш взгляд, необходимо связать с тем, что к данному времени наука российского уголовного права достигла того уровня, при котором в основе регулирования уголовно-правовых отношений стала выдвигаться идея состава преступления, достаточно разработанная ведущими представителя доктрины уголовного права – Н. С. Таганцевым[4], В. Д. Спасовичем[5], А. Ф. Кистяковским[6] и т. д. Но, необходимо сказать, что уже в то время в действовавших уголовных законах законодатель раскрывал понятие преступления, указывая в нем его существенные признаки, которые и должны были быть, с нашей точки зрения, юридическим основанием квалификации.

Так, ст. 4 Уложения о наказаниях уголовных и исправительных 1845 г. предусматривала, что: «Преступлением или проступком признается как само противозаконное деяние, так и неисполнение того, что под страхом наказания уголовного или исправительного законом предписано». Законодатель уже в этот период определял в качестве общих признаков преступления противозаконность

[2] Таганцев Н. С. Русское уголовное право. Часть общая. Том I. Тула. Автограф, 2001. С. 154.

[3] Спасович В. Д. Избранные труды и речи / сост. И. В. Потапчук. Тула: Автограф, 2000. С. 168-314.

[4] Таганцев Н. С. Русское уголовное право. Часть общая. Том I. Тула. Автограф, 2001. С. 307-530.

[5] Спасович В. Д. Учебник уголовного права. Т. 1. СПб., Тип. И. Огризко. 1863. С. 89-153.

[6] Кистяковскій А. Ф. Элементарный учебникъ Общаго уголовнаго права съ подробным изложением Началъ Русскаго Уголовнаго Законодательства. Часть Общая. Второе исправленное и значительно дополненное изданіе. Киев. Тип. И. и А. Давиденко. 1882. С. 294-580.

(противоправность или запрещенность) и наказуемость.

Представляет важность и содержание статьи 97 указанного Уложения, согласно которой: «Наказание за преступление … может быть определено судом тогда только … когда, во-первых, содеяние преступления … или существование преступного умысла несомненно доказаны; во-вторых, когда … содеянное или умышленное должно быть вменено подсудимому или подсудимым в вину»[7]. Данная норма говорит о том, что для назначения уголовного наказания содеянное должно быть доказано и вина лица в совершенном должна быть установлена. Это указывает об обязательном установлении при квалификации и назначении наказания такого уголовно-правового признака, как виновность (установленная вина), который в настоящее время является законодательно закрепленным общим признаком преступления.

Вплоть до середины 20 века в науке отечественного уголовного права не имелось каких-либо положений, идей, теорий о квалификации преступлений. В уголовных законах РСФСР законодателем термин «квалификация» не употреблялся, но имелось несколько предусмотренных правил относительно уголовно-правовой оценки. Так, согласно ст. 14 УК РСФСР 1922 г.: «…покушение же, не доведенное до конца по собственному побуждению покушавшегося, карается как то преступление, которое фактически им совершено» [8]. Ст. 29 данного уголовного закона – «Когда в совершенном обвиняемом деянии содержатся признаки преступлений, предусмотренных разными статьями Кодекса, суд определяет наказание по статье, устанавливающей наибольшую наказуемость»[9].

На основании ст. 19 УК РСФСР 1926 г. «Покушение на какое-либо преступление, а равно и приготовительные к преступлению действия, выражающиеся в приискании или приспособлении орудий, средств и создании условий преступления, преследуются так же, как совершенное преступление ... В случаях, если преступление не было совершено по добровольному отказу лица, намеревавшегося совершить это преступление, от его совершения, суд устанавливает соответствующую меру социальной защиты за те

[7] Уложеніе о наказаніяхъ уголовныхъ и исправительныхъ 1845 г. Типографія Втораго Собственной Его Императорскаго Величества Канцеляріи. Санкт-Петербургъ, 1885. С. 31.

[8] Уголовный кодекс РСФСР 1922 года. Собрание узаконений и распоряжений Рабочего и Крестьянского Правительства, издаваемое Народным Комиссариатом юстиции, N 20-21, 4 июня 1922 года.

[9] Там же.

действия, которые фактически были совершены покушавшимся или приготовлявшимся»[10].

Отсутствие в этот период каких-либо положений, касающихся квалификации преступлений, можно объяснить такими негативными событиями, явлениями и процессами, происходившими в России, как:

– Русско-японская война 1904-1905 годов;

– Революция 1905-1907 годов (первая русская революция);

– Февральская революция 1917 года;

– Октябрьская революция 1917 года;

– Первая мировая война 1914-1918 годов;

– Советско-финская война (советско-финляндская война) 1939-1940 годов;

– Великая Отечественная война 1941-1945 годов;

– Советско-японская война 1945 года (август-сентябрь);

– Массовые репрессии в период нахождения у власти И.Ф. Сталина.

Все вышеуказанные обстоятельства вызвали застой научной сферы. В качестве исключения необходимо упомянуть только лишь военные науки, развитие которых было обусловлено пятью войнами, и, прежде всего, Первой мировой и Великой Отечественной, когда все силы и средства, в том числе научные, были направлены на достижение победы. Например, с началом Великой Отечественной войны «в кратчайший срок Академия наук СССР перестроила работу всех своих институтов и лабораторий на обслуживание нужд фронта и тыла» [11]. Очевидно, что в такой обстановке благоприятных условий для развития науки уголовного права не было, соответственно, в доктрине не возникали и положения, касающиеся квалификации преступлений.

Существенный урон науке в это период был нанесен и репрессиями, под которые попадали многие представители научного мира.

Только лишь к 1944-1945 годам государством стало возможным принятие мер для развития науки. «В сложных условиях периода войны проходил перелом в организации научной деятельности, развитии народного образования … Развернулись реэвакуация и восстановление учреждений науки, ускорилось интенсивное развитие науки, связанное с развитием экономики, высшей и средней школы, восстановлением научного

[10] Уголовный кодекс РСФСР 1926 года. «СУ РСФСР», 1926, N 80, ст. 600.

[11] Ксенофонтов А. В. Роль науки Советского Союза в годы Великой Отечественной войны // Политика. Обществознание. Искусство. Социология. Культура. 2015. № 2. С. 8.

потенциала страны, укреплением материально-технической базы науки и культуры, понесших тяжелые потери» [12]. Благоприятные условия для восстановления и развития научной сферы появились только после 1945 года.

Поэтому, первый этап развития учения о квалификации необходимо отнести к концу 19 – середине 20 веков. Он связан с возникновением исходных, первоначальных представлений о квалификации, наличием нескольких правил уголовно-правовой оценки в действовавших уголовных законах и отсутствием каких-либо иных положений.

Второй этап развития учения о квалификации можно определить временными рамками с 1950-ых до 1990-ых годов.

В 1948 г. впервые в истории отечественного уголовного права дано понятие квалификации. Квалификация преступного деяния определялась как установление соответствия данного конкретного деяния признакам, предусмотренным в уголовном законе, того или иного состава преступления[13].

Позднее квалификация была определена как установление и юридическое закрепление точного соответствия между признаками совершенного деяния и признаками состава преступления, предусмотренного уголовно-правовой нормой [14]. Впоследствии данное определение в отечественной науке уголовного права стало «классическим», раскрывающим квалификацию как процесс установления признаков того или иного преступления в действиях лица и как результат этой деятельности – официальное признание и закрепление в соответствующем процессуальном документе.

В этот период были сформулированы принципы, правила и приемы квалификации преступлений, рассмотрены общие признаки, лежащие в основе разграничения отдельных видов преступлений, проведен анализ судебной и следственной практики по применению уголовного закона, проанализированы условия, соблюдение которых необходимо для правильной квалификации. Уголовно-правовая оценка отнесена к завершающей стадии правоприменения, которая «ближе стоит к последней стадии процесса

[12] Македонская В. А., Каримова Л. Р. Восстановление системы образования и науки в освобожденных районах РСФСР в годы Великой Отечественной Войны // Грамота. 2013. № 5. С. 124.

[13] Герцензон А. А. Уголовное право. Общая часть. Учебное пособие для слушателей ВЮА. М.: Издание РИО ВЮА, 1948. С. 440.

[14] Кудрявцев В. Н. Общая теория квалификации преступлений. М.: Юридическая литература, 1972. С. 8.

применения нормы права: принятию решения и изданию акта, закрепляющего это решение»[15].

Юридическим основанием квалификации и единственным основанием уголовной ответственности признавался состав преступления. Выделялось пять основных этапов уголовно-правовой оценки, непосредственно связанных со стадиями уголовного процесса.

В это время получили значительное развитие исследования в области логики, кибернетики и психологии, имеющие непосредственное отношение к вопросам применения закона [16]. Анализировались психологические особенности деятельности следователя при квалификации преступлений. Использовались данные математической логики и программирования, так как в 1970-ые годы начали ставиться вопросы о создании автоматизированных справочно-информационных систем в области права[17].

Внимание уделялось и предпосылкам правильной квалификации, к которым относили, например, установление всех фактов и обстоятельств, необходимых для вывода о юридической оценке содеянного и достаточных для ее мотивировки, их доказанность[18].

Отличительной чертой этого периода является проведение исследований по квалификации преступлений применительно к работе соответствующих ведомств и подразделений правоохранительной системы, например, к деятельности органов внутренних дел[19].

Интересной предстает идея данного времени, носящая прикладной характер, суть которой заключается в том, что процесс квалификации состоит из трех этапов. Первый – выявление наиболее общих признаков деяния, то есть установление типа правоотношения. На этой стадии лицо, осуществляющее правоприменительную деятельность, решает вопрос о том, имеются ли в данном конкретном случае признаки преступления или же это деяние следует квалифицировать как проступок. В случае обнаружения уголовно-правового отношения – наличия в деянии виновного

[15] Кудрявцев В. Н. Теоретические основы квалификации преступлений. М.: Государственное издательство юридической литературы, 1963. С. 15.

[16] Кудрявцев В. Н. Общая теория квалификации преступлений. М.: Юридическая литература, 1972. С. 4.

[17] Наумов А. В., Новиченко А. С. Законы логики при квалификации преступлений. М.: Юридическая литература, 1978. С. 4.

[18] Тарарухин С. А. Теория и практика квалификации преступлений. Киев. Типография МВД УССР, 1978. С. 44.

[19] Миренский Б. А. Использование оценочных категорий органами внутренних дел при квалификации преступлений: учебное пособие. Ташкент. «Матбуот», 1979. С. 8.

признаков преступления – процесс квалификации вступает во второй – выявление родовых признаков преступного деяния, то есть определение, какой главой уголовного кодекса охватывается рассматриваемое преступление. Третий этап – выявление и сопоставление видовых признаков преступления в пределах какой-либо избранной статьи конкретной главы УК[20].

Важность и практическая значимость данной идеи проявляется в том, что ее автор говорит о необходимости использования при квалификации общих признаков деяний. Относительно преступления, таковыми, например, согласно нормам УК РСФСР 1960 г., являлись общественная опасность, предусмотренность уголовным законом (запрещенность или противоправность), виновность и наказуемость. Так, согласно ч. 1 ст. 3 данного уголовного закона «Уголовной ответственности и наказанию подлежит только лицо, виновное в совершении преступления, то есть умышленно или по неосторожности совершившее предусмотренное уголовным законом общественно опасное деяние» [21] . А также на основании ч. 1 ст. 7 «Преступлением признается предусмотренное уголовным законом общественно опасное деяние … предусмотренное уголовным законом»[22]. То есть в этот период в науке уголовного права уже возникла идея об использовании при уголовно-правовой оценке общих признаков преступления, обоснованность которой подтверждалась их наличием на законодательном уровне.

Таким образом, главной особенностью данного этапа является появление в науке российского уголовного права первого определения квалификации, создание единого, системного учения – общей теории квалификации преступлений, его дальнейшее развитие, а также возникновение идеи об использовании при уголовно-правовой оценке общих признаков деяния. Однако, в этот период в учении об уголовно-правовой оценке господствовало положение о составе преступления как единственном юридическом основании квалификации преступлений.

Третий этап развития учения о квалификации можно определить временными рамками с 1990 годов –

[20] Куринов Б. А. Научные основы квалификации преступлений. М.: Издательство Московского университета, 1984. С. 56.

[21] Уголовный кодекс РСФСР 1960 г. Ведомости ВС РСФСР, 1960. № 40. Ст. 591.

[22] Уголовный кодекс РСФСР 1960 г. Ведомости ВС РСФСР, 1960. № 40. Ст. 591.

по настоящее время. В развитии учения об уголовно-правовой оценке на этом этапе необходимо выделить следующие направления.

Первое – исследование проблем, касающихся общих вопросов квалификации. Здесь важно отметить разработку и совершенствование, например, теоретических основ уголовно-правовой оценки [23], правил квалификации [24] и ошибок [25], квалификации преступлений по субъективным признакам [26], квалификации непреступных и правомерных деяний[27] и т. д.

Второе связано с исследованием проблем квалификации отдельных видов преступлений, например, убийств[28], хищений [29], хулиганства [30], преступлений, совершаемых в финансово-экономической сфере [31], против жизни и здоровья, половой неприкосновенности и половой свободы личности, общественной безопасности и общественного порядка [32], должностных преступлений[33] и т. д.

Важно отметить то, что на данном этапе в доктрине уголовного права больше внимание уделяется

[23] Корнеева А. В. Теоретические основы квалификации преступлений: учебное пособие. Под редакцией А. И. Рарога. М.: ТК Велби. Издательство Проспект, 2007. 176 С.; Толкаченко А. А. Теоретические основы квалификации преступлений. Учебное пособие для студентов вузов, обучающихся по специальности 021100 «Юриспруденция». Фонд содействия правоохранительным органам «Закон и право». М.: ЮНИТИ-ДАНА, Закон и право. 2004. 128 С.

[24] Гаухман Л. Д. Квалификация преступлений: закон, теория, практика. М.: АО «Центр ЮрИнфР», 2007. 457 С.; Шумихин В. Г. Нормативные правила квалификации преступлений. Пермь: Издательство Пермского университета, 2004. 116 С.

[25] Кузнецова Н. Ф. Проблемы квалификации преступлений: лекции по спецкурсу «Основы квалификации преступлений». М.: Издательский Дом «Городец», 2007. 336 С.

[26] Рарог А. И. Квалификация преступлений по субъективным признакам. Санкт-Петербург: Издательство «Юридический центр пресс», 2002. 304 С.

[27] Сабитов Р. А. Теория и практика уголовно-правовой квалификации: научно-практическое пособие. М.: Юрлитинформ, 2013. 592 С.

[28] Краев Д. Ю. Убийство, сопряженное с иными преступлениями: законодательная регламентация и квалификация: дис. … канд. юрид. наук: 12.00.08. / Краев Денис Юрьевич. Санкт-Петербург, 2009.

[29] Векленко В. В. Квалификация хищений: монография. Омская академия МВД России. Омск, 2001. 256 С.

[30] Есина Л. А. Квалификация хулиганства и иных преступлений, совершенных из хулиганских побуждений: уголовно-правовые и криминологические аспекты: дис. … канд. юрид. наук: 12.00.08. / Есина Лариса Александровна. Челябинск, 2011.

[31] Нудель С. Л. Квалификация преступлений, посягающих на финансовые отношения: научно-практическое пособие. М.: ФГКУ «ВНИИ МВД России», 2013. 168 С.

[32] Кадников Н. Г. Квалификация преступлений и вопросы судебного толкования: теория и практика. Учебное пособие. М.: Норма, 2003. 144 С.

[33] Борков В. Н. Преступления против осуществления государственных функций, совершаемые должностными лицами: дис. … докт. юрид. наук: 12.00.08 / Борков Виктор Николаевич. Омск, 2015.

исследованиям проблем квалификации отдельных преступлений (видов, групп), нежели общим вопросам уголовно-правовой оценки. Это связано с тем, что практически все общие положения квалификации были разработаны еще в советский период – с созданием и дальнейшим совершенствованием общей теории квалификации. Однако с принятием в 1996 г. нового Уголовного кодекса возникла объективная потребность в изучении вопросов квалификации отдельных категорий преступлений, так как его Особенная часть существенно изменилась по сравнению с предыдущим уголовным законом.

При этом, следует отметить, что оба направления основой изучения проблем квалификации и совершенствования положений уголовно-правовой оценки имеют основу в виде ранее созданной общей теории квалификации, в которой роль юридической основы уголовно-правовой оценки отводится составу преступления.

Однако анализ правоприменительной деятельности ставит под сомнение основные положения общей теории квалификации преступлений и не позволяет с ними согласиться. Так, 92% опрошенных сотрудников правоприменительных органов (следователей и дознавателей) указало, что при квалификации они используют общие признаки преступления. Изучение уголовных дел по наиболее распространенным категориям преступлений, рассмотренным в общем порядке судебного разбирательства различными судами РФ показало, что в 93, 4% приговоров суды ссылаются на общие признаки преступления без использования состава. В 6, 6% приговоров имеются указания как на состав преступления, так и на общие признаки преступления. Поэтому, мнение правоприменителей и анализ решений судов доказывают, что уголовно-правовая оценка осуществляется именно на основании общих признаков преступления.

В связи с этим, на наш взгляд, в развитии учения об уголовно-правовой оценке необходимо осуществить переход от использования состава преступления, являющегося научной категорией, к общим признакам преступления, имеющим не только законодательное закрепление (ч. 1 ст. 14 УК РФ), но и применяющимся в практической деятельности. Данный переход будет отправной точкой следующего этапа в развитии учения о квалификации преступлений.

Таким образом, в развитии учения о квалификации преступлений необходимо выделить

3 этапа. Первый относится к концу 19 – середине 20 веков и связан с возникновением в науке российского уголовного права первоначальных представлений, идей об уголовно-правовой оценке и отсутствием каких-либо положений, касающихся квалификации. Застой научной сферы этого периода объясняется имевшими место быть такими негативными социальными явлениями как: три революции, массовые репрессии, пять войн, в числе которых Первая мировая и Великая Отечественная.

Второй этап определяется 1950-ыми – 1990-ыми годами. С возникновением благоприятных условий для восстановления и развития научной сферы в доктрине отечественного уголовного права было разработано понятие квалификации преступлений, создано системное учение – общая теория квалификации преступлений. Особенностью этапа является также выдвижение идеи прикладного характера – выявлении при квалификации общих признаков деяния, то есть установлении типа правоотношения. Однако преобладающей являлась идея состава преступления как единственного юридического основания квалификации.

Третий этап определяется временными рамками с 1990-ых годов – по настоящее время. Его отличительная особенность проявляется в наличии двух основных направлений развития учения о квалификации: исследование общих вопросов уголовно-правовой оценки, а также проблем квалификации отдельных преступлений (видов, групп). При этом большее развитие имеет второе направление. На данном этапе в квалификации по-прежнему главенствующая роль отводится составу преступления.

Анализ правоприменительной деятельности относительно уголовно-правовой оценки позволяет прийти к выводу, что следующий этап в развитии учения о квалификации преступлений должен быть связан с отказом от использования состава преступления и переходом к применению общих признаков преступления.



**Б.МӨНХБААТАР**
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, ахмад

# ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭГЧИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ

**Хураангуй:** Өнөөгийн нийгэмд тулгамдаж буй асуудлуудын нэг болох гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчийн сэтгэл зүйн нийтлэг илрэл, үр дагаврын талаар онолын үзэл хандлагын талаар тусгасан болно.

**Түлхүүр үг:** Гэр бүлийн хүчирхийлэл, хүчирхийлэл үйлдэгч, зан үйл, харилцаа, нөлөөлөл, хүчин зүйл

Ямар үйлдлийг хүчирхийлэл гэж тооцох нь ард түмний соёл, уламжлалаас хамааран янз бүр байдаг. Манай улсад гэрийн ажил, үр хүүхдээ асрах, хүмүүжүүлэх нь зөвхөн гэр бүлийн эмэгтэй гишүүний үүрэг гэсэн хэвшмэл ойлголт давамгайлсан хэвээр байгаагийн зэрэгцээ ядуурал, ажилгүйдэл жендерийн [1] тэгш бус байдал, Монголын улсын нийгэм дэх эцгийн эрхт ёс гүн шингэсэн, эрэгтэй хүнд давуу байдал олгож, эмэгтэй хүнийг хамааралд байлгадаг дэвшилтэт бус соёл, уламжлал, зан заншлаас үүдэлтэй хэвшмэл ойлголт, дорд үзэх хандлага, эрх мэдэл хяналтаа тогтоох гэсэн үзэл, зан үйл нь тэгш бус байдал зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийн улмаас гэр бүлийн хүчирхийлэл, тэр дундаа эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, хил дамнасан хүний наймаанд өртөх, гэр бүл салах явдал түгээмэл болсоор байна.

Энэ нь нэг талаас хувь хүний нийгэмшлийн үйл явцтай[2] холбоотой юм. Орчин үеийн нийгэмшлийн механизм, зүй тогтлыг тайлбарладаг "Нийгмийн даган сургалтын онол"-оор бол хүний зан үйл нь түүний нийгмийн янз бүрийн нөхцөлд бусад хүмүүстэй харилцах харилцаа, харилцан үйлчлэл, хамтын ажиллагаа, бусдыг даган дуурайх,

[1] Жендер гэдэг үгийг "хүйс" гэсэн үгтэй хольж хэрэглэх явдал түгээмэл хэдий ч агуулгын хувьд энэ хоёр үг зарчмын ялгаатай. Хүйс гэдэг нь биологийн хүчин зүйлс дээр тулгуурлан эрэгтэй эмэгтэй хүний ялгаатай байдлыг тодорхойлдог бол, жендер нь нийгмийн соёлын хүчин зүйлсэд тулгуурлан эрэгтэй ба эмэгтэй хүний ялгаатай байдлыг тодорхойлдог. Тиймээс хүйсийг биологийн ойлголт, жендерийг нийгэм соёлын ойлголт гэж нэрлэдэг (ХЭҮК, С.Баасанбат, Fillingim, ed8 2000)

[2] Нийгэмшил гэдэг нь хувь хүний талаас хүн төрөлхтний соёл иргэншил, нийгмийн амьдралын туршлагыг эзэмших олон талтай үйл ажиллагаа, биологийн амьтныг нийгмийн, хувь хүнийг бие хүн болгон хувиргах үйл явц юм. Хувь хүний нийгэмшлийн үйл явцыг нийгмийн туршлагыг эзэмших, шинээр бий болгох явцад өөрөө бие хүний хувьд төлөвшиж амьдрал үйл ажиллагаандаа хэрэгтэй мэдлэг чадвар зан үйлийн хэвшил, үнэт зүйлс гэх зэрэг сэтгэл зүйн шинж чанарууд, харилцааны ур чадвар, эв дүй, бусадтай хамтран ажиллах, харилцан үйлчлэх, авьяас билгээ хөгжүүлэх явдал хэмээн үздэг. (Estrich.S. Real rape. Cambridge, 1987)

бусдын үлгэр дуурайллаас суралцах, нийгмийн амьдралыг ажиглан тандах үйлийн үр дүн байдаг. Хүмүүс өөрсдийн нийгмийн зан үйлийн үр дагаврыг урьдчилан харах, зан үйлээ урьдаас нэг бүрчлэн төлөвлөж хэрэгжүүлэх чадвартай байдаг. Хүн зан үйлийнхээ эцсийн үр дүнд чухам юу хүсэн хүлээж байгаа нь түүний амьдралд маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

Нийгэмшлийн өөр нэг тодорхой, гэхдээ нэн чухал механизм бол ижилсэхүй юм. Хүн бие сэтгэцийн хөгжлийнхөө явцад хүний харилцааны зан үйл, эв дүй, ур чадварын олон янзын хэлбэр, хэв шинж, хэм хэмжээг эцэг эх, үе тэнгийнхэн, эргэн тойрныхоо хүмүүсийнхээ үзэл бодол, амьдралын туршлагыг хүлээн авахдаа тэдэнтэй өөрийгөө ижилсгэж байдаг. Хүүхэд энэхүү ижилсэх механизмын тусламжтайгаар нийгмийн олон төрлийн туршлага олж аваад зогсохгүй, бас хүйсийн, ах эгчийн, эцэг эхийн, мэргэжлийн гэх зэрэг олон дүрд өөрийгөө зохих хэмжээгээр бэлтгэж байдаг онцлогтой. Бага насны хүүхдийн ижилсэх үндсэн эх сурвалж нь эцэг эх байдаг. Хүний нийгэмшлийн нэг чухал механизм болох ижилсэхүй хүмүүсийн бүх насан туршид үйлчилсээр байдаг. Ижилсэхүйн эх үндэс нь хүмүүст хэрэгтэй, тэдэнд таалагдсан үнэ цэнэтэй шинж чанарыг өөртөө агуулж байдаг. Өөрөөр хэлбэл бидний соёл, уламжлалт хандлага нь та бидний үр хүүхэд, хойч ирээдүйд гүн бат шинжтэй уламжлал хэлбэрээр үлдсээр байдаг гэсэн үг юм.

Хэдийгээр бие хүний сэтгэл зүйн бүтцийг нэг бүрчлэн тодорхойлох хялбар биш ч энэ асуудлыг ямар нэг хэмжээгээр тодруулахгүйгээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Нийгмийн солилцооны онолыг үндэслэгч Жорж Хоман нийгмийн бүхий л харилцааг энэ онолоор тайлбарлахыг зорьж байжээ. Тиймээс ч гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг энэ онолоор тайлбарлаж болох юм. Ямар ч харилцаанд байх харилцан солилцох зарчмын дагуу хосууд мөн бие биедээ үйлчлэх эсвэл тухайн харилцаанаасаа ямар нэг үр шим хүртэх байдлаар дотно харилцаанд байдаг. Энэ онолоор хүний зан үйл нь бусдын магтаал ба шийтгэлийн нөлөөнд өөрчлөгдөн өөрийн хэв маягаа олдог гэж үздэг. Өөрөөр хэлбэл энэ онолд тайлбарласнаар, хүмүүс хүссэн зүйлээ авах, хүсээгүй үр дүнгээс зайлсхийхийн тулд өөрийн биеэ авч яваа байдалдаа анхааралтай ханддаг. Нөгөө талаас, хэрэв сөрөг үр дагавартай тулгарахгүйгээр, хүчирхийллээр хүссэн зүйлээ авбал хүчирхийлэл үйлдэгч энэхүү үйлдлээ дахин давтах магадлал их гэж үздэг. Онолын төлөөлөгч Геллисийн тодорхойлсноор, хэрэв тухайн хүч хэрэглэж буй үйлдлийг эсэргүүцэх ямар нэг хуулийн арга хэмжээ аваагүй, эсвэл хүч хэрэглэснийхээ төлөө ямар нэг сөрөг үр дагавар амсахгүй бол хүч хэрэглэсэн этгээд хүчирхийллийг хамтран амьдрагчаасаа хүссэн зүйлээ авах тактик болгон хэрэглэж болно гэж үзсэн байна.

Хүч хэрэглэх нь тэдний хувьд тохиолдсон бэрхшээл, зөрчилдөөнт байдлыг шийдвэрлэх цорын ганц, шилмэл арга юм. Хүчирхийлэл үйлдэгчид гэмт зан төлвөө бүх талаар зөвтгөх, буруугаа бусдад болон гадны хүчин зүйлд тохох талаар мэргэшсэн байдаг. Хүчирхийлэл үйлдэгчийг энэхүү үйлдлүүдийг хийхэд түлхэж, өдөөж байдаг зан төлвийн элдэв гажуудал нь гэр бүл, хамт олны тааламжгүй нөхцөлд хүүхэд ахуй насанд нь төлөвшиж түүний гэмт үйл ажиллагааны үндсэн агуулга, чиглэлийг тодорхойлдог байна.

Хүчирхийлэл үйлдэгчид ялимгүй зүйлээр шалтаглан бусдыг айлган сүрдүүлэх, зодох, жанчих, хүч хэрэглэх замаар өөрийнхөө хүч чадалтай, эрэмгий зоригтой болохоо батлахыг эрмэлздэг сэтгэл зүйн өвөрмөц онцлогтой [3] . Түрэмгий догшин авирлах нь хүч хэрэглэсэн гэмт хэрэгтнүүдэд байдаг түгээмэл шинж юм [4]. Түрэмгий зан авир нь бусдыг дайсагнах, уурлан бачимдах, үзэн ядах бодлын бодит илрэл юм. Хүн хэрцгий догшин зан авиртай болж төлөвшихөд гэр бүл, хамт олон, бичил бүлгийн сөрөг нөлөөлөл, тухайлбал хүүхдийг ёс суртахууны талаар зөв төлөвшүүлж чадаагүй, хүмүүс хоорондын зөрчлөө хүч хэрэглэх замаар шийдвэрлэдэг байдал нөлөөлнө. Гэмт хэрэг үйлдэхдээ хэрцгий догшин авирлахад тухайн үеийн тааламжгүй, зөрчилдөөнд нөхцөл байдал, хохирогчийн буруутай ажиллагаа, субьектийн сэтгэл санааны гэнэтийн цочрол, сэтгэцийн эмгэгтэй байдал, өөрийгөө хүч чадалтай, зориг зүрхтэй болохоо батлах гэсэн эрмэлзэл зэрэг нь өдөөгч хүчин зүйлүүд болдог.

Хэрцгий догшин зан авир нь бие хүн уурлах, хар амиа хичээх, өөрийнхөө боломжийг хэтрүүлэн үнэлэх, тохиолдсон бэрхшээлийг давж туулах зориг, өөрийгөө хянах чадвар дутах, нийгэм, хамт олон, гэр бүлийн нөлөөнөөс холдож хөндийрөх, нийгэмд тогтсон хууль ёс, дэг журам, ёс суртахууны хэм хэмжээг үл ойшоох зэрэг зан төлөв, сэтгэл зүйн сөрөг шинжүүдээр нөхцөлдсөн байдаг. Хүчирхийлэл үйлдэгчийн догшин авир нь субьектын хэрэгцээг хангах гол хэрэгсэл болдог байна.

Магадгүй, хүмүүс хүчирхийлэл үйлдэгч гэр бүлийн аль нэг эсвэл бүх гишүүнийг дарамталж, хүчирхийлэх явдал нь тухайн хүчирхийлэл үйлдэгчид шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэж бодож болох юм. Гэвч үнэндээ, хүчирхийлэл үйлдсэн хүнд хүчирхийллээс улбаатай үүсэх сөрөг нөлөө багагүй. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн эрчүүд өөртөө хэрхэн туслах тухай гарын авлага бичсэн Австралийн мэргэжилтэн Р.Франсис, түүний хамтран зүтгэгчид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид дараах байдлаар хохирдог хэмээн тодорхойлжээ [5]. Үүнд: хүчирхийлэл

[3] С.Жанцан . Хууль зүйн сэтгэл судлал, УБ., 2001, 262 тал

[4] Жанцан Суурийн, Борьба с рецидивной преступностью /Уголовно-правовые и криминологические проблемы / Докторская диссертация., М 1992

[5] Net, Frances.R, 1994, Belfrage.N &Wilson.I, 1998 "Mirrors, Windows and Doors": A self-help book for men about violence and abuse in

үйлдэгч нь хуулийн хариуцлага хүлээнэ; хүчирхийлэл үйлдэгч - хувь хүний хувьд тодорхой хэмжээний хохирол амсана. Чухам ямар байдлаар хүчирхийлэл үйлдэгч нь хувь хүний хувьд хохирол амсана гэж? Гэсэн асуултад-судалгааны дүнд хийгдсэн дүгнэлтэд - *Хүчирхийлэл үйлдэгч хувь хүнийхээ хувьд* өөрийн ойр дотны хүмүүс болох гэр бүл, үр хүүхдээсээ хөндийрдөг. Магадгүй гэр бүлийг гишүүдээсээ салж өөр хүнтэй гэр бүлийн харилцаа үүсгэсэн ч чухам дадсан түрэмгий байдал, хүчирхийлэгч зан үйл нь түүнийг дахин гэр бүлийн хүчирхийлэл үйлэдхэд хүргэж болох юм. Мөн ойр дотны хүмүүс болох гэр бүлийн гишүүдээсээ хөндийрхийн сацуу найз нөхөд, төрөл садантайгаа харилцах харилцаанд нь мөн өөрчлөлт гардаг байна. Хүчирхийлэл үйлддэг нь ил болсон, түрэмгий зантай олон олон эрчүүд найз нөхөд, ойр дотны хамаатан, гэр бүлийн хүмүүстэйгээ удаан хугацаанд холбоо тасарсан байх явдал түгээмэл байдаг бөгөөд энэ болгон нь хүчирхийлэл үйлдэгчийг нийгмээс улам тусгаарлахад хүргэдэг. Мөн хүчирхийлэл үйлдэгчийг байнгын уур хилэн, сэтгэл санааны тогтворгүй байдал нь түүний сэтгэцийн эрүүл мэнд, мэдрэл, зүрх судасны үйл ажиллагаа, улмаар түүний эрүүл мэнд, амьдралын сайн сайхан байдалд муу нөлөө үзүүлдэг.

Олон судлаачид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн талаар судалж үзэн гэр тэд сэтгэцийн өөрчлөлттэй байх үндэсгүй хэмээдэг. Гэвч сэтгэцийн өвчлөл нь биологи, нийгэм, сэтгэл зүйн хүчин зүйлсийн харилцан үйлдлүүдийн үр дүнд үүсдэг байна. Үүнд:

Сэтгэл зүйн хүчин зүйлс: Бие хүний дотоод будлиан, сэтгэцийн дотоод будлиан, тайлагдаагүй далд бухимдал, сэтгэлийн цохилт, дистресс, фрустраци, стрессээ тайлах чадваргүй байдал, харилцааны ур чадвар эзэмшээгүй бие хүн, гутранги бодолтой байх, ирээдүйдээ үл итгэх, өөртөө итгэлгүй байх, эмгэг зан төлөв, бусад хүчин зүйлс.

Нийгмийн хүчин зүйлс: Ялгаварлан гадуурхалт, муу нэр авах, сэтгэцийн өвчнийг мухар сүсгээр тайлбарлах, архидалт ба мансуурал, хүчирхийлэл, гэр бүл салалт, гэр бүлийн буруу хүмүүжил, тухайн цаг үеийн нийгмийн бухимдал, ядуурал, ажилгүйдэл, бүлэг хүмүүсийн хоорондын будлиан, бусад сөрөг хүчин зүйлс.

Биологийн хүчин зүйлсийн нөлөөлөл: Ферментүүдийн эмгэг ба сэтгэцийн өвчин, бэлгийн хромосомын эмгэг ба сэтгэцийн өвчин, тархины сөнөрөл, витаминуудын дутмагшил, нейротрансмиттерийн идэвхт чанар ихсэх буюу буурах, бие хүний хувийн онцлог чанар, насны үечлэлийн хүчин зүйлс, хордлогын шалтгаант эмгэгүүд, халдварын шалтгаант эмгэгүүд, гэмтлийн шалтгаант эмгэгүүд, судасны шалтгаант эмгэгүүд, гэмтлийн шалтгаант эмгэгүүд, биеийн өвчний шалтгаант эмгэгүүд, дотоод

the home. Richmond Vic: V-NET "The Victorian Network for the Prevention of Male Family Violence"

шалтгаант сэтгэцийн эмгэгүүд, бусад хүчин зүйлс багтана.

Өөрөөр хэлбэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч бие хүнд нөлөөлөх нөлөөлөл харилцан адилгүй хэдий ч нийтлэг байдлаараа энэ 3 хүчин зүйлийн нөлөөллөөр эрсдэлт зан үйл дагуулдаг байна.

Хэдий олон төрлийн шалтгаан нөхцөл байдаг хэдий ч тэдний энэ мэтийн /хүчирхийлэл/-ийн үйлдлүүд нь хүмүүжил, харгис хэрцгий байдалд нь төрж өссөн гэр бүлийн орчин /хүүхэд байхад нь эцгийнхээ хүчирхийлэл үйлдэх явцын гэрч болсон, өөрөө биемахбодийн хүчирхийлэлд өртөж байсан/ нийгмийн нөлөө хамгийн чухал хүчин зүйл болдог хэмээн үздэг байна.



*Э. АЛТАНЗУЛ*
*Идэр дээд сургууль*
*НАНУБ тэнхимийн*
*багш*

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ НИЙГМИЙН АЖЛЫН МЭРГЭЖЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ (ХОРООНЫ ЖИШЭЭН ДЭЭР)

## Social work profession issues at the labor market and it is solutions

Thechnical guidance, middle and senior administration is not clear. Therefore professional social work interventions are not fully reaching the public and not giving chance to improve and develop citizens.Development social workers don't have complex job description. Thus district social welfare department head is creating the job description but due to lack of concrete standard social workers are tend to have busy. Also these things lead to poor interaction with public. workplace auditions are restricted. Research results show that regardless professionality, employees tend to hire non- professional people. Also these things lead to poor interaction with public. workplace auditions are restricted. Research results show that regardless professionality, employees tend to hire non- professional people. Employers also agreed with these issues. Research work has revealed that political parties show a lot of negative affect. Common challenges that social worker of Khoroo are Facing are as insufficient remuneration mechanism , poor working conditions and unstable guarantee of job uncertainty. Those thing are affecting as a barriers to the provision of services. Eventhough students majoring in social work have good skills of communication, teamwork and organization they are weak in psycological counseling and in working with documents. Therefore in universities it is necessary to provide more knowledge and skills in this area.

**Үндэслэл:**

Хүн амын нийгмийн хамгааллын системийн салшгүй нэг хэсэг бол нийгмийн халамжийн асуудал байдаг.Нийгмийн амьдралын нугачаанд тулгарсан хүндрэл, бэрхшээлтэй тэмцэх чадваргүй, өөрт тохиолдсон эрсдлээс бие даан хамгаалагдах болзлыг хангаж чадахгүй хэсэг бүлэг хүмүүс аль ч нийгмийн үед, хөгжлийн ямар ч түвшинд байсаар ирсэн, цаашид ч байх л болно.Эдгээр хүмүүст хүн төрөлхтөний хүмүүнлэг, соёл иргэншилт нийгмийн гишүүний хувьд нь амьдрах боломж олгох, дэмжиж туслах шаардлага нийгмийн бусад давхарын хүмүүст тавигддаг. Энэ шаардлагыг амьдралд хэрэгжүүлэх арга хэрэгслийн нэг нь нийгмийн халамжийн системээр дамжуулан зорилтод бүлгүүдэд чиглэн тэдэнд хүрч ажиллах үүрэг бүхий мэргэжилтэн бол сум, хорооны нийгмийн ажилтнууд юм. Энэ ч утгаараа нийгмийн халамжийн салбарын нийгмийн ажилтнууд нь

маш чухал үүрэг бүхий албыг хашдаг. Өөрөөр хэлбэл төр, ард иргэдийг холбогч гүүр гэж хэлж болохуйц чухал мэргэжил юм. Гэтэл энэ салбарын мэргэжилтнүүдийн талаар тодорхой судалсан судалгаа шинжилгээний ажил туйлийн бага, бараг судлагдаагүй байна. Халамжийн салбарт тэр дундаа төр захиргааны анхдагч нэгж болох сум, хороодуудад мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллах ёстой гэж нийгмийн халамжийн тухай хуулийн зураг дугаар бүлгийн 28.1 тусгасан байдаг. Гэтэл амьдрал дээр энэ салбарын нийгмийн ажилтнуудын хүний нөөц бүрдүүлэлтэд хуулийн дагуу “Нийгмийн ажлын мэргэжлээр бакалавр болон түүнээс дээш түвшний боловсролтой” мэргэжилтэнг ажлын байранд авч ажиллуулж байгаа хувь туйлийн бага байсаар л байна.

Үүний тод жишээ Тэгвэл 2015 оны байдлаар нийслэлийн 9 дүүргийн 152 хороон дээр нийт халамжийн асуудал хариуцсан 198 халамжийн мэргэжилтэн ажиллаж байгаагаас ердөө 30 мэргэжилтэн нь мэргэжлийн нийгмийн ажилтангууд ажиллаж байна [1] .Үүнийг хувьд шилжүүлвэл ердөө15.2% нь мэргэжлийн нийгмийн ажилтан ажиллаж байна гэсэн үг юм.Тэгвэл “Хөгжлийн” нийгмийн ажилтнуудын ердөө 12% нь мэргэжлийн нийгмийн ажилтнууд ажиллаж байна [2] . 2014 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийгмийн ажлаар мэргэжилтэн бэлтгэж байгаа 14 их дээд сургуулийг” Нийгмийн ажилтан” мэргэжлээр Бакалаврын боловсрол эзэмшин гарч байгаа 422 мэргэжилтэн төгссөн байна.[3] Дээрхи үзүүлэлтээс харахад энэ салбарт хөдөлмөрийн зах зээл дээрх эрэлт нилүүлэлтийн хувьд ямар нэгэн гажуудал гарсан байгаа нь харагдаж байна.Тиймээс халамжийн салбарын нийгмийн ажилтан тэр дундаа хорооны нийгмийн ажилтануудын дунд мэргэжлийн нийгмийн ажилтанг авч ажиллуулахгүй байгаа шалтгаан, нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд тэдэнд тулгарч байгааасуудалыг илрүүлэн судлах шаардлага урган гарч ирж байгаа юм. Иймээс **хөдөлмөрийн зах зээл дээрх нийгмийн ажлын мэргэжлийн тулгамдсан асуудал шийдвэрлэх арга зам** “сэдвийг сонгон судалгааны ажлыг хийсэн болно.

**Судалгааны зорилго:**

Хороонд ажилдаг нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд нь тулгарч буй саад бэрхшээлийг судлан шийдвэрлэх арга замыг тодорхойлоход

**Судалгааны түүвэрлэлт:** Энэхүү түүвэр судалгаанд

- Нийслэлийн Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн халамжийн болон хөгжлийн нийт 90 нийгмийн ажилтнуудаас анкет болон асуулгын аргаар судалгааг авсан.Судалгаан оролцогчдын 52% нь халамжийн мэргэжилтэн, 44% нь хөгжлийн нийгмийн ажилтан, үлдсэн хувь нь түр орлон ажилагсад байсан.

[1] НХҮЕГ- тайлан2014 он

[2] НГБХГ- судалгаа 2014 он

[3] БСШУЯ Их, дээд сургууль, коллеж төгсөгчдийн мэргэжлийн чиглэл судалгаа 2014 он

- Нийгмийн ажилтан мэргэжлээр суралцаж буй төгсөх курсын оюутнуудын мэргэжлийн чиг баримжаа, ажил олгогчийн зүгээс тавигдах нийтлэг шаардлагад нийцэж байгаа байдлыг судлах зорилгоор МУБИС болон Идэр дээд сургуулийн нийт 43 оюутнаас ярилцлага болон анкетын аргаар судалгаа авсан.

- Ажил олгогчдын зүгээс халамжийн болон хөгжлийн нийгмийн ажилтанг ажлын байран дээр сонгон шалгаруулан авахад тавигдах шаардлагыг судлах зорилгоор

Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүргүүдийн халамжийн болон хөгжлийн нийгмийн ажилтнуудыг хариуцан ажилдаг удирлах албан тушаалтан буюу ажил олгогчдын төлөөлөл болох 10 мэргэжилтнээс ярилцлага болон анкетын аргаар судалгаа авсан.

Мэдэээл цуглуулах арга:

Хөдөлмөрийн зах зээлийг сонирхогч талууд болох дээрх зорилтот гурван бүлгүүдийн хүрээнд асуулга болон ярилцлагын аргаар мэдээллийг цуглуулсан ба цуглуулсан мэдээлэлд тойм статистикийн аргаар боловсруулалт хийлээ.

Судалгааны шинэлэг тал: Энэхүү судалгаагааруг салбарт ажиллаж байгаа практикын нийгмийн ажилтнуудынтулгамдаж байгаа асуудлыг судлаад зогсохгүй хөдөлмөрийн зах зээлийг сонирхогч талуудаас төлөөлөл болгон эмпирик судалгаа хийж үр дүн дээр нь үндэслэнхаламжийн салбарт ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтны ажлын байран дээрээ тогтвортой ажилах боломжийг бүрдүүлэх, цаашлаад тулгамдаж байгаа асуудлыг хууль эрх зүйн орчинтой холбон авч үзэж байгаа нь өмнө нь хийгдэж байсан судалгааны ажлуудаас шинэлэг болно.

Судалгааны ажлын практик ач холбогдол:

Практик дээр ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд тэдэнд тулгарч байгаа асуудалыг илрүүлэн судалсанаар нийгмийн ажилтнуудын дунд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд тулгарч байгаа асуудлыг тодруулж шийдвэрлэх арга замыг ирэлхийлэх замаар халамжийн салбарт ажиллах мэргэжлийн нийгмийн ажилтны ажлын байран дээрээ тогтвортой ажилах боломжийг бүрдүүлэх цаашлаад Монголын халамжийн салбарын боловсон хүчнийг амжилттай бэлтгэхэд их дээд сургуулийн багш нар оюутнуудад ямар чадварыг голчлон эзэмшүүлэх нь хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй болохыг судлан тодруулж дээд сургуулийн боловсролын сургалтын чанарыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр болох.

**Энэхүү судалгааны үр дүнд хэд хэдэн тулгарч байгаа асуудыг тодорхойллоо үүнд:**

- Нэг нийгмийн ажилтанд ноогдож буй хорооны хүн амын тоо хэт их
- Хууль эрх зүйн орчин сул үүнд:
  - Ажлын байрны тодорхойлолтыг засан сайжруулах
  - Нийгмийн ажилтны хмгаалах хууль эрх зүйн орчин сул

- Ажлын орчин нөхцөлийн хүрээнд тулгарч буй асуудал
- Төсөв санхүү байхгүйн улмаас мэргэжлийн болон бусадсургалт явуулах боломжгүй
- Ажил үүргийн тодорхойгүй хэт их олон төрлийн үйл ажиллагаа явуулах нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох
- Айл өрхүүдээр явж нөхцөл байдлын үнэлгээ хийх явдлыг хбгжлийн нийгмийн ажилтны ажил үүргийн хувиарт тусгаагүй
- Ажлын ачаалал их тул илүү цагаар сууж ажилтаг боловч үнэлгээ урамшуулалгүй
- Цалингийн зэрэглэл ялгаатай тогтоосон атлаа хөгжлийн нийгмийн ажилтанд халамжийн мэргэжилтнээс илүү ачаалалтай ажилдаг
- Мэргэжлийн бус хүмүүс ажилладаг тул мэргэжил арга зүйн чадьар чадамж дутагддаг тул супервизорыг орон тоо үгүйлэгдэж байна.

## Дүгнэлт

Судалгаанд оролцогчдын маш бага хувь нь мэргэжлийн нийгмийн ажилтан байсан ба мэргэжлийн бус хүмүүс мэргэжлийн хүмүүстэй харьцуулахад нийгмийн ажлын үүрэг, үйлчилгээг бүрэн утгаар нь мэдэхгүй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Иймээс мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг энэ ажлын орон тоон дээр ажиллуулах шаардлагатай байна. Тэгсэн цагт мэргэжлийн чанартай үйлчилгээг иргэдэд хүргэх боломжтой болох юм. Түүнчлэн судалгаанд хамрагдсан гурван дүүргийн ажлын байрны тодорхойлолтонд дүн шинжилгээ хийхэд СБД-ээс бусад хоёр дүүргийн хувьд ажлын байранд тавигдаж буй ерөнхий шаардлагын хувьд мэргэжил харгалзахгүй гэсэн байна. Энэ нь нийгмийн ажилтныг хэн дуртай хүн хийх боломжтой гэсэн өрөөсгөл ойлголтыг бий болгох улмаар мэргэжлийн бус хүн ажиллуулах нөхцлийг үүсгэж байгаа нь нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг үйлчлүүлэгчдэд хүргэх боломж нөхцөлийг бууруулж байна.

Ур чадварын хувьд нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, албан бичиг хөтлөх чадвартай байх, англи хэлний дунд шатны мэдлэгтэй, компьютерийн хэрэглээний программ дээр ажиллах чадвартай гэж заасан байна гэтэл эдгээр чадвараас гадна хамгийн чухал чадвар болох харилцааны ур чадвар, судалгаа шинжилгээ хийх гэх мэт мэргэжлийн чадваруудыг ажлын байрны тодорхойлтонд тусгаагүй эдгээр чадварт ач холбогдол өгөхгүй байгаа нь нийгмийн ажлын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх шаардлагатай байна. Энэ асуудлыг хороонд ажиллаж байгаа нийгмийн ажилтнуудаас судалгаа авахад ажлын байрны нэгдсэн тодорхойлолт байхгүй, дүүрэг бүрийн хөгжлийн хэлтсийн дарга нарын үзэмжээр тодорхойлолтыг гаргаж байгаа нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд саад учруулж байна. Иймээс нэгдсэн албан ёсны тодорхойлолтыг холбогдох яам тамгын газраас батлах хэрэгцээ шаардлага байна гэсэн үр дүн гарлаа. Иймд нийгмийн ажилтнуудын эрх зүйн орчинг боловсронгүй болгох, хэрэгцээ шаардлага байгаа тухай, эрх зүйн

зохицуулалтыг сайжруулахад саад учруулж байгааг хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор экспертүүдээс ярилцлагын аргаар судалгаа авсан. Хороонд ажиллаж байгаа халамжийн мэргэжилтэн болон хөгжлийн нийгмийн ажилтны ажил үүргийн хуваарилалтыг сайтар зохицуулах нэн шаардлагатай байна гэж санал нэгтэйгээр хариулсан ба үүний тулд ажлын байрны тодорхойлолт, хууль эрх зүйн орчинг сайжруулах тал дээр ажиллах шаардлагатай байна гэж хариулсан юм. Мөн хорооны хөгжлийн нийгмийн ажилтан нь халамжийн мэргэжилтэнтэй харьцуулбал түүнд хамаарагдах ажлын цар хүрээ их, хариуцах ажил их, ачаалал өндөр байна. Нэг нийгмийн ажилтанд ноогдох хүн амын тоо хэт их жишээ нь: БЗД-ийн хувьд хамгийн их хүн амтай хороо нь 18,900 байгаа нь хэт их ачаалал үүсгэх нөхцөл болж байгаа нь ойлгомжтой. Бидний судалгаанд оролцсон хүмүүс долоо хоногт дунджаар 240 хүнтэй ажилдаг байна. Мэргэжлийн нийгмийн ажилтанг ажлын байранд сонгон шалгаруулах асуудал хязгаарлагдмал байдгаас мэргэжлийн онцлог байдлыг үл харгалзан мэргэжлийн бус хүнийг авч ажиллуулах, ажлын байрны онцлогыг үл харгалзан албан тушаалын дамжлага болгож байгааг судалгааны үр дүн харуулж байна. Ажил олгогчдын зүгээс нийгмийн ажилтанг ажлын байранд сонгон авахад дадлага туршлага, ажилласан жилээс гадна төгссөн сургуулийн статусыг харж ажилд авах хандлага өндөр байгаа нь судалгааны дүнгээс харагдсан. Улсын сургууль төгссөн төгсөгчийг ажилд авах хүсэл сонирхол өндөр байлаа. Мөн дадлага туршлага чадварыг анхаарч авахаас илүүтэй танил тал, намын нөлөө их нөлөөлж байна. Төгсөгчдөд тавигдаж байгаа шаардлагын хувьд харилцааны ур чадвар, багаар ажиллах чадвараас гадна албан бичиг боловсруулах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, үйл ажиллагаа зохион байгуулах чадвар хамгийн хэрэгцээтэй байна гэж ажил олгогчид үзэж байгааг судалгааны үр дүн харуулж байна. Түүнчлэн хорооны нийгмийн ажилтанд тулгарч буй нийтлэг бэрхшээлийн нэг нь цалин урамшууллын механизм хангалтгүй, ажлын байрны орчин нөхцөл, тогтвортой ажиллах баталгаа муу, ажил үүргийн тодорхойгүй байдал зэрэг нь ажил үйлчилгээ үзүүлэхэд саад болж байна. Нийгмийн ажилтнуудад үйлчлүүлэгчийг хүлээн аван уулзах тусдаа өрөө тасалгаагүйн улмаас үйлчлүүлэгчийн нууцын асуудалд, цаашлаад мэргэжлийн үнэт зүйлд харшлах тохиолдол гарсаар байгааг судалгаанд оролцогсод илэрхийлж байсан.

Харин нийгмийн ажил мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудын хувьд хамгийн сайн эзэмшиж байгаа чадвар нь харилцааны чадвар, багаар ажиллах, зохион байгуулах ур чадваруудыг сайн суралцсан байгаа ч ажил олгогчдын тавьж буй баримт бичиг боловсруулах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх чадвар сул байна. Иймээс их дээд сургуульд энэ чиглэлийн мэдлэг чадварыг түлхүү олгох шаардлагатай байна. Нийгмийн халамжийн тухай

шинэчилсэн хуулинд нийгмийн ажилтнуудыг мэргэжлийн сургалтанд хамруулж магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээний эрх олгох байгууллагыг байгуулах тухай заасан байдаг ба "Нийгмийн ажлын ажил үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ, хувийн тэмдэг олгох, ёс зүйн дүрэм батлан сахиулах ажиллагааг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх орон тооны бус зөвлөл гүйцэтгэнэ гэсэн байдаг. Гэвч энэ заалт зөвхөн халамж хариуцсан мэргэжилтэнд холбогдохоос хөгжлийн нийгмийн ажилтанд холбогдохгүй байна. Мөн энэ хуулинд тусгагдсан нийгмийн ажилтан гэсэн нэг томьёо ч нэр томьёоны хувьд хөгжлийн нийгмийн ажилтанд холбогдох боловч үндсэн үүрэг үйл ажиллагааны хүрээнд" Халамжийн мэргэжилтэн"-д хамаарч байна. Үүнээс үзэхэд хууль эрх зүйд шинчлэл шаардлагатай байна.

**Ном зүй**


1. Алтангэрэл.С., Нацагдорж.Б., Сарантуяа.Б., (2008). Макро эдийн засгийн ухаан. Улаанбаатар.
2. Бакей.А., Батцоож.Ө., Оросоо. Р., (2002). Эдийн засгийн ухаан. Улаанбаатар.
3. Дагвадорж.Ч.,(2004). Нийгмийн хамгаалал. Улаанбаатар.
4. Гидденс.А., Ганхуяг.Д., (2006) Социологи/ред. Улаанбаатар.
5. Мөнхбат.О., (2000). Нийгмийн социаль бүтцийн социологи. Улаанбаатар.
6. Монгол улсын мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд ажил олгогч эзэд, бизнес эрхлэгчдийн оролцоо.( 2009). Улаанбаатар.
7. Нямдорж.М.,(2013) Нийгмийн ажил. Улаанбаатар.
8. Нямдорж М. Өлзийтунгалаг Х.нар (2006) Нийгмийн ажлын сургалтын гарын авлага Улаанбаатар.
9. Лханям.Л., Саран Л.,( 2008). Хөдөлмөрийн эдийн засаг. Улаанбаатар.
10. Смелзер. Н.,( 2001). Социологи. Улаанбаатар.
11. Пүрэв .Ц.,(2013).Монголын нийгмийг социологиор шинжлэхүй. Улаанбаатар.
12. Пүрэв. Ц.,( 2009) Хөдөлмөрийн социологи. Улаанбаатар.
13. Содномдорж. Н., (2006). Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрийн шинэ харилцаа, шинэ зууны үйлдвэрчний эвсэл.Улаанбаатар.
14. Содномдорж Н.,( 2000). Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг. Улаанбаатар.



**Б.БОЛОР-ЭРДЭНЭ**
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахлах дэслэгч

# ГҮЙЦЭТГЭХ БАРИМТ БИЧИГ ДЭХ ЭД ХӨРӨНГИЙН БУС ШААРДАХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол улсад Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд шүүх болон бусад байгууллагаас гаргасан шийдвэр, эрх зүйн баримт бичгийн үндсэн дээр бичигдсэн гүйцэтгэх баримт бичигт зааснаар бусдын хуулиар хамгаалагдсан зөрчигдсөн эрх ашгийг сэргээж, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг явуулахтай холбогдсон нийгмийн тодорхой харилцааг зохицуулж байна. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр анх “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль”-д Иргэний, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах журмыг хамтад нь хуульчилж өгсөн бөгөөд энэ нь Монгол улсад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх журмыг зохицуулсан анхны нэгдмэл акт байснаараа түүхэн ач холбогдолтой юм. Үүнээс хархад шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны анхны эх сурвалж нь 1926 оны “Монгол Ард Улсын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах шийтгэх тухай хууль” юм. Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотойгоор илүү ойртуулсан хууль бол 1952 оны “Бүгд Найрамдах Монгол Ард улсын Иргэний байцаан шийтгэх хууль” юм. Энэ хуулиар иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны гол чиг үүргүүдийг тодорхой болгож өгсөн.

Иргэний хэргийн болон захиргааны хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төгсгөлийн үе шат буюу үргэлжлэл хэмээн зарим эрдэмтэн, судлаачид дүгнэсэн байдаг хэдий ч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах, нөгөө талаар иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээн эдлүүлэхэд чиглэгдсэн онцлог эрх зүйн зохицуулалттай,бие даасан харилцаа гэж тодорхойлдог.

1994 оны 5 дугаар сараас шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны тухай хуулиудын зохих зүйлд иргэний хэргийн талаарх шийдвэрийг хэрхэн биелүүлэх, гүйцэтгэх тухай заагдсан байдаг. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны шинэчлэл нь холбогдох хууль тогтоомжид тусгалаа олж, боловсронгуй болон хөгжсөөр ирснийг 1994, 1996, 2002 оны хуулиас тодорхой харж болно.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд ажиллагаа бүрийг нарийвлан зохицуулж зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийг хийсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг зөвхөн иргэн, хуулийн этгээдийн хоорондын төлбөрийн асуудалтай хамааралтай явагдаггүй, тэжээн тэтгүүлэх болон шүүхээр шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны онцлогоос хамаарч хуулийн этгээдийн хувьцаа хуваах, үйл ажиллагааг нь зогсоох, шинээр бүртгэл хийх, бүртгэлээс хасах, эрх зүйн актын биелэлтийг хангуулах, хариуцагчид даалгасан үүргийг гүйцэтгүүлэх, хориглох зэрэг ажиллагааг хэрэгжүүлж байна. Нийт гүйцэтгэж байгаа шүүхийн шийдвэрийн 70 орчим хувийг иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх баримт бичиг эзэлдэг.

**Үүнийг чиглэлээр нь ангилбал:**

1.Иргэд хоорондын төлбөртэй холбоотой ажиллагаа

2.Хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагаа

3.Тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, гүйцэтгэгэхгүй байхыг хариуцагчид даалгасан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зэрэг байгаа юм.

Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь тухайн төлбөр төлөгчийн төлбөрийн чадвар, хөрөнгө орлогоос шууд шалтгаалдаг бөгөөд төлбөр төлөгчийн эд хөрөнгийг шүүхийн шатанд хамгаалуулах арга хэмжээ аваагүйгээс шүүхийн шийдвэр гарахаас өмнө эд хөрөнгө бусдад шилжиж, үрэгдсэн байдаг нь шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд нөлөөлж, төлбөр гаргуулах боломжгүй нөхцөл байдал үүсгэх, ажиллагааг удаашруулах нөхцөлийг бүрдүүлж байдаг.

Ирэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр жилд доорх байдлаар гардаг байна.

1.Иргэний хэргийн 80873 шүүхийн шийдвэр

2.Захиргааны хэргийн 5206 шүүхийн шийдвэр гарсан байна.

Үүнээс жилд дунджаар улсын хэмжээнд 40 мянга гаруй гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа явагдаж байгаагийн 9 мянга гаруй нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахтай холбоотой байна. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр тодорхой ажил зохион байгуулсаны үр дүнд 16347 гүйцэтгэх баримт бичгийн 168.2 тэрбум төгрөгийг барагдуулан төлбөр авагчийн шаардлагыг хангасан байна.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг явуулах эрх бүхий субектийг бэлтгэхдээ Хууль зүйн сайдын баталсан “Шийдвэр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах” тухай журмын дагуу шалгалт өгч тэнцсэн иргэн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах эрх үүснэ.

Шийдвэр гүйцэтгэгч нь засан захиргаа, нутаг дэвсгэрийн зарчмаар хуваасан тойрогт шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулдаг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын системийн хэмжээнд аймаг, нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба, хэсэгт тойргийн журмаар шийдвэр гүйцэтгэгч нар иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэн ажиллаж байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 7 дугаар

зүйлийн 7.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах анхан шатны нэгж нь тогтоосон тойрог байна гэж заасан байдаг. Шийдвэр гүйцэтгэгч нь тойргийн системээр ажиллах бөгөөд 7.7 дахь хэсэгт зааснаар 1 тойрогт 1 шийдвэр гүйцэтгэгч байхаар хуульчилсан байдаг.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгчийг 0.5-10%-р урамшууллыг олгож байгаа бол 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр үйлчлэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар шийдвэр гүйцэтгэгчийг урамшуулах талаар тусгагдаагүй ба харин шийдвэр гүйцэтгэгчийн ур чадварт тохирсон мэргэшлийн зэрэг тогтоох, мэргэшлийн зэргээс хамааран нэмэгдэл олгох тогтолцоо бий болох юм.

Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж байгаа зарим асуудлууд байдаг.

Иргэд шийдвэр гүйцэтгэгчид урамшуулалыг олгоход шийдвэрийг биелүүлээд дууссаны дараа сайн ажилласныг урамшуулан олгож байгаа хөлс. Гэтэл энэхүү урамшууллыг төлбөр авагч нар ойлгохдоо 100% шийдвэр гүйцэтгэгч авдаг гэж үздэг гэтэл уг урамшуулалын 3.5% -ийг шууд албаны байр, цахилгаан дулаан, тоног төхөөрөмж, урсгал зардал, сургалт семинар, томилолт зэрэгт шаардагдах зардлыг санхүүжүүлж байгаа тул энэ нь шийдвэр гүйцэтгэгчид бүрэн хэмжээгээр хүрч байгаа мөнгөн урамшуулал биш юм. Гэтэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд "Шийдвэр гүйцэтгэгчийн урамшуулал" хэмээн нэрлэгдэн зохицуулагдсан байдаг. Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг хэрхэн бүрдүүлж ажиллагаанд хэрэглэж байгаа нь анхаарал татаж байгаа юм. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 82 дугаар зүйл, Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах журамд зааснаар төлбөр авагчаас зардлыг гаргуулан тухайн ажиллагааг явуулдаг ажиллагааны явцад гарч буй бодит дундаж зардал суурин газарт 130.000-480.000, алслагдсан газарт 180.000-780.000 орчим мянган төгрөгийн зардал гарч байгаа боловч өнөөдрийн байдлаар нэг гүйцэтгэх баримт бичигт дундажаар 20.000-200.000 орчим мянган төгрөгөөр зардал тооцогдож байгаа ч ажиллагааны бодит зардлыг нарийвчлан тооцох зохицуулалтгүй байна. Мөн 1 төлбөр авагчаас авсан зардлыг хүүхдийн тэтгэлэг, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд зарцуулах асуудал их байгаа юм. Эдгээр ажиллагаанд зарцуулах зардлын талаар зохицуулсан зохицуулалт байхгүй байгаа юм.

Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах урьдчилсан нөхцөл нь тухайн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд гарах зардал, түүнийг хуульд заасны дагуу төвлөрүүлэн зарцуулах асуудал байдаг.

Эрх зүйн зохицуулалтаар шуудан холбоо болон шинжээчийн ажлын хөлсийг эрх бүхий байгууллагаас тогтоосон

үйлчилгээний хөлсний хэмжээгээр тооцохоор зааж, бусад зардлыг төлбөр авагчтай харилцан тохиролцох, мөн төрийн байгууллагад холбогдох зардлыг урьдчилан гаргуулахгүйгээр шүүхийн шийдвэр биелэгдсний дараа нөхөн төлүүлэхээр заасан. Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал гаргуулах ажиллагааг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байгаа юм. Манай улсын хувьд ажиллагааны төрөлд үнэлгээ тогтооход хүндрэлтэй ч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зайлшгүй гарах зардлыг тооцдог аргачлалыг эрх бүхий байгууллагаас батлуулан мөрдөх чиглэлээр шинэчлэл хийх шаардлагатай,ингэснээр талуудаас ямар төрлийн ажиллагаанд хэдэн төгрөгийн зардал төлөх нь нээлттэй, зардлын зарцуулалтад хяналт тавих тогтолцоо бүрдэх юм.

Иргэд шүүхээр маргаанаа шийдвэрлүүлэхээр хандаж байгаа ч хариуцагчийнхаа эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авахуулдаггүйгээс шүүхээр маргаан шийдэх хугацаанд нөгөө хариуцагч хөрөнгөө бусдад шилжүүлэх, зарж үрэгдүүлсэн байдаг нь шүүхийн шийдвэрийг шуурхай биелүүлэхэд нөлөөлж байна.

Энэ чиглэлээр тоо баримтаас харахад жилд шүүхээс ирж байгаа гүйцэтгэх баримт бичгийн зөвхөн 5 хувь нь хөрөнгө хамгаалах ажиллагаа явагдсан байдаг. Нэхэмжлэгчид шүүхийн шатанд хариуцагчийн хөрөнгийг хамгаалуулах арга хэмжээг авахуулах шаардлага байгаа нь дээрх хэлсэн тоо баримтаас харагдаж байна.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төсөлд иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын жишиг хандлагад нийцүүлэх, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх зохицуулалтын санал тусгагдсан нь "нэхэмжлэгч"-д өөрт хамаарах шүүхийн шийдвэрийг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагыг сонгон гүйцэтгүүлэх боломжийг олгож, нөгөө талаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр өрсөлдөөний нээлттэй тогтолцоо бий болох юм.

Хуулинд гэрээний үндсэн дээр хувийн шийдвэр гүйцэтгэл явуулах талаар тусгагдаж байна. Энэ нь хуулийн дагуу тодорхой шаардлага, шалгуур хангасан этгээд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг мэргэжлийн байгууллагын хяналт дор явуулахаар зохицуулагдаж байгаа юм. Тогтолцооны хувьд нотариатчийн үйл ажиллагаатай төстэй хэлбэрээр явагдана гэсэн үг юм.

Сүүлийн 3 жилийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны ажлын дундаж үзүүлэлтээс [1] үзэхэд 71.0 хувийг иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй, 25.0 хувийг эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэрээр

[1]Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх газрын 2013-2015 оны тайлан.

төлбөр гаргуулах, 3.0 хувийг захиргааны хэргийн, 1.0 хувийг эрх бүхий бусад байгууллагын шүүхээр баталгаажсан шийдвэр эзэлж байна.

2015 онд дуусгавар болгосон гүйцэтгэлийн 3.0 хувийг барьцаа эд хөрөнгөөр,4.0 хувийг төлбөр төлөгчийн болон дундын өмчлөлийн эд хөрөнгөөр, 80.0 хувийг мөнгөн хэлбэрээр барагдуулж 13.0 хувь нь хуульд заасан бусад үндэслэлийн дагуушийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой үзүүлэлтээс харахад 885 гүйцэтгэх баримт бичигт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан байна. Чиглэлээр харуулбал доорх байдлаар бодит биелэлтйг харж болох юм.

-Захиргааны шүүхийн шийдвэрийн биелэлт - 65.1%

-Захиргааны шийтгэвэр оногдуулсан торгууль- 81.6%- тай биелэгдсэн байна.

Нийт дүнгээр 73.9% -тай байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг гүйцэтгэж буй маргааны төрлөөр нь авч үзэхэд газрын асуудал шийдвэрлүүлэх, тусгай зөвшөөрлийн эрх олгох, өргөдөл хүлээн авч шийдвэрлэх, ажилд эгүүлэн томилсон шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, захиргааны актыг хүчингүй болгосон, захиргааны байгууллагаас зохих акт гаргахыг даалгасан, актын биелэлтийг түдгэлзүүлж, энэ хугацаанд дахин шинэ акт гаргахыг даалгасан шүүхийн шийдвэрт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж байна.

Шүүхийн шийдвэр бүрэн биелэгдэх шинжийг өөртөө агуулдаг ч төрийн эрх бүхий албан тушаалтан сайн дураар биелүүлэхгүй байх, тэдгээрээс шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг шаардах, гүйцэтгэхэд хүндрэлтэй асуудал үүсч байна.

Иймээс иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бүрийг бүрэн хэрэгжих боломжтой, хэрэгжүүлэх арга зам нь тодорхой байх, шүүхийн шийдвэрийг биелэлтийг хангуулах урьдчилсан нөхцөл төдийгүй, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үр дүнтэй явагдахад байгууллагын эрх хэмжээ, эрх зүйн зохицуулалтаас гадна тухайн шүүхийн шийдвэрээс шууд хамааралтай тул шүүхийн шийдвэрт гүйцэтгэх арга, журам тодорхой байх, энэ чиглэлээр эрх зүйн зохицуулалтын шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага үүссэн гэж дүгнэж байна.



**Ж.УУГАНЧИМЭГ**
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн дэд профессор, дэслэгч

# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ: ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Улс орнуудад "ерөнхийлөгч (*head of state, chef d'Etat*)" –ийг маш олон янзын нэршилээр томьёолдог.

Герман болон Австри улсад "Холбооны Ерөнхийлөгч (*Bundesprɔsident*)"[1], Финланд, Франц, Итали, Исланд, Португал, Турк болон Грек улсад "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч (*President of the Republic, Prŭsident de la Rŭpublique*)"[2], Израйл улсад "Улсын Ерөнхийлөгч (*President of the State*)" [3], Америкийн Нэгдсэн Улс, Монгол мөн Ирланд улсууд зөвхөн "Ерөнхийлөгч (*President, Uachtan na Eireann*)" [4] харин Австрали улсад "Ерөнхий засаг дарга (*Governor-General*)"[5] хэмээх байдлаар нэрлэдэг.

Энэхүү өгүүлэлд улс орнуудын ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүнд тавигдах шаардлага болон сонгох, шалгаруулах журмын талаар нарийвчлан судалж дурьдахыг хичээсэн болно.

## I. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх хүнд тавигдах шаардлага

Улс орнуудын үндсэн хуулинд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээдэд тавигдах шаардлага ихэвчлэн улсын их хурлын сонгуульд өрсөлдөх этгээдүүдэд тавигдаж буй шаардлагуудтай төстэй байдаг.

Энэхүү шаардлагуудыг иргэний харьяалал, нас, оршин суугаа газар, сонгох болон сонгогдох эрхтэй эсэх, иргэний болон улс төрийн эрх үүрэг хүлээх чадвартай эсэх гэх байдлаар дурьдаж болох юм.

**1. Иргэний харьяалал:** Иргэний харьяалал хамгийн энгийн шалгуур юм. Үндсэн хуулиудад ерөнхийлөгчөөр сонгогдох этгээд тус улсын иргэн байх ёстой гэж үздэг. Зарим улс орнуудад хууль тогтоох байгууллага иргэний харьяалалаас ч илүү чухал шаардлага бий хэмээн үзэж зарим нэг зохицуулалтыг үндсэн хуульдаа тусгажээ. Жишээ нь АНУ-ын Үндсэн хуулийн 2.1.4. зүйл[6], ерөнхийлөгчөөр сонгогдох хүн уг улсад төрсөн байх ёстой хэмээн үздэг. Тиймээс хожим нь АНУ-ын

[1] 1949 оны Герман улсын үндсэн хуулийн 54. зүйл, 1929 оны Австри улсын үндсэн хууль 60. зүйл.

[2] 1999 оны Финланд улсын үндсэн хуулийн 54. зүйл, 1958 оны Франц улсын үндсэн хууль 5. зүйл, 1947 оны Итали улсын үндсэн хууль 83. зүйл, 1944 оны Исланд улсын үндсэн хууль 3. зүйл, 1975 оны Грек улсын үндсэн хууль 133. зүйл, 1975 оны Португал улсын үндсэн хууль 30. зүйл, 1982 оны Турк улсын үндсэн хууль 101. зүйл.

[3] 1964 оны 6 сарын 16-ны өдрийн Ерөнхийлөгчийн эрх үүргийн ерөнхий хууль.

[4] 1937 оны Ирланд улсын үндсэн хууль 12. зүйл.

[5] 1900 оны Австрали улсын үндсэн хууль 2. зүйл.

[6] 1900 оны Австрали улсын үндсэн хууль 2. зүйл.

иргэн болсон хүмүүс ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээд болох боломжгүй. Финланд улсын үндсэн хуулинд мөн адил зөвхөн уг улсад төрсөн хүн л ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээд болох боломжтойг хуульчилсан байна. Грек улсын үндсэн хуулинд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээд болоход "эцгээс эхлэн цэвэр Грек удамтай байх[7]" ба "хамгийн багадаа таван жилийн турш Грек улсын иргэншилтэй байх" гэсэн шаардлагуудыг тусгасан. Португал улсын хувьд "гарал үүсэл нь Португал байх[8]" гэсэн шаардлагыг хангаж буй этгээд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээд байж болно хэмээн үзжээ. Харин Израйл улсад ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх этгээд Израйл улсын иргэншилтэй байна гэж үндсэн хуулиндаа тусгажээ.

**2. Оршин суугаа газар:** Израйлд ерөнхийлөгчөөр сонгогдох этгээд тус улсын иргэн байхын зэрэгцээ оршин суугч нь байх гэсэн шаардлага мөн тавигдаж байдаг. Уг шаардлага Израйл улсын 1964 оны 6 сарын 16-ны өдрийн Ерөнхийлөгчийн эрх үүргийн тухай ерөнхий хуулийн 4. бүлэгт тусгагдсан байдаг. АНУ-ын хувьд ерөнхийлөгчөөр сонгогдох этгээд хамгийн багадаа 14 жил уг улсад оршин суусан байх шаардлагатай хэмээн үндсэн хуулийнхаа 2.1.4 дэх хэсэгт заасан.

**3. Сонгох эрх:** Зарим улс оронд ерөнхийлөгчөөр сонгогдох этгээд парламентийн сонгуульд сонгох, сонгогдох эрхтэй байхыг чухалчилж үздэг. Жишээ нь Герман, Австрали, Исланд, Грек улсуудад ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрх бүхий этгээд парламентийн сонгуульд сонгох эрх эдлэх боломжтой этгээд байх ёстой юм.

**4. Иргэний болон Улс төрийн эрх эдлэх чадамжтай байх:** Итали улсад ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх этгээд иргэний болон улс төрийн эрх эдлэх чадамжтай байх ёстой.

**5. Нас:** Насны талаарх ойлголт ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх этгээдийн хувьд улс орон бүрт хамгийн энгийн шалгуур мөн. Улс орнуудад ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхийн тулд тодорхой насанд хүрсэн байх ёстой.

Тухайлбал:

1) 1929 оны Австри улсын үндсэн хууль, 1937 оны Ирланд улсын үндсэн хууль, 1944 оны Исланд улсын үндсэн хууль, 1976 оны Фортугал улсын үндсэн хуулиудад 35 насанд хүрсэн байхыг тусгасан байдаг.

2) 1949 оны Герман улсын үндсэн хууль, 1975 оны Грек улсын үндсэн хууль, 1982 оны үндсэн хуулиудад 40 насанд хүрсэн байхыг тусгасан байдаг бол 1992 оны Монгол улсын үндсэн хуульд 45 нас, 1947 оны Итали улсын үндсэн хуульд 50 насанд хүрсэн байхыг тус тус шаарддаг байна. Харин 1999 оны Финланд улсын үндсэн хууль, 1958

[7] 1975 оны Грек улсын үндсэн хууль 31. зүйл, (Be of Greek descendence from the father's line).

[8] 1975 оны Португал улсын үндсэн хууль 125. зүйл, (Portuguese by origin port).

оны Франц улсын үндсэн хууль болон Израйл улсын 1964 оны 6 сарын 16-ны өдрийн ерөнхийлөгчийн эрх үүргийн тухай ерөнхий хууль зэрэгт ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх этгээдийн насны доод хязгаарыг тусгаж өгөөгүй. Уг улсуудад ерөнхий байдлаар тусгагдсан сонгох, сонгогдох эрх үүсэх насыг мөн адил ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх насны хязгаар хэмээн үздэг байна. Иймд Франц улсын хувьд сонгуулийн тухай хуульд зааснаар ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх бүхий этгээдийн насны доод хязгаар 23 нас [9] байна хэмээн хуульчилсан байдаг байна.

**6. Боловсролын байдал:** 1982 оны Турк улсын үндсэн хуулинд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрх нь дээд боловсрол эзэмшсэн этгээдэд нээлттэй [10] болохыг тусгасан байдаг бол дээр дурдсан барууны ардчилсан засагтай улс орнууд болон Монгол улсын үндсэн хуулинд нарийвчлан заасан хэсэг байдаггүй юм.

**7. Сөрөг хүчин зүйлс:** Үндсэн хуулиудад зарим этгээдийн ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрхийг нь хязгаарласан байдаг. Тухайлбал Мальт улсад улсын дээд шүүхийн шүүгчид ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрхгүй [11] . Австри, Франц улсуудад хаан удмын сурвалжит гэр бүлийн өв залгамжлагч болох этгээдийг ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх эрхгүй хэмээн үздэг[12] бол 1947 оны Итали улсын үндсэн хуулинд "Савойа-н гэр бүл(*Casa Savoia*[13])"-ийн гишүүн этгээд ерөнхийлөгчийн сонгуульд болон бусад сонгуулиар сонгогдож очих төрийн албанд орохыг хориглосон байдаг[14].

## II. Сонгуулийн тогтолцоо

Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо нь улс орнуудын засаглалын хэлбэрээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. Ерөнхийлөгчийн болон хагас ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад ерөнхийлөгч тухайн улсын иргэдийн санал хураалтын үр дүнд сонгогдсон байдаг бол парламентын засаглалтай улс орнуудад ерөнхийлөгч парламент болон тусгайлан бий болгосон комиссийн зүгээс сонгогдоно.

### 1. Ерөнхийлөгчийн болон хагас ерөнхийлөгчийн засаглалтай улс орнуудад ерөнхийлөгчийг сонгох тогтолцоо

АНУ ерөнхийлөгчийн засаглалын тогтолцоог сонгодог хэлбэрээр хөгжүүлж буй улс орнуудын хамгийн бодит жишээ юм. Австри, Финланд, Ирланд, Исланд, Португал, Франц улсууд нь хагас ерөнхийлөгчийн засаглалын тогтолцооны сонгодог хэлбэрт

---

[9] Jean Gicquel, Droit constitutionnel et institutions politiques, Paris, Montchrestien, 1999 он, 526-р тал.

[10] 1982 оны БНТУ-ын Үндсэн хууль 102.3үйл, www.adalet.gov.tr/duyurular/2011/eylul/anayasalar/1982.pdf.

[11] Мальт улсын Үндсэн хууль 48.2 зүйл, Anne Twomey, "Methods of Choosing a Head of State", www.aph.gov.au/library/pubs/bp/1997-98/98bp12.htm.

[12] 1929 оны Австри улсын үндсэн хууль 60.3 зүйл.

[13] en.wikipedia.org/wiki/House_of_Savoy, (29.01.2017).

[14] 1947 оны Итали улсын үндсэн хууль.

багтана. Эдгээр засаглалын тогтолцоонд ерөнхийлөгч ард, иргэдийн санал хураалтаар сонгогдоно. Ерөнхийлөгч нь ард, иргэдийн санал хураалтын үндсэн дээр сонгогдож байгаа нь энгийн нэг тогтолцоо биш бөгөөд энэ нь тухайн улсын засаглалын хэлбэрт шууд болон шууд бус байдлаар нөлөөлхүйц чухал өөрчлөлт юм.

Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн сонгууль 11-р сарын эхний долоо хоногийн мягмар гарагт болдог [15]. Энэхүү сонгуульт өдөр ерөнхийлөгч шууд байдлаар сонгохгүй харин ерөнхийлөгчийг сонгох төлөөний сонгогчид тодорхой болох юм. Хот болгоноос сонгогдсон төлөөний сонгогчид *(electoral college)* нийтдээ 538 хүн байна. Энэхүү төлөөний сонгогчид 12-р сарын хоёр дахь долоо хоногийн даваа гарагт ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтанд оролцоно[16]. Эдгээр үйл ажиллагааны дараа 1-р сарын 6-ны өдөр санал хураалтын дүн ил тод болж төлөөний сонгогчидийн зүгээс их санал авсан сонгогдогч сонгогдсоныг төлөөлөгчид зарлана.

Австри, Финланд, Ирланд, Исланд, Португал болон Франц улсуудад ерөнхийлөгч шууд байдлаар ард, иргэдийн санал хураалтаар сонгогддог. Франц, Австри, Португал болон Финланд улсуудад ерөнхийлөгчөөр сонгодохын тулд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж буй сонгогдогч ард иргэдийн санал хураалтын дийлэнх хувийг авсан байх ёстой бөгөөд эхний шатанд ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн хэн хэн нь сонгогчдын дийлэнх хувийн саналыг аваагүй бол, 14 хоног буюу хоёр хүртэлх долоо хоногийн дараа хоёр дахь сонгуулийг дахин авна. Энэ шатанд эхний шатанд хамгийн их санал авсан 2 сонгогдогч оролцох бөгөөд мэдээж сонгогчдын дийлэнх хувийн саналыг авсан сонгогдогч ялалт байгуулах болно. Ирландад бол “шилжүүлж болохуйц цорийн ганц санал хураалтийн систем *(single transferable vote)*” байдаг учир ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөгчдийн нэг нь л сонгогчдын дийлэнх хувийн саналыг авдаг байна. Исландад ерөнхийлөгчийн сонгууль мажоритар буюу сонгогчдын дийлэнх хувийн саналыг авсан этгээд ялагчаар тодордог систем бус сонгуулийн пропорционал системийг ерөнхийлөгчийн сонгуульд хэрэглэдэг байна. Өөрөөр хэлбэл Исландад эхний буюу зөвхөн нэг шатлалтай сонгуульд хамгийн их санал авсан сонгогдогч ерөнхийлөгч болно.

Финланд, Ирланд, Исланд улсуудад ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх нэр дэвшигч нэгээс илүүгүй байвал сонгууль явуулахгүй ба уг нэр дэвшигч ерөнхийлөгч болно. Энэхүү үйл явц нь намууд нэг нэр дэвшигч дээр харилцан

[15] Laurence H. Tribe, American Constitutional Law, New York, Foundation Press, 2000 он, 169, 170-р тал; Louis Favoreu et al., Droit constitutionnel, Paris, Dalloz, 1998 он, 582-р тал.

[16] Marie France Toinet, Le système politique des Etats-Unis, Paris, PUF, 1990 он, 57-р тал.

тохиролцсоны үндсэн дээр бий болно[17].

**2. Парламентийн засаглалтай улс орнуудад ерөнхийлөгчийг сонгох тогтолцоо**

Парламентийн засаглалтай улс орнуудад ерөнхийлөгчийг сонгох олон төрлийн арга зам байдаг. Тухайлбал парламентийн гишүүдийн сонголтоор болон тусгайлан бий болгосон комиссийн сонголтоор ерөнхийлөгч сонгогддог бол зарим улсад ерөнхийлөгчийг сонгох бус томилдог байна.

**1) Парламентийн сонголт**

Израйл, Грек зэрэг улсуудад ерөнхийлөгч парламентийн зүгээс сонгогддог. Мөн Турк улс 2014 оны 8-р сарын 10 хүртэл мөн адил ерөнхийлөгчөө парламентээс сонгож ирсэн.

**2) Тусгайлан бий болгосон комиссийн сонголт**

Зарим улсуудад ерөнхийлөгч парламентийн зүгээс бус зөвхөн ерөнхийлөгчийг сонгох зорилгоор тусгайлан бий болгосон комисс*(electoral college)*-ийн зүгээс сонгогддог. Жишээлбэл 1949 оны Герман улсын Үндсэн хуулинд ерөнхийлөгч *(Bundesprasident)* тусгайлан бий болгосон "холбооны төөлөлөгчдийн *(Bundesversammlung)*" зүгээс сонгогддог. Энэхүү холбооны төлөөлөгчид нь Герман улсын парламентийн доод *(Bundestag)* болон дээд *(Bundestrat)* танхимаас бүрддэг[18]. 1947 оны Итали улсын Үндсэн хуулинд ерөнхийлөгчийг мөн тусгайлан бий болгосон "сонгох зөвлөл"-өөс сонгодог байна. Энэхүү зөвлөл нь парламентийн 2 танхимаас сонгогдсон гишүүд болон бүс нутгуудыг төлөөлсөн 58 гишүүнээс бүрднэ. Бүс нутаг болгоноос 3 төлөөлөгч төлөөллийн үүрэг гүйцэтгэдэг. Францад 1962 оны 11-р сарын 6-ны өдөр 1958 оны Үндсэн хуулийн 6-р зүйлийг өөрчилсөн энэ зүйлд ерөнхийлөгчийг парламентийн гишүүд болон мужуудын парламентийн гишүүд, хотын зөвлөлийн гишүүд мөн иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга зэргээс бүрдүүлсэн бүлэглэлээс сонгодог байна[19].

**3) Томилох байдлаар сонгох**

Энэхүү өвөрмөц арга барил нь Авсрали улсад хэрэгждэг байна. 1900 оны Австрали улсын Үндсэн хуулинд "Ерөнхий засаг дарга *(Governor-General)"* гэгдэх ерөнхийлөгч, Англи улсын Хатан хааны зүгээс томилогдож үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү томилгоо нь 1926, 1939 оны Хаант засаглалын бага хурлыг үндэслэн Австрали улсын ерөнхий сайдын хүсэлтээр явагддаг[20]. Өөрөөр хэлбэл Австрали улсын ерөнхийлөгч буюу

[17] Constance Grewe ve Hélène Ruiz Fabri, Droits constitutionnels européen-nes, Paris, 486-р тал.

[18] Christian Autexier, Introduction au droit public allemand, Paris, PUF, 1997он , 53-р тал; Bernard Chantebout, Droit constitutionnel et science politique, Paris, Armand Colin, Onbirinci Baskı, 1994 он, 353-р тал.

[19] Энэхүү бүлэглэл нь 80.000 орчим хүнээс бүрддэг; Elisabeth Zoller, Droit constitutionnel, Paris, PUF, 1999 он, s.457.

[20] https://en.wikipedia.org/wiki/Presidential_system.

ерөнхий засаг даргыг тус улсын ерөнхий сайд томилдог гэхэд буруудахгүй байх. 1986 оны Шинэ Зеландын Үндсэн хуулинд ерөнхийлөгч буюу ерөнхий засаг дарга Англи улсын хатан хааны зүгээс томиллогддог бөгөөд ерөнхий засаг дарга нь Хатан хааны төлөөлөгч байна хэмээн тусгасан.

**Парламент болон тусгайлан бий болгосон комиссийн зүгээс ерөнхийлөгчийг сонгох үйл ажиллагаандаа удирдлага болгодог анхан шатны зарим хэрэгжүүлбэл зохих арга дүрэм, журмууд**

Ерөнхийлөгчийг парламент болон тусгайлан бий болгосон комиссийн зүгээс сонгоход зарим баримталбал зохих дүрэм, журам эдгээрээс дурдвал:

**Нууц санал асуулга:** Ерөнхийлөгчөө парламентийн зүгээс сонгодог Израйл, Итали болон Грек улсуудад парламент дотроо нууц санал асуулга *(secret ballot)* явуулах аргыг хэрэгжүүлдэг [21] . Уг аргыг хэрэгжүүлэх учир нь ерөнхийлөгчийн хараат бус байдлыг хангах болон уг санал асуулгыг улс төрийн намуудын дарамтнаас ангид байлгахад оршдог.

**Олон шатлалтай сонгууль:** Герман, Израйл, Итали, Грек улсуудад парламент болон тусгайлан бий болгосон комиссийн зүгээс хийгдэж буй ерөнхийлөгчийн сонгууль олон шатлалтай явагдах магадлалтай байдаг. Дээрх улсуудын үндсэн хуулиндаа сонгуулийн эхний шатанд дийлэнх олонх буюу хуульд заасан хувьд хүрэхгүй бол сонгууль хоёр дахь шат цаашлаад гурав дөрөв дүгээр шатанд шилжих нөхцөл байдлыг тусгаж өгсөн байдаг.

**Сонголт хийхэд шаардагдах санал:** Олон шатлалтай сонгуулийн аргыг хэрэгжүүлдэг улс орнууд ихэвчлэн сонгуулийн эхний болон хоёр дугаар шатанд нэг нэр дэвшигчийн ерөнхийлөгч болход ердийн олонхын *(qualified majority)* саналыг харгалзан үздэг бол мөн энэ нь хуульд заасан хувьд хүрээгүй бол гурав дахь шатанд дийлэнх олонхын *(absolute majority)* саналыг харгалзан үздэг. Зарим тохиолдолд улс орнууд ердийн олонх болон дийлэнх олонхын саналаар ерөнхийлөгчөө сонгож чадаагүй нөхцөлд дараагийн шатанд сонгуулын пропорциональ системүү шилжих боломжтойг үндсэн хуулиндаа тусгасан байдаг байна. Итали улс үндсэн хуулиндаа сонгуулийн хямрал тохиолдвол пропорциональ системүү шилжих боломжтойг тусгаагүй учир 1971 онд Итали улсын ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч сонгогчдийн ердийн олонхын санал болон дийлэнх олонхын саналыг авч чадахгүй байсаар уг сонгууль нийт 23 шатлал хүртэл үргэлжилсэн юм[22].

1961 оны Турк улсын үндсэн хуулинд ерөнхийлөгчийн сонгууль эхний болон хоёр дугаар шатанд нийт сонгогчдын гуравны хоёрынх нь санал байх ёстой бөгөөд хэрэв энэ нөхцөл байдал хангагдахгүй бол

[21] 1947 оны Итали улсын Үндсэн хууль 83.3 зүйл, 1982 оны Турк улсын Үндсэн хууль 102.1 зүйл, 1975 оны Грек улсын Үндсэн хууль 35 зүйл.

[22] Эцэст нь 1971 оын 12 сарын 24-ны өдөр Леоне Жованни (Giovanni Leone XE "Leone") Итали улсын ерөнхийлөгчөөр сонгогдсон юм.

гурав дугаар шатанд дийлэнх олонхын саналаар ерөнхийлөгч сонгогдохыг хуульчилж өгсөн байдаг мөн сонгуулийн хямрал бий болвол авах арга хэмжээг хуульчлаагүй учир Турк улс 1980 оны 3 сарын 12 ноос мөн оны 9 сарын 12-ны өдөр хүртэл парламентийн зүгээс ерөнхийлөгчийг сонгож чадахгүй байсаар улс төрийн хямрал бий болсон юм[23].

Турк улс дээр дурдсан сонгуулийн хямралыг 1982 оны үндсэн хуулиндаа шийдвэрлэх арга замыг оруулж өгсөн юм. Энэ нь сонгуулийн эхний болон хоёр дугаар шатанд нэг нэр дэвшигчийн ерөнхийлөгчөөр сонгогдох явдал Турк улсын парламентийн нийт гишүүдийн гуравны хоёрын саналыг авсан байх шаардлагатай. Дээрх нөхцөл хангагдаагүй тохиолдолд сонгуулийн гурав дахь шатанд дийлэнх олонхын саналыг авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно. Гурав дахь шатанд дийлэнх олонхын санал хангагдаагүй бол сонгуулийн дөрөв дэх шат явагдана. Уг шатанд гурав дахь шатанд хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигч оролцоно. Уг шатанд мөн парламентийн гишүүдийн дийлэнх олонхын саналыг харгалзах ба уг шатнаас ерөнхийлөгч сонгогдохгүй бол Турк улсын парламент сонгуулийг дахин шинээр явуулхаар хуульчилсан байдаг[24].

Грек улс 1975 оныхоо Үндсэн хуулинд ерөнхийлөгчийг сонгох үйл явцыг маш нарийвчлан тусгасан. Эхний болон хоёр дугаар шатанд парламентийн гишүүдийн гуравны хоёрын санал хүрээгүй бол гурав дахь шат явагдана. Уг шатанд тавны гурав тэдгээрийн санал хүрэлцэхгүй бол, парламент дөрөв дэх шатны сонгуулыг явуулах ба уг сонгуульд сонгогчдын саналын тавны гуравын саналыг аваагүй бол парламент түр завсарлан тав хоногын дараа тав дахь шатны сонгуулиа явуулж уг шатанд дийлэнх олонхын саналыг авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно. Тав дахь шатанд дийлэнх олонхын санал хангалттай биш гэж үзвэл зургаа дахь шатны сонгууль явагдах ба уг шатанд тав дахь шатанд хамгийн их санал авсан хоёр нэр дэвшигч оролцож хамгийн их санал авсан нь ерөнхийлөгчөөр сонгогдоно.

Герман улс 1949 оны Үндсэн хуулиндаа ерөнхийлөгчийн сонгуулийн эхний хоёр шатанд ердийн олонхын санал бус дийлэнх олонхын саналыг харгалзан үзнэ хэмээн тусгасан байна. Эхний хоёр шатанд дийлэнх олонхын санал хангагдаагүй бол гурав дахь шатанд хамгийн их санал авсан нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно.

Израйлд зөвхөн эхний шатанд дийлэнх олонхын саналыг харгалзан үздэг. Дараагийн бүх шатанд дийлэнх олонхын санал хангагдах хүртэл шат болгонд хамгийн бага санал авсан нэр дэвшигч хасагдах байдлаар сонгууль үргэлжилж нэг нэр дэвшигч ерөнхийлөгчөөр сонгогдоно.

---

[23] Кемал Гөзлер "Турк улсын Үндсэн хуулийн эрх зүй" 2014 он Бурса хот 486-р тал.

[24] Кемал Гөзлер "Турк улсын Үндсэн хуулийн эрх зүй" 2014 он Бурса хот 485, 486-р тал.

## Дүгнэлт

Монгол улсад ерөнхийлөгчийн сонгууль дээр дурдсан улс орнуудтай адилхан байдлаар парламент болон тусгайлан бий болгосон комиссийн зүгээс сонгогдсон явдал Монголын төрт ёсны түүхэнд ганц тохиолдол байсныг хуульчид болон түүхчид мэднэ. Удахгүй болох ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөхөн Үндсэн хуулинд зарим нэгэн өөрчлөлт, шинэчлэл хийх асуудлууд маш ихээр яригдаж эхэлсэн мөн ард нийтийн төлөөлөлийн дунд зөвлөлдөх санал асуулгыг явуулж үр дүнг нь дүгнэснээр үндсэн хуулийн шинэчлэл, өөрчлөлт хийгдэх магадлал өндөр байна.

Хэрэв үндсэн хуулийн шинэчлэл, өөрчлөлт хийгдвэл улс орны засаглалын хэлбэрийг солих хандлага өндөр байгаа нь ажиглагдаж байна. Одоогийн Монгол улсын засаглалын хэлбэр нь парламентийн засаглалтай бөгөөд уг засаглалын хэв шинжийг агуулдаг гэвч ерөнхийлөгчөө сонгох арга барил нь ерөнхийлөгчийн засаглал болон хагас ерөнхийлөгчийн засаглалын шинж чанарыг агуулдаг. Ерөнхийлөгчийн засаглалтай улс оронд ерөнхийлөгчийн ард, иргэдийн саналаар сонгодог явдал нь ард иргэдийн сонголтоор гарч ирсэн засгийн газрын тэргүүн түүний эсрэг түүнд харилцан хяналт тавих мөн ард иргэдийн сонголтоор гарч ирсэн хууль тогтоох дээд байгууллагын гишүүдтэй адил хэмжээний эрхтэй байлгах үүднээс ерөнхийлөгчөө ард иргэдийн сонголтын үндсэн дээр сонгодог. Уг үйл явц нь Монтескьегийн бий болгосон төрийн эрх мэдэл хуваарилах онолтой нягт холбоотой юм.

Гэвч Монгол улс Үндсэн хуулийн шинэчлэл өөрчлөлтөнд төрийн эрх мэдэл хуваарилалтын онолыг төдийлэн чухал хэлбэрээр тусгах бус хуучин хэв шинжийг агуулж ерөнхийлөгчөө хууль тогтоох дээд байгууллагаасаа сонгодог хэлбэрийг бий болгоно гэсэн нөхцөл байдлууд хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр ихээхэн дурдагдаж байгаа нь судлаач миний хувьд оновчгүй болохыг дээр дурдсан улс орнуудын ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын талаархи харьцуулалтаар нотлохыг оролдсон болно.

## Ашигласан эх сурвалж, ном зүй:


1. Монгол улсын Үндсэн хууль 1992
2. Холбооны бүгд найрамдах Герман улсын Үндсэн хууль
3. 1947 оны Итали улсын Үндсэн хууль
4. 1982 оны Турк улсын Үндсэн хууль
5. 1975 оны Грек улсын Үндсэн хууль
6. 1975 оны Португал улсын үндсэн хууль
7. 1982 оны БНТУ-ын Үндсэн хууль
8. Мальт улсын Үндсэн хууль
9. 1929 оны Австри улсын үндсэн хууль .



**Д.БАДАМЦЭЦЭГ**
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

# ШҮҮХИЙН СОЦИОЛОГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГУУД

**Хураангуй:** Шүүхийн социологийн судлагааны орчин үеийн чиг хандлагуудыг дурьдаж тэдгээрийг нэгтгэн дүгнэх улмаар шүүхийн социологийн судлах зүйлийн сонголтыг барууны хэв маягт ойртуулах талаархи санал бодлоо уг өгүүлэлд тусгасан болно.

**Түлхүүр үг:** эрх зүйн социологи, социологи, шүүх, шүүн таслах ажиллагаа, эрх зүйн зарчим, шүүхийн статистик, шүүгч, эрх зүйн орчин, шүүгдэгч, хэргийн оролцогч, дүн шинжилгээ

## Үндсэн хэсэг

Социологийн шинжлэх ухааныг үндэслэгчдийн нэг болох Францын эрдэмтэн Э.Дюркгейм одоогоос 100 гаруй жилийн өмнө: "....төр засгийн зүгээс өөрийн батлан гаргасан албан ёсны хууль, эрх зүйн актуудынхаа тусламжтайгаар хуулийг хэрэгжүүлнэ. Төрийн үүрэг бол хамгийн ерөнхий хууль тогтоолыг батлан хэрэгжүүлж, нийгмийн оршин тогтнох үндсэн нөхцлийг хангах явдал мөн ажээ. Харин мэргэжлийн бүлэг бол нийгмийн гишүүдийг нэг бүрчлэн хамарч чаддагийн зэрэгцээ, тэдний ашиг сонирхол, үзэл бодлыг нарийн мэдэрч, тэдний зан үйлийг хянаж байдгаараа нийгэмд гэр бүлийн гүйцэтгэдэг үүрэгтэй нэгэн адил зохицуулалтын функцийг хэрэгжүүлж чадна. Иймд социологийн шинжлэх ухааны мэдлэгийн нэг үндсэн чиглэл бол хууль зүйн социологи тэр дундаа шүүхийн социологи юм[1]." гэж үзэж байв.

Эрх зүйн хэм хэмжээ нь аяндаа бий болж нийгмийн харилцааг шууд зохицуулж чадахгүй билээ. Иймд эрх зүйн орчинг бүрдүүлэх түүний хэрэгжилтийг хангахын тулд төрөөс эрх олгогдсон тодорхой эрх мэдэл бүхий этгээдүүдийн оролцоог шаардах ба ингэснээр нийгмийн харилцааг хамгаалах, эрх зүйн хэм хэмжээг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зэрэг асуудлыг шийдэх боломжтой болох юм. Өөрөөр хэлбэл эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх этгээд нь уг хэм хэмжээг тайлбарлаж, тухайн харилцаанд аль хэм хэмжээг хэрэглэх боломжтойг сонгон хэрэглэх замаар нийгмийн харилцааг зохицуулж хамгаална гэсэн үг юм. Эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх эрх бүхий олон этгээдүүд байх бөгөөд эдгээрээс шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, түүний албан тушаалтны эрх зүйн хэм хэмжээг хэрхэн хэрэглэж байгаа бодит байдал, хараат бус бие дааж шийдвэр гаргахад нөлөөлж буй арга хэрэгсэлийн талаар үнэн зөв дүгнэлт хийх, цаашид боловсронгуй болгох арга замуудыг шүүхийн социологи тодорхойлдог.

[1] https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D0%BC%D0%B8%D0%BB%D1%8C_%D0%

Шүүхийн социологи бол эрх зүйн социологийн бие даасан томоохон салбаруудын нэг нь юм.

Шүүхийн социологи нь шүүхээс эрх зүйг хэрэглэх үйл явц буюу шүүхийн шүүн таслах үйл ажиллагааг судлана гэж томъёолж буй боловч шүүн таслах үйл ажиллагааны чухам аль талыг судлах вэ гэдэгт эрх зүйн социологийг судлаачдын үзэл бодол жигдрээгүй байна. Тухайлбал, Францын эрдэмтэн Ж.Карбонье "Шүүхийн социологийн төвд шүүхийн шийдвэр, түүнийг хэрэгжүүлэх үйл явц байна" [2] . Харин "Хууль дээдлэх зарчим" бодитой хэрэгждэг нийгэм гэж үздэг АНУ-ын иргэдийн хувьд тэдний нийгмийн амьдралын олон талт харилцааг зохицуулж чадсан хуулийн тогтолцоонд тулгуурласан шүүхийн байгууллагаар өөрсдийн эрх ашгийг хамгаалуулахыг илүүтэй үздэг бөгөөд АНУ-ын эрх зүйн социологич Леон Мехью "Шүүхийн сохциологи шүүн таслах ажиллагааны явцад шүүгчид үзүүлж буй нийгмийн нөлөөлөл, дарамт, шахалтыг илрүүлэх зорилготой" [3] гэжээ.

Европын орнуудад иргэдийн эрх, эрх чөлөөг хангах, хууль ёсыг бэхжүүлэхэд шүүх эрх мэдлийн тогтолцооны гүйцэтгэх үүрэг аль ч нийгэмд өндөр ач холбогдолтой гэж үзэж хууль зүйн их дээд сургуулийн эрх зүйн сургалтын хөтөлбөрт эрх зүйн социологийг бие даасан хичээл, судлагдахуун болгон заадаг байна. Мөн Монгол улсын хууль зүйн дээд боловсрол олгодог сургуулиудын хөтөлбөрт "Эрх зүйн социологи" хичээлийг тусган түүний нэгээхэн судлагдахуун хэсэгт "Шүүхийн социологи"-ийг заадаг байна[4].

Нийгмийн хөгжлийн зүй тогтол, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилтэй уялдан орчин үед шүүхийн социологийн дүн шинжилгээний дараах чиг хандлагууд бий болсон байна. Үүнд:

**1. "Хууль шүүхийн өмнө иргэд тэгш эрхтэй байх зарчим"-ын хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийх.** Энэ нь үйлдэгдсэн эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүнд тохирсон ял шийтгэл оногдуулж буй эсэхэд дүн шинжилгээ хийх юм. Иргэд, олон нийтийн дунд гэмт хэрэгт тохирсон ял шийтгэлийг оноосон эсэх талаар маргаан гарч байдаг тул шүүхээс ял оногдуулахдаа хэргийн нөхцөл байдлыг бодитойгоор харгалзан үзэж эрх зүйн зөрчил үйлдсэн этгээд хэн байхаас үл хамааран үйлдэгдсэн эрх зүйн зөрчлийн шинж байдалд тохирсон ял шийтгэлийг дотоод итгэлээрээ хуульд нийцүүлэн оноосон эсэхийг социологийн судалгааны аргуудыг ашиглан дүн шинжилгээ хийх юм. Эрх зүйн онолын үүднээс тайлбарлавал хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдсэн эсэх, хэргийг хянан

[2] Карбонье Ж. Юридическая социология.М.1986.с.52

[3] Мехью Л.Социология права. Америнканская социология.М.1972.с222-223.

[4] МУИС-ийн ХЗС-ийн хувьд эрх зүйн бакалаврын түвшинд магистр, докторын сургалтын хөтөлбөрт эрх зүйн социологи, эрх зүйн социологийн чиг хандлага, онол арга зүй гэх мэтээр томъёологдон тусгагджээ. Мөн "Шихихутаг", "Их Засаг" зэрэг их сургуулиудын эрх зүйн бакалаврын хөтөлбөрт тусгагдсан байна.

шийдвэрлэхдээ эрх зүйн ерөнхий болон салбарын зарчмыг удирдлага болгосон эсэхэд хяналт тавина гэсэн утгатай юм.

**2. Шүүхийн алдааг судлах.** Шүүхийн алдаа гэдэг нь шүүхээс шүүн таслах ажиллагааны сэтгэл зүй,/ шүүгчийн тухайн үйлдэлд хандах хувийн сэтгэл зүйн онцлог/ мэргэжлийн ур чадвар дутагдсанаас тухайн эрх зүйн зөрчлийн бүрэлдэхүүнийг буруу тодорхойлох, алдаатай зүйлчлэх, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц буруу байх зэргийг ойлгодог.

Шүүхийн алдаатай шийдвэр хэлмэгдүүлэлт авчирдаг[5]. Ялангуяа цаазаар авах ялыг оноохдоо гэмгүй иргэний амийг хууль шүүхийн ажиллагааны алдаанаас болж төр егүүтгэсэн байх, эсвэл егүүтгэх шахаж байсан зэрэг шүүхийн ноцтой алдаанууд гарч байсан удаатай. Тухайлбал, Завхан аймгийн харъяат Ч.Эрдэнэ-Очирыг 6 жил 8 сар 23 хоног мөрдөн шалгаж, 6 удаа прокурор түүнд яллах дүгнэлт бичиж, 3 удаа шүүх түүнд цаазаар авах ял оноосон байдаг. Харин дээд шатных нь шүүхийн магадлангаар түүний хэрэг хэрэгсэхгүй болсон[6].

Иймд шүүх эрх мэдлийн байгууллагуудын практикийг судалж, алдааг илрүүлэх, засч залруулах, алдаанаас зайлсхийх талаар нэгдсэн практикийг тогтоож, санал, зөвлөмжийг хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулдаг байгууллагуудын үйл ажиллагааны үндсэн чиглэл юм.

**3. Хуулийн социологи тайлбар.** Энэхүү тайлбарын зорилго нь эрх зүйг хэрэглэж буй албан тушаалтануудад эрх зүйн хэм хэмжээний агуулга, мөн чанарыг зөв ойлгож хэрэглэхэд оршино. Францын эрдэмтэн Ж.Карбонье “Хууль муу байна гэж үзэх үзэл нь түүниг сахихгүй бай гэсэн үг биш, харин өөрчлөх хэрэгтэй гэсэн санал юм. Шүүгч хуулийн цорын ганц тайлбарлагч биш... гэхдээ тэд л тайлбарт заавал үйлчлэх хүчийг өгнө”[7] гэжээ.

Хууль тогтоомжийн давхардал, ойлгомжгүй байдал, эрх зүйн хийдлийг арилгах зорилгоор хуулийг тайлбарладаг. Хуулийн тайлбарыг боловсруулахдаа эрх бүхий субьект нь эрх зүйн зөрчлийн зүйлчлэлийг судалдаг бөгөөд ингэхдээ тухайн процессын ажиллагаанд оролцогчдоос гаргасан шийдвэрт анализ хийдэг. Иймд шүүгчийн гаргасан шийдвэр нь хуулийг тайлбарлах үндсэн эх сурвалж болох бөгөөд цаашид хуулийн тайлбарыг харгалзан үзэж шийдвэр гаргах боломжийг шүүгчдэд олгодог. Гэхдээ хуулийн тайлбар нь хуулийг орлохгүй бөгөөд хуулийн зүйл заалт дутагдвал шүүгч эрх зүйн жишиг болгон ашиглаж эрх зүйн зарчимд нийцүүлэн шийдвэр гаргах эрх нь нээлттэй юм.

---

[5] Шүүхийн алдааны талаар доктор профессор Г.Совд “хэрэв шүүх алдаа гаргасан тохиолдолд цагаатгалаа ч гэсэн уг алдааг засаж залруулах аргагүй байдагт цаазар авах ялын аюул оршино” гэж Монгол улсын Үндсэн хуулийг тайлбарласан тайлбартаа дурьджээ.

[6] http://www.amnesty.mn/mn/our-work/bd32e0338345a917ece2b75f0f800ea2fa63fa0a

[7] Карбонье Ж. Юридическая социология.М.1986.с.308

**4. Хавтаст хэргийг судлах замаар нийгмийн харилцаанд дүн шинжилгээ хийх.** Хавтаст хэргийг шинжлэн судлах нь нийгмийн хөгжлийн аль нэгэн шатан дахь нийгмийн ухамсар, сэтгэл зүй, ёс суртахууныг танин мэдэх боломжийг бий болгодог. Хавтаст хэргийг шинжлэн судлах дараах аргууд байдаг. Үүнд:

А. Шүүхийн практик буюу шүүгчийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж буй байдлыг судлана. Эрх зүйн зөрчлийн хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн хэм хэмжээ, хууль тогтоомжийг хэрхэн хэрэглэснийг судалж, бичмэл болон бичмэл бус нотлох баримтууд /гэрч, хохирогчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт/ хангалттай эсэх, түүнд үндэслэж шүүхийн шийдвэр гарсан эсэхийг судлана.

Мөн прокурорын яллах дүгнэлтэд бичигдсэн зүйлчлэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй тохирч байгаа эсэхэд анализ хийж, хууль зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл байгаа эсэх, хэт хатуу эсвэл хэт зөөлөн ял ногдсон эсэх, ял шийтгэлийг оногдуулахдаа эрх зүйн зарчмуудад тулгуурласан уу зэрэг эрүүгийн хариуцлагын хэм хэмжээг зөв хэрэглэсэн эсэхийг тогтооно.

Б. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн нийгмийн болон бусад хүчин зүйлийг судалж анализ хийх. Ингэхдээ гэмт хэргийн шалтгаан нөхцөл, үйл баримтад социологийн шинжилгээ хийнэ. Ийнхүү социологийн шинжилгээ хийснээр нийгмийн хөгжлийн тодорхой үе шатан дахь нийгмийн ухамсар, сэтгэл зүй, ёс суртахууны талаархи төлөв байдлын тухай мэдлэгтэй болно. Тухайлбал, 1930-аад оны үед БНМАУ-д шүүн таслах ажиллагаа нь шударга ёс, хууль дээдлэх, хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх гэх мэт олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээнүүдийг алдагдуулсан түүнийг зөрчсөн шийдвэрүүд гарч хилс хэргээр олон хүнийг цаазалжээ. Энэ нь ард түмний дунд төрдөө итгэхгүй байх, бие биенийгээ хардаж сэрдэх гэх мэт сөрөг сэтгэл зүйг төлөвшүүлсэн байна.

Францын эрдэмтэн Ж.Карбонье "Социологич өөрийн судалгаа шинжилгээндээ шүүхийн шийдвэрт тусгалаа олсон хувь хүмүүс хоорондын болон хувь хүний нийгмийн үзэгдлийн харьцаа, амьдралын тохироог авч үзэхийг эрмэлзэнэ. Шүүхийн аль ч шийдвэр нь зөрчидөөний үр дүн мөн. Зөрчилдөөн нь нийгмийн сэтгэл зүйн сонирхолтой үзэгдэл учраас тэдгээрийг судлах нь .... шүүхийн социологийн шинжилгээнд маш чухал юм"[8] гэжээ.

Ийнхүү шийдвэрлэгдсэн хавтаст хэргүүд нь нийгмийн ёс суртахуун, сэтгэл зүйд социологийн дүн шинжилгээ хийх суурь бааз болох бөгөөд цаашид шүүхээс хууль хэрэглэх арга зүйг боловсронгуй болгох, эрх зүйн зөрчлөөс урьдчилсан сэргийлэх, таслан зогсоох арга хэрэгслийг зөв сонгох нөхцөлийг бүрдүүлэх юм.

**5. Шүүгчийн зан үйлийн "хэвшмэл" байдалд хийх дүн шинжилгээ.** Шүүхийн социологи нь

[8] Мөн тэнд

сэтгэл судлалын шинжлэх ухаантай нягт холбоотой юм. Учир нь шүүгч тодорхой бие хүн бөгөөд түүний мэргэжлийн ёс зүй, зан үйлийг төлөвшүүлэхэд бие хүний хувийн сэтгэл зүй, зан үйл чухал нөлөөтэй байдаг. Шүүгч аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ эрх зүйн үнэт зүйлст итгэлтэй байж цагаатгах эсвэл яллах шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл шүүгчийн үйл ажиллагаанд шүүгчдэгчийн амьдрал ахуй, хувийн байдал, хувь хүний нууц зэрэг эмзэг асуудлууд хөндөгддөг тул хууль амьдралын шүтэлцээг хангахад анхаарах ёстой байдаг.

Шүүгчийн хэвшмэл зан үйлд хийсэн гадаадын зарим эрдэмтдийн судалгаанаас үзвэл шүүх хурлын явцад шүүгчийн сэтгэл зүйд шүүгдэгчийн гадаад төрх /царай зүс, бие бялдар/, шүүгдэгчийн мэдлэг боловсрол, мэргэжил нөлөөлдөг нь ажиглагджээ. Тухайлбал, АНУ-ын социологич Д.Мэйрсийн судалгаагаар "шүүгч нар гадаад төрхийн хувьд нүдэнд дулаахан, царайлаг, аядуу зөөлөн дуутай, боловсрол өндөртэй хүмүүст зөөлөн ханддаг, харин царай муутай нүдэнд хүйтэн, хахир хатуу дуутай, боловсролгүй хүмүүсийг ямар ч төрлийн гэмт хэрэг үйлдэх боломжтой хэмээн үзэж ширүүн ханддаг. Хэрэв шүүгдэгчийн хувийн байдал, царай зүс, түүний үзэж туулсан амьдрал шүүгчтэй төстэй байвал шүүгч түүнд аядуу зөөлөн хандаж хөнгөн ял оноох сэтгэгдэл төрдөг"[9] гэж ажиглагджээ.

Гэхдээ энэ бүхнийг шүүгчийн хэвшмэл зан үйлд хийсэн анализаар бүрэн дүүрэн нотлогдсон зүйл гэж хараахан үзэж болохгүй юм.

**6. Шүүхийн статистик тоо баримтад дүн шинжилгээ хийх.** Энэ эрх зүйн социологид 20-р зууны дунд үеэс яригдаж эхэлсэн бөгөөд 20-р зууны сүүлч үеэс эрх зүйн социологи дахь шүүхийн социологийн судлагдахуун мөн хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн билээ.[10]

Шүүхийн статистик нь шүүн таслах үйл ажиллагааны явц, нөхцөл байдлыг илэрхийлээд зогсохгүй, нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлогч эх сурвалж болдог.[11] Шүүхэд шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны тоо, шүүгчийн ачаалал, хэргийн үлдэгдэл зэрэг мэдээлэл нь шүүхээс үзүүлж буй шударга ёсны үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд шүүхийн социологийн судалгааны эх сурвалж болдог.[12] Тухайлбал, Шүүхийн статистик нь шүүхийн байршлыг оновчтой тогтоох, хүний нөөцийг зөв зохистой хуваарилах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, сэлгэн ажиллуулах, шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг хангах зэргийг судлан шинжлэнэ. Мөн шүүхийн статистик мэдээллийг шүүгдчдэд таниулсанаар шүүн таслах ажиллагааны нийтлэг төлөв байдлыг шүүгчид өөрөө ажиглаж өөрсдийн дүн шинжилгээг хийх, хөндлөнгийн судлаачдын судалгааны эргэлтэнд

[9] Мэйрс Д .Социальная психология. Спб М.1999.с.414.

[10] Richard J. Speak ''Statistics for the Courts'' 1990 pp.936

[11] Мөн тэнд

[12] Мөн тэнд

оруулах зэрэг ач холбогдолтой. Түүнчлэн иргэд олон нийт, хэргийн оролцогчид шүүхэд нэг хэргийг хянан шийдвэрлэхэд зарцуулж буй дундаж хугацаа, ажлын ачаалал, түүнээс гарах үр дүнг ямагт сонирхож байдаг тул шүүхийн статистик нь зөвхөн дотоодын хэрэгцээнд бус олон нийтэд ойлгомжтой байдлаар танилцуулж байх нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлэх нэг алхам байж болох юм.

Шүүхийн статистикийг анхлан боловсруулсан улсын нэг бол АНУ бөгөөд 1871 онд бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайланга боловсруулж гаргасан юм. Тус мэдээ нь нийт хүлээн авсан хэрэг, түүнээс шийдвэрлэсэн иргэний болон эрүүгийн хэрэг, тухайн онд шийдвэрлээгүй үлдэгдэл хэргийн тоо гэх зэрэг мэдээллийг агуулж байжээ.

Монгол Улсын хувьд Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн 2008 оны 17-р тогтоолоор батлагдсан “Шүүхийн статистикийн мэдээлэл, тайлан гаргах журам”-ын дагуу нийт 13 маягтаар шүүн таслах ажиллагааны тайлан мэдээг гаргаж байна. Цаашид шүүхийн статистик мэдээг боловсруулахдаа шүүн таслах ажиллагааны үзүүлэлтүүдийг хэрэг маргааны төрөл тус бүрээр нарийвчлан гаргах нь хэрэгцээ шаардлага тулгарч байна. Ингэснээр шүүхийн талаархи мэдээлэл үнэн зөв, нээлттэй болох, тухайн чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх чиглэлийг тодорхойлох, шүүхийн практикт тулгамдаж буй асуудлыг зөв тодорхойлох боломжтой болох юм.

**7. Шүүхийн ажлын талаарх олон нийтийн санаа бодолд дүн шинжилгээ хийх.** Шүүхийн үйл ажиллагааны үр нөлөө нь шүүн таслах ажиллагааны гүйцэтгэлээр тодорхойлогдохоос гадна шударга ёсны хэрэгжилт, нийгмийн ухамсар, дэг журам, эрх зүйн соёл хэрэгжиж байна уу гэдэг олон нийтийн итгэх итгэл, хүлээлтээр тодорхойлогдоно. Ард иргэд болон эрх зүйн зөрчил үйлдсэн этгээдүүдээс шүүхийн үйл ажиллагааны талаар судалгаа хийж түүнд дүн шинжилгээ хийх нь шүүхийн үйл ажиллагааг үр нөлөөтэй боловсронгуй болгох, түүнийг удирдах, шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмд шударга ёсыг тогтоох, хүний эрхийг дээдлэх чухал хүчин зүйл болох юм.

**8. “Шүүхийн хараат бус байдал”-д дүн шинжилгээ хийх.** Шүүхийн социологийн нэг зорилго нь эрх зүйн хэрэгжилтийг хангаж, шийдвэр гаргаж байгаа байгаа шүүгч нарт үзүүлэх нийгмийн дарамт, шахалтын хэлбэрийг судлах, түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх санал, зөвлөмж гаргахад оршдог.

Шүүхийн хараат бус байдлыг судлаачид “шүүхийн бие даасан хараат бус байдал”, “шүүгчийн хараат бус байдал” гэсэн хоёр талтай гэж үздэг. Шүүхийн хараат байдлын зарчим нь нэгдүгээрт, аливаа нэг шүүхийн процессын ажиллагаанд процедурын шударга ёсыг баталгаажуулах, хоёрдугаарт, ардчилал, түүний үнэт зүйлсийн хамгаалалтыг баталгаажуулах гэсэн

зорилготой. [13] Тодруулбал, шүүх бусад эрх мэдлээс хараат бие даасан, хяналт, тэнцвэртэй байснаар ардчиллын үнэт зүйлс, хүний эрх хамгаалагдах үндсэн механизм болох ач холбогдолтой бөгөөд үүнийг “шүүхийн бие даасан байдал”-ын зарчим гэнэ. Түүнчлэн шүүгч, шүүх бүрэлдэхүүн хараат бус алагчлалгүй байснаар иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхол тодорхой тохиолдолд хамгаалагдаж, олон нийтийн шүүхэт итгэх итгэл нэмэгдэх ач холбогдолтой бөгөөд үүнийг “шүүгчийн хараат бус байдал”-ын зарчим гэдэг.

Судлаачид шүүх бусад эрх мэдлээс хараат буй оршихын тулд дараах нөхцөлөөр хангагдсан байх ёстой гэж үзжээ. Үүнд:

- *Үндсэн хуулийн түвшинд шүүх бусад эрх мэдлээс хараат бус байх нь тунхаглагдсан байх ёстой.* Тухайлбал, Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх, шүүхийн шийдвэрийн халдашгүй , хүлээн зөвшөөрөгдсөн байх зэрэг зарчмуудыг зайлшгүй тусгасан байх ёстой.

- *Эрх зүйн баталгаа.* Энэ нь шүүх эрх мэдлийг баталгаажуулах зарчмыг Үндсэн хуульд тусгасан байх явдал юм. Тухайлбал, түр зуурын буюу тусгай шүүх байгуулахыг хориглох [14] , энгийн шүүхээс хэргийг шүүхийн бус байгууллагад шилжүүлэн авахгүй байх[15], шүүхийн шийдвэр хараат бус байх, бусад эрх мэдэл түүнийг хүндэтгэх зэрэг зарчимуудыг тусгасан байх ёстой. Түүнчлэн шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахсан бие даасан хуультай байх шаардлагатай юм.

- *Эдийн засгийн баталгаа.* Шүүх эрх мэдлийг байгууллага өөрийн хэрэгцээгээ өөрөө тодорхойлж төсвийн төслөө хууль тогтоох байгууллагад шууд өргөн мэдүүлэх, төсвийн төслөө батлуулах явцад эрхээ хамгаалах механизмтай байх, батлагдсан төсвөө өөрөө захиран зарцуулах, шүүх өөрийн байртай байх, шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалаар хангагдсан байх зэрэг нь түүнийг санхүүгийн хувьд бие даасан үйл ажиллагаа явуулах үндэс болж өгдөг ач холбогдолтой.

Европын орнуудад шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах бас нэг нөхцөл бол олон нийт, нийгмийн зүгээс үзүүлж буй дарамт шахалт мөн гэж тодорхойлсон бөгөөд энэ шүүхийн социологийн судлах зүйлийн нэгээхэн чухал хэсэг үзэх хандлага нилээд түгээмэл байна. Судлаачид шүүхийн хараат бус байдалд нөлөөлөх дараах төрлийн дарамт, шахалт байна гэж үзжээ. Үүнд:

- *Эрх мэдлийн зүгээс үзүүлэх дарамт шахалт.*

[13] Ш.Отгонцэцэг “Шүүхийн бие даасан байдлыг хангах арга зам” магистрын ажил.УБ.2015.х.8-аас дам ишлэв.

[14] Монгол Улсын Үндсэн хуулийн 47.2-т “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” хэмээн тусгажээ.

[15] Мөн тэнд

- *Олон нийтийн санаа бодлоос үзүүлэх дарамт шахалт.*

- *Хэвлэл, мэдээллийн хэрэгслийн зүгээс үзүүлэх дарамт шахалт.*

- *Гэмт этгээдүүдийн зүгээс үзүүлэх дарамт шахалт.*

- *Эдийн засгийн дарамт шахалт.*

Шүүхэд үзүүлэх дарамт шахалтын янз бүрийн хэлбэрүүд нь хууль дээдлэх зарчмыг хараат бусаар, чөлөөтэй хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл учруулдаг бөгөөд үүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх талаар санал зөвлөмж боловруулах нь шүүхийн социологийн нэг зорилт юм.

Шүүхийн социологи нь шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлийг тодорхойлоод зогсохгүй шийдвэрлэх арга замыг сонгох, хэрэгжүүлэх, үр дүнг тооцоход боломжийг нээн өгдөг эрх зүйн социологийн томоохон салбар болон хөгжиж байна.

**Дүгнэлт.**

Орчин үед эрх зүйн социологийн судлах зүйл нь нийгмийн харилцааны хөгжлийг даган нэмэгдэж судалгааны шинэ шинэ онол, хандлагуудаар баяжигдсаар байна. Тухайлбал, хууль сахиулах байгууллагын социологийн судалгааны нэг дэд хэсэг болох шүүхийн социологи нь барууны орнуудад эрх зүйн социологийн бие даасан институт болсон байна. Иймд шүүхийн социологийн судлах зүйлийг барууны орнуудын хэв маягт ойртуулах, тухайлбал, шүүхийн статистик мэдээ баримтыг судлах, шүүн таслах ажиллагааны журам, шүүгчдээс үйл ажиллагаагаа явуулж буй нийтлэг дүр төрх, тэдэнд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, эрх зүйн хүчин зүйлүүд тусгайлан судалж шүүхийн социологийн судалгааг өргөжүүлэх түүнийг боловсронгуй болгох, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх хэрэгцээ шаардлага манай улсад бий болжээ.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд эрх зүйн социологийн судалгааг хийх зайлшгүй шаардлагатай байдаг тул хууль сахиулах байгууллагын боловсон хүчин бэлтгэх сургалтын хөтөлбөрт "Эрх зүйн социологи" хичээлийг тусгаж өгсөнөөр сонсогч, суралцагчид онолын мэдлэгийг практикт хэрэглэх мэдлэг, ур чадварыг төлөвшүүлэх ач холбогдолтой юм.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль. "Төрийн мэдээлэл" сэтгүүл.УБ.1992. №1
2. Ш.Отгонцэцэг "Шүүхийн бие даасан байдлыг хангах арга зам" магистрын ажил.УБ.2015.
3. Карбонье Ж. Юридическая социология.М.1986.
4. Мехью Л.Социология права. Американская социология.М.1972.
5. Мэйрс Д .Социальная психология. Спб М.1999.
6. Richard J. Speak ''Statistics for the Courts'' 1990
7. https://mn.wikipedia.org/wiki/%D0%AD%D0%BC%D0%B8%D0%BB%D1%8C_%D0%



**С.ОЮУНЧИМЭГ**
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, ахмад

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬТ ЁСНЫ ТӨЛӨВШИЛ, ХЭРЭГЖИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

**Abstract:** In the modern world, the concept "Rule of Law" transferred into the concept "Constitutional law". The law has the final and top validity. The state power is originated from it is people. Government functions are limited by law. The laws are based on the human rights. Constitutional law is embodied through following concept, as representatives shall obey the Constitution while they execute their legislative powers. Nowadays, the concept "Constitutionalism" must find fulfillment as "Constitutional powers"

**Key words:** Constitutional provision, Constitutionalism, Constitutional Powers, Constitutional jurisprudence, Constitutional responsibility, Constitutional jurisprudence, Constitutional control, constitutional order regime

**Үндсэн хууль** гэдэг нь аливаа улсын нийгэм, эдийн засаг төрийн байгууламжийн эрх зүйн үндэс, хүний эрх эрх чөлөөг бататган бэхжүүлсэн хууль зүйн дээд хүчин чадалтай хамгийн гол тулгуур хууль юм.

**Үндсэн хуулийн мөн чанар.** Энэ нь Үндсэн хуульд чухам хэний эрх ашиг сонирхлыг илэрхийлж байна вэ? гэдгээр тодорхойлогдох бөгөөд жам ёсны онол ёсоор Үндсэн хуулийн мөн чанар нь ард түмний хүсэл зоригоор илэрхийлэгдэнэ хэмээн үздэг бол нормативистууд эрх зүйн хэм хэмжээний дээд хүчин чадал нь Үндсэн хуулийн мөн чанарын илэрхийлэл хэмээн үздэг байна.

Орчин үед Үндсэн хуулийн мөн чанар нь төрийн эрх мэдлийг хууль зүйн арга хэрэгслээр хязгаарлаж улмаар нийгмийн үнэт зүйлсийн нэг болох хүний эрх, эрх чөлөөг иш болгосон төрийн удирдлагын хэлбэрийг эрх мэдэл хувиарлах онолын дагуу бий болгож нийгмийн ашиг сонирхолд үйлчлэхэд оршино[1] хэмээн тодорхойлжээ. Тэгэхээр Үндсэн хуулийн мөн чанарын нэг илэрхийлэл болсон төрийн эрх мэдэл хувиарлах онолын мөн чанарыг авч үзье.

Төрийн эрх мэдэл хувиарлах онол нь төрийн удирдлагын боловсронгуй тогтолцоог хангах үүднээс бус, "хүний эрхийг хамгаалах механизмыг бүрдүүлэх" хэрэгцээ шаардлагаас урган гарсан.

Төрийн эрх мэдэл ямар нэг хязгаарлалтгүй байх нь дарангуйлал орших, хүний төрөлх эрх зөрчигдөх нөхцөл болсоор байсан тул хүний төрөлх эрхийг тунхаглах нь төрийн эрх мэдлийг хязгаарлах эхлэл юм.[2]

[1] Б.Нармандах "Үндсэн хуулийн эрх зүй". УБ., 2011 он.25-26-р тал

[2] Н.Лүндэндорж "Төрийн онол". УБ., 2008 он. 203-р тал

Эртний Грек, Ромд сэтгэгчид төрийн эрх мэдэл бие даасан хийгээд харилцан тэнцвэртэй байх асуудлыг бус нийгмийн зарим давхаргуудын хоорондын хөдөлмөрийн хуваарилалт зайлшгүй тухай, төрийн байгууллагуудын оршин тогтнох үндэс, бүрэлдэхүүн, зорилт, чиг үүргийн тухай авч үзэн, тэдгээрийн бүрэн эрхийг зааглахын чухлыг тэмдэглэж иржээ.

Жишээ нь: Платон эрх мэдэл хуваарилах онолын талаар "нийгмийн язгуур давхраа" хоорондын "хөдөлмөрийн хуваарь" гэсэн утгаар илэрхийлж, давхраа бүр бусдын хэрэгт оролцохгүй зөвхөн өөрт ногдсон хүрээнд ажиллаж хот улсынхаа хэрэгцээг хангаж байвал зохино гэжээ.

Мөн 17-18-р зууны үед Английн улс төрийн гүн ухаантан Дж.Локк хүний амьд явах эрх /Life/, эрх чөлөөтэй байх /Liberty/, өмчлөх эрх /Property/-ийг эзэн хаан ч хууль ч олгоогүй хүн хэнээс ч гуйж аваагүй өөрт нь л байдаг салшгүй төрөлх эрх гэж тунхаглажээ. Дж.Локкийн "LLP" онол Англий төдийгүй бүх Европ дахинаа түгэн дэлгэрч улмаар 1789 оны Францын **"Хүн ба иргэний эрхийн тунхаг"**-т хүний эрхийг хамгаалах гол механизм бол төрийн эрх мэдлийн хувиарлалт гэдэг үзэл санааны үндсийг бүрдүүсэн юм. Тухайлбал, 1-р зүйлд *"Хүмүүс ижилхэн эрх эрх чөлөөтэй төрж амьдардаг"*, 5-р зүйлд *"хууль бол нийтлэг хүсэл зоригийн илэрхийлэл мөн"*, 2-р зүйлд *"аливаа улс төрийн холбооны гол зорилго бол хүний салшгүй болон жам ёсны эрхийг хангах явдал мөн"*, 16-р зүйлд ***"иргэд нь эрхээр хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хувиарлаагүй нийгэмд Үндсэн хууль байдаггүй"*** гэх мэтээр өнөөдөр ч нийгэм улс төр эрх зүйн ертөнцөд дээдлэн эрмэлзэж хэрэгжүүлэхийг зорьж байгаа гол зарчим үнэт зүйлийг агуулсанаараа түүхэн ач холбогдолтой юм.

**Тиймээс хүний эрх, төрийн эрх мэдлийн хувиарлалт нь нэг зүйлийн хоёр тал мөн.**[3]

Тэгэхээр 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Монгол улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг батлан гаргасан билээ. Энэхүү шинэ Үндсэн хууль нь урьд урьдын Үндсэн хуулиудаас агуулга зарчмын хувьд илүү ардчилсан үзэл баримтлалын үүднээс боловсрогдсон бөгөөд Монгол улсын өнөөгийн болон хэтийн хөгжлийн үндсийг оновчтойгоор тодорхойлж, бэхжүүлж өгсөн түүхэн ач холбогдолтой баримт бичиг юм.[4]

Тухайлбал өмнөх Үндсэн хуульд эрх мэдлийн төвлөрсөн тогтолцоог хуульчилж байсан бол шинэ Үндсэн хуулиар төрийн эрх мэдэл хувиарлах зарчмын дагуу төрийн байгууллагуудыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага хэмээн ангилж тогтолцоонд оруулсан билээ.

Хэдийгээр Монгол улсын Үндсэн хуулиар иргэд нь эрхээр хангагдаж, төрийн эрх мэдлийг хувиарласан ч түүнийг хамгаалах механизмыг бий болгох нь чухал билээ. Энэ асуудлаар доктор /Sc.D/,

[3] Н.Лүндэндорж "Төрийн онол". УБ., 2008 он. 205-р тал

[4] Б.Нармандах "Үндсэн хуулийн эрх зүй". УБ., 2011 он.47-р тал

профессор Н.Лүндэндорж "...иргэд нь эрхээр хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хувиарлаагүй нийгэмд Үндсэн хууль байдаггүй. Ийм орны Үндсэн хууль нь хуурмаг Үндсэн хууль буюу зүгээр л хууль зүйн текст юм. Үүнийг хоёрхон зүйлээр л шалгадаг бөгөөд 1-рт тухайн улс ардчилсан дэглэмтэй байх уу, 2-рт тухайн улсын эрх зүйн тогтолцоо ямар байх вэ гэдгээс хамаардаг. Эрх зүйн газрын зураг гэж бий Монголын эрх зүйн тогтолцоо ямар өнгөтэй байх вэ гэдгийг Separation of power шийднэ. **Монгол улсад төрийн эрх мэдэл бүрэн хувиарлагдаагүй байна. Тийм байж хүний эрх эрх чөлөөг яаж хангаад байгаа юм бэ гэвэл энэ бол глобалчлалын нөлөө юм. Энэ их удаан үргэлжлэхгүй.**

**Үүний үр дүнд:**

1. **Ардчилал хагас болно**
2. **Хагас эрх чөлөө болно**
3. **Хууль эрх зүйт бус болно"**

гэж төрийн эрх мэдэл хувиарлах онолын лекцэндээ дурдсан байдаг.

Нийгмийн амьдрал улам баялаг болж хууль тогтоомжийн зохицуулалт улам өргөн хүрээг хамарч байгаа ч нийгмийн бүхий л харилцааг хуульчлах нь эргээд **rul of law**-г хууль дээдлэх ёс гэсэн буруу ойлголт ард түмний дунд төрж муу хуулийг ч биелүүлнэ гэсэн ойлголтод хүрнэ. Ингэснээр эрх зүйт төр, эрх зүйт хуулийн шинж мөн чанар алдагдахад хүрнэ.

Тэгвэл өнөөдөр бид 1960 оны Үндсэн хуулинд Монгол улсын иргэн хувийн өмчтэй байхыг хориглосон шиг 2012 онд хувийн өмчийг хуулиар биш захиргааны актаар хязгаарлах тохиолдол гарч байна. Энэ бол **Монгол улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэхгүй.**

2012 оны 08-р сарын 22-ны өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлчит бус хуралдаанаар "Улаанбаатар хотын замын хөдөлгөөний хэт ачааллаас урьдчилан сэргийлэх, иргэдийг нийтийн тээврийн хэрэгслэлээр зорчуулах боломжийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээ авах тухай" гэсэн 02/8 дугаар тогтоол дэмжигдэж 2012 оны 08 дугаар сарын 27-ноос 10 дугаар сарын 27-ны өдрийг хүртэл 1 ба 6-аар төгссөн улсын дугаартай автомашин даваа гаригт, 2 ба 7-аар төгссөн улсын дугаартай автомашин мягтар гаригт, 3 ба 8-аар төгссөн улсын дугаартай автомашин лхагва гаригт, 4 ба 9-өөр төгссөн улсын дугаартай автомашин дүрэв гаригт, 5 ба 0-аар төгссөн улсын дугаартай автомашин баасан гаригт замын хөдөлгөөнд оролцохгүй гэсэн агуулга бүхий тогтоол гарсан билээ.

Ингээд тогтоолын хэрэгжилтийн туршилтын хугацаа дуусч 2012 оны 11-р сарын 16-ны өдрийн Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн 4/14 дугаар тогтоолоор дээрхи шийдвэрийг хэвээр үлдээж үргэлжлүүлэн зохион байгуулах тухай тогтоол гаргасан.

Уг захиргааны актын эрх зүйн үндэслэлийг шалгавал "...хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй" [5] ,

[5] Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай

"Хурал, Засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ"[6], "Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрх эдлэхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд үүнд:

1/ нийслэлтэй холбогдсон асуудлаар хууль тогтоомжид нийцүүлэн бие даан шийдвэр гаргах;

2/ нийслэлд хэв журам сахиулах, хотын аж ахуй, оршин суугчдын нийгэм, соёлын асуудлаар нийтээр дагаж мөрдөх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, биелэлтэд хяналт тавих;

3/ нийслэл, түүний оршин суугчдын нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, өөрийн эрх хэмжээнд шийдвэрлэх боломжгүй асуудлыг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, холбогдох бусад байгууллагад санал тавих;

4/ нийслэлийн нийгэм, эдийн засгийн хөгжил, хот байгуулалт, хүрээлэн байгаа орчныг хамгаалах, хүн амын үйлчилгээтэй холбогдох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх;

5/ нийслэлийн хэмжээнд тэмдэглэлт ой, баяр ёслол тэмдэглэх, байгууллагад нэр өгөх, нэрэмжит болгох, хөшөө дурсгалын цогцолбор байгуулах асуудлаар өөрийн санаачилгаар болон иргэд, байгууллагын саналыг үндэслэн шийдвэр гаргах.[7] " гэсэн хуулийн зүйл заалтыг үндэслэжээ.

Монгол улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлгийн 63-р зүйлийн 63.2-т "...хурлын тогтоол, засаг даргын захирамж нь хууль тогтоомж, ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харъяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөнө" гэж заасныг үндэслэн Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-т "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ" гэж заасан нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг байгуулах, өөрчлөх, татан буулгах, түүний удирдлагын тогтолцоо, эрх хэмжээ, үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалттай холбогдсон үүссэн харилцааг зохицуулах хэм хэмжээг эрэмбэлсэн байна. Тухайлбал энэхүү харилцааны үндсэн эх сурвалж нь Монгол улсын Үндсэн хууль бөгөөд энэ хуулийн

---

хууль. УБ., 2006 он, 20 дугаар зүйлийн 20.1.7

[6] Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль. УБ., 2006 он, 39 дүгээр зүйлийн 39.1

[7] Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 1994он, 8-р зүйлийн 8.1

зүйл заалт нь Монгол улсын Үндсэн хуулийн зарчим, зүйл заалтад нийцсэн байна гэсэн санааг илэрхийлж байгаа юм. Энэ нь тухайн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний нийцэл зохицлыг хангахад чиглэгдэнэ.

Мөн уг тогтоолын үндэслэх хэсэгт заасан Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7-д зааснаар "...хуульд өөрөөр заагаагүй бол нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй" гэсэн хэм хэмжээ нь эрх зүйн онолын хэм хэмжээний нийцэл зохицлынх нь байдлаар авч үзвэл **Диспозитив \нөхөгдөж гүйцэх\ хэм хэмжээ** юм. Энэ хэм хэмжээний онцлог нь тухайн харилцааг зохицуулсан өөр хуулийн зүйл, заалт байхгүй тохиолдолд хүчин төгөлдөр үйлчлэхэд зориулагдсан хэм хэмжээ юм. Иймд тухайн харилцааг өөрөөр зохицуулаагүй тохиолдолд л энэ хэм хэмжээг дагаж мөрдөнө гэсэн үг. Жнь: "...Хуульд өөрөөр заагаагүй бол...." гэсэн нь тухайн харилцааг өөр хуулинд өөрөөр зохицуулсан бол тухайн хуулийн заалтыг дагаж мөрдөнө гэсэн утга илэрхийлэгдэж байна.

Иймээс Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2012 оны 2/08 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, 2012 оны 11-р сарын 16-ны өдрийн **Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах зохион байгуулалтын зарим арга хэмжээ авах тухай** 4/14 дугаар тушаалын 2-р зүйл нь Монгол улсын Үндсэн хуулийн 1-р бүлгийн 1-р зүйлийн 1.2-т "...ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", 5-р зүйлийн 5.2-т "...төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална",5 дугаар зүйлийн 5.3-т ...өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно", 70-р зүйлийн 70.1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудтай тус тус зөрчилдөж байна гэж судлаачийн хувьд үзэж байна.[8]

Дээрхи асуудлаар Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 2 дугаар сарын 4-ний өдөр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг баталснаар Монгол Улсын захиргааны процессын эрх зүйд хуулиар тусгайлан эрх олгогдсоноос бусад нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй болов.

2016 онд батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд "нийтийн ашиг сонирхол" хэмээх ойлголтыг

[8] Т.Азжаргал "Монгол улсын Үндсэн хууль"-ийн мөн чанар, түүний хэрэгжилтийн зарим асуудал" http://www.fact.mn/138317.html

оруулж, 62-р зүйлийн 62.1.1 хэсэгт “...захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх нь бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой, хуулийн этгээд, эсхүл нийтийн ашиг сонирхолд илт хохирол учруулахаар бол”; мөн 106-р зүйлийн 106.3.10 хэсэгт “...захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй нь тогтоогдсон бол түүнийг хүчингүй болгох, илт хууль бус болохыг тогтоох” гэж хуульчлан тодорхойлжээ.

Эндээс “нийтийн ашиг сонирхол” гэсэн ойлголтыг судлах, танин мэдэх, түүний агуулга, концепцийг онол, арга зүйн үндэслэлтэй тодорхойлох шаардлага Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаанд тавигдаж эхэллээ.

Дээрхээс үзвэл, “нийтийн ашиг сонирхол” гэх ойлголт нь яг таг буюу нэг томъёолол бүхий ухагдахуун биш бөгөөд юуны өмнө, нийтийн эрх ашгийг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт байна.

Түүнээс гадна нийтийн ашиг сонирхол гэдэг нь хуулиар шууд тодорхойлон заах боломжгүй ойлголт учраас түүний урьдчилсан нөхцлийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг бүхэллэг байдлаар тайлбарлах замаар шүүхээс шалган тайлбарладаг байна.

Анхаарах асуудлын хувьд: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт зааснаас үзвэл, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргах эрх бүхий нийгэмлэг, холбоод нь нийтийн ашиг сонирхолд холбоотой ямар ч асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй биш юм. Зөвхөн хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах хүрээнд нэхэмжлэл гаргаж болно.

Ийнхүү хязгаарлалт хийж өгсөн нь нийтийн захиргааны байгууллагад нийтийн ашиг сонирхол хийгээд хувийн ашиг сонирхлын хамгаалалтын балансыг барих боломж олгосон гэдэг утгаараа өнөөдрийн байдлаар оновчтой гаргалгаа гэж үзэж байна.

Дээрхээс харахад хүрээлэн байгаа орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэндийг хамгаалах талаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх явдал харьцангуй түгээмэл бол харин нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх тухай ойлголт нь өнөөгийн нийтийн өмчийн тухай Үндсэн хуулийн болон Иргэний хуулийн зохицуулалтуудаас үзэхэд ярвигтай байдлыг бий болгож болзошгүй юм.



**Ч.МЯГМАРБАЯР**
ХСИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн эрх зүйн онолын тэнхимийн ахлах багш, хошууч

# ХУУЛИЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ЧАДВАРЖУУЛАХ СУРГАЛТАНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

**Товч агуулга:** Эрх зүйн боловсрол олгох сургалтын хүрээнд суралцагч танхимд олсон мэдлэгээ практикт хэрэглэх, хуульчийн мэргэжлийн ажлын ур чадварт суралцан зохих дадал, чадваруудыг эзэмших хэрэгцээ шаардлагыг хангах нэг чиглэл бол чадвахржуулах сургалт юм.

Хуулийн их, дээд сургуулийн сургалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох зарим судалгаанд дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах зарим асуудлыг хөндөхийг зорилоо.

**Түлхүүр үгс:** Чадваржуулах сургалт, хуулийн их, дээд сургууль, суралцагч, ур чадвар, дадал

Эрх зүйн болон нийгэм, эдийн засаг, технологийн салбарыг нийтэд нь хамарсан томоохон өөрчлөлтүүд, улам бүр нарийсч, мэргэшсэн чиглэлээр явж байгаа нийгмийн хөгжлийн хандлага зэрэг нь хуульч бүр хууль, эрх зүйн дагнасан чиглэлд мэргэшин ажиллах, эсвэл зарим тодорхой чиглэл дээр төвлөрөн ажиллахыг шаардаж байгаа хэдий ч, тэд "бүх талын мэргэжилтэн" байх уламжлалт дүр төрхөө хадгалсаар иржээ.

Хуулийн их, дээд сургуульд суралцагчдын эзэмших эрх зүйн мэргэжил өнөө үед улам бүр төрөлжихийн зэрэгцээ, зохион байгуулалттай, нэгдмэл тогтолцоотой мэргэжил болон хөгжиж байна[1].

Саяхныг хүртэл манай хуулийн их, дээд сургуулийн сургалт нь суралцагчдад онолын мэдлэг олгох тал дээр илүү түлхүү анхаарч ирсэн нь эрх зүйн боловсрол олгох сургалтын байгууллага, хууль зүйн салбарын практик байгууллагуудын хооронд төгсөгчдийн ур чадварын асуудал дээр санал зөрөлдөх, бие биеэ буруушаах явдал байсаар ирсэн. Практик байгууллагууд "Гэрээний загвар, төсөл гаргаж чаддаггүй, тэд бичиж чаддаггүй, тэд хэзээ ч зарлан дуудах хуудас гэж юу байдгийг хараагүй гэх мэт гомдлыг гаргадаг. Энэ гомдолд хуулийн сургуулиас "Бид үйлдвэрлэлийн сургуулиуд биш, эрдэм боловсролд суралцах төв харин практикийг үйл ажиллагаа явуулж буй хуульч нар илүү сайн заана[2]" гэсэн хариултыг өгдөг байна.

Эрх зүйн боловсрол олгох үйл ажиллагаа, хууль, эрх зүйч мэргэжлээр ажиллах хоёр нь хоорондоо зааг ялгаагүй нэгдмэл нэг "үйл хэрэг"-ийн салшгүй бүрдэл хэсгүүд билээ. Хуульчдын өрсөлдөх чадвар, мэргэжлийн ур чадвар, үнэлэмжийн хөгжил нь хуулийн

[1] Эрх Зүйн боловсрол ба хуулийн мэргэжлийн хөгжил төлөвшил. Хуулийн мэргэжилд судалгаа хийсэн тусгай комиссын тайлан. 1992 он, 5 дах тал

[2] Мөн тэнд

сургуулийн өмнөх үеэс эхлэн, хуулийн сургуульд суралцаж байх үед хөгжлийнхөө хамгийн эрчимтэй шатанд хүрч, хуульчийн ажил мэргэжлийн өсөлтийн бүхийл цаг хугацаанд нэг шугамаар үргэлжлэн хөгжиж байх учиртай.

Багш нарынхаа мэдлэг, ур чадварын түвшинд тавих шаардлага нь хуулийн сургууль бүрт өөр өөр байдаг ч багш нарынхаа эрдэм мэдлэг, чадвар, багшлах ур чадвар асуудалд ямар нэг шаардлага тавьдаггүй, нөгөө талаас чадваржуулах сургалтыг зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлэх санхүүжилт хангалтгүй зэргээс шалтгаалан суралцагчдад ур чадвар олгох сургалтын тогтолцоо бүрдэхгүй байна. Хуулийн сургуулиуд өөрсдийн эрдэмтэн багш нарын нэр хүнд, сургалтын чанараас үндэсний гэсэн статусыг олж авч чаддаг. Ийм нэр хүндтэй байх нь илүү сайн оюутнуудыг өөртөө татахад тус дөхөм болдгоос гадна оюутнууд төгссөнийхөө дараа илүү сайн ажлын байраар хангагдах боломж бүрддэг.

Хууль зүйн практикт эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлж байгаа хуульчид хуулийн сургуульд эзэмшсэн мэдлэг, ур чадвар нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахад ямар үнэ цэнэтэй зүйл болохыг мэдэрдэг, төгссөн сургуульдаа талархдаг хэдий ч судалгааны үр дүнгээс харахад тэд сургалт ур чадвар эзэмшүүлэх тал дээр дутуу дулимаг байдаг тул сургууль төгссөнийхөө дараа тэдгээрт суралцах шаардлага зайлшгүй гардаг гэж үздэг байна.

Монгол Улсын хуулийн их, дээд сургуулиудад чадваржуулах сургалтын хэлбэр болох хууль зүйн клиник сургалтын хөгжлийн түүх 1999 оноос эхлэлтэй гэж судлаачид үздэг бөгөөд 1999-2001 оны үед Монголын анхны хууль зүйн клиник сургалтын төвүүд байгуулагдаж, эрх зүйн бакалаврын боловсролын тогтолцоонд клиник боловсролын эхлэл тавигджээ[3].

Хууль зүйн сургууль төгсөгчдийн чанарыг түвшинг тогтоох зорилгоор 748 төгсөгчдийн дунд явуулсан судалгаагаар тэдний 70 хувь нь өдөр тутмын ажилдаа мэргэжлийн алдаатай тааралддаг , 37 хувь нь хэрэг маргаан шийдвэрлэхдээ буруу шалтгаан олдог , 34 хувь нь шаардлагатай туршлага дутдаг , 26 хувь нь хуулийг хэрэгжүүлэх чадвар дутдаг , 20 хувь нь илүү дадлага хэрэгтэй , 70 хувь нь эрх зүйн боловсролд өөрчлөлт хийх хэрэгтэй гэж үзжээ[4].

[3] Нээлттэй нийгэм форум “Хууль зүйн клиник сургалтын стандартын хэрэгжилтийн мониторингийн тайлан” 2015

[4] Дэлхийн банкнаас хэрэгжүүлсэн “Шүүх эрх зүйн шинэчлэл” төслийн хүрээнд хийсэн “Үр дүнд тулгуурласан эрх зүйг судлах нь” Судалгааны тайлан.


**Зураг 1. Төгсөгчдийн ур чадварын түвшин**




*Эх сурвалж: Дэлхийн банк, “Шүүх эрх зүйн шинэчлэл” төсөл “Ур дүнд тулгуурласан эрх зүйг судлах нь” Судалгааны тайлан.*

2013 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хийсэн “Залуу хуульчдын мэргэжлийн ур чадвар, үнэт зүйлсийн төлөвшлийн үнэлгээ” сэдэвт социологийн судалгаагаар хууль зүйн их дээд сургуулийн төгсөх курсын 258 оюутан, төсгөөд ажиллаж байгаа залуу 294 хуульчид, тэдэнд ажил олгогч 15 аймаг, 6 дүүргийн шүүх, прокурор, өмгөөлөгчдийн товчооны удирдлага /151/-ын хүрээнд санал асуулга явуулахад дараахь дүр зураг ажиглагджээ. 151 удирдах ажилтнаас хуульчийн ур чадварын 10 багц асуудлаар өөрсдийнх нь удирдлага дор ажилладаг залуу хуульчдын ур чадварыг үнэлүүлэхэд 37,6 хувь нь сайн, 62,4% нь дунд болон түүнээс доош гэжээ. Харин залуу хуульчид өөрсдийнхөө ур чадварыг дунд болон түүнээс доогуур гэж 54,3% нь үзсэн байна[5].

**Зураг 2. Залуу хуульчдын ур чадварын үнэлгээ**




*Эх сурвалж: ХЗҮХ “Залуу хуульчдын мэргэжлийн ур чадвар, үнэт зүйлсийн төлөвшлийн үнэлгээ” 2013*

Хуулийн сургуулиуд оюутнуудыг эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх дадал, хандлагатай болгож, төгсгөхөд юу хийх шаардлагатай вэ гэдэг тал дээр анхаарлаа хандуулж ирсэн ч аливаа асуудалд хууль зүйн үнэлэлт өгөх, дүн шинжилгээ хийх, хуульчийн мэргэжлийн үүрэг хариуцлага хүлээхээсээ өмнө ямар төрлийн ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай талаар иж бүрэн судалгаа хийгдээгүй байна. Эдгээр ур чадварыг хөгжүүлэхийн тулд хуулийн сургуулиуд дараахь ур чадвар, дадал олгох сургалт явуулахад анхаарах хэрэгтэй юм.

Үүнд: Аливаа асуудлыг эрх зүйн үүднээс авч үзэх аналитик ур чадвартай болгохоос эхэлнэ.

[5] Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн “Залуу хуульчдын мэргэжлийн ур чадвар, үнэт зүйлсийн төлөвшлийн үнэлгээ” 2013 он

- Асуудал шийдвэрлэх
- Хууль зүйн дүн шинжилгээ хийх

Дээрх чадварыг эзэмшүүлсний дараа эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцааны төрөл, чиглэлд зайлшгүй шаардагдах ур чадвар, дадалтай болох

- Хууль зүйн судалгаа
- Баримт мэдээллийг шинжлэн судлах
- Үйлчлүүлэгчтэй харьцах харилцаа
- Зөвлөгөө өгөх
- Хэлцэл хийх ур чадвар
- Шүүн таслах ажиллагаа болон маргааныг шийдвэрлэх
- Эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг үр бүтээлтэй зохион байгуулах, менежмент хийх захиргааны ур чадвар

Эрх зүйн үйлчилгээ, хууль зүйн туслалцаа үзүүлэх ур чадварууд нь эрх зүйн мэргэжлийн хувьд заавал эзэмшсэн байх ёстой харилцан уялдаа холбоо бүхий чадварууд юм. Жишээ нь: зөвлөгөө өгөх ур чадвар, хэлцэл хийх, шүүн таслах ажиллагааны үед мэтгэлцэх ур чадварыг томъёолоход эдгээр ур чадвар нь хууль зүйн дүн шинжилгээ, судалгаа хийх, баримт мэдээллийг шинжлэн судлах ур чадваруудыг ашиглах, шаардлагатай бол хэлцэл хийх ур чадварт дүн шинжилгээ хийж тайлбарлахдаа зөвлөх ур чадварыг ашиглан хэлцэл хийх үед харилцагч нь нөгөө талаас хамгийн сайн нөхцлийг хүлээн авах уу, эсвэл татгалзах уу гэдэгт тусалдаг бол асуудал шийдвэрлэх ур чадвар нь голдуу эрх зүйчээс үйлчлүүлэгчийн асуудлыг тодорхойлох, оношлогоо хийхэд шаардлагатай баримтуудыг цуглуулах, ярилцлага хийх ур чадварыг шаарддаг.

Иймээс ур чадваруудыг суралцагчдад эзэмшүүлэхийн тулд сургалтын процесст дараахь чиглэлийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй гэж үзэж байна.

1. Чадваржуулах сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, эрх зүйн бакалаврын боловсролын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай ба үүнд хуулийн их, дээд сургууль төдийгүй хууль хяналтын байгууллагын үүрэг оролцоо чухал байна. Ялангуяа багшлах нөөцийг нэмэгдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулахад хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Мэргэжлийн ном, сурах бичигт тодорхой кейс /тохиолдол/ болон асуудал шийдвэрлэх арга, техник олгох нэмэгдэл материал түлхүү оруулж өгөх;

2. Чадваржуулах сургалтыг зохион байгуулж, хууль сахиулах байгууллагад ажиллах хүний нөөцийг бэлтгэхэд багшийн үүрэг чухал юм. Гэтэл манай их, дээд сургуулиудад дээд боловсролын дидактик сул хөгжсөнөөс багшийн тасралтгүй хөгжил хангалтгүй байгаа тул багшийн хөгжлийн чиглэлээр олон талт дэмжих үйл ажиллагааг санаачлан хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүний зэрэгцээ хуулийн практикт ажиллаж буй мэргэжилтнүүд хууль зүйн их дээд сургуульд ажиллах нөхцөл боломжийг олон арга хэлбэрээр дэмжих шаардлагатай байна. Тухайлбал: тэдний ажлын чиг

үүрэгт зааж институтчилах, нэр хүндийг өргөх, алдаршуулах зэрэг арга замуудыг ашиглах боломжтой бөгөөд ийм практик бусад улс оронд байдаг билээ.

3. Сургалтын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох тал дээр хуулийн сургууль тус бүр өөрийн гэсэн тодорхой зорилготой, онцлогтой байдаг тул чадваржуулах сургалт нь тухайн зорилгын хүрээнд өөрийн зорилго, хэлбэр, сургалтын агуулгаа тодорхойлох нь зүйтэй юм. Сургалтын хөтөлбөрийн шаталсан ахиц дэвшил, нэгдмэл байдлыг хангаж, сургалтын хөтөлбөрийн загварыг боловсруулж, туршилтын болон загвар төслийг эхний ээлжинд хэрэгжүүлэх алхам хийж, тэдгээрт дэмжлэг үзүүлэх. Ихэнх сургуулиуд 4-р курсдээ үйлдвэрлэлийн дадлагад гардаг. Мөн төгсөх курсдээ клиник сургалтанд хамрагддаг байна. Тэгэхээр энэ давхцлыг арилгах, мөн дадлагад гарахаасаа өмнө хууль зүйн мэргэжлийн үйл ажиллагааны тодорхой чадваруудыг эзэмшүүлээд гаргавал дадлагын чанар сайжирна.

4. Хууль зүйн сургуулиуд хууль хяналтын байгууллагын сургалт, судалгааны төвүүдтэй хамтран ажиллаж, тухайн байгууллагуудын боловсон хүчний чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалтууд, давтан сургалтын чиг хандлага, бодлогыг судалж байх нь тухайн сургуулиас төгсөж гарч буй боловсон хүчнийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн бэлтгэхэд хувь нэмэр оруулах боломжтой. Мөн АНУ-д сургалтын шинэлэг хөтөлбөр боловсруулсан, хэрэгжүүлсэн багш нарт илүү хөлс төлөх замаар энэ төрлийн сургалтын хэлбэрийг улам боловсронгуй болгох нь зүйтэй гэсэн хандлага байна.

5. Хуулийн сургуулиуд илүү туршлагад тулгуурласан нөхцөл бололцоогоор оюутнуудыг хангах. Тухайлбал: хуульч мэргэжлийн ажлын байрны орчин нөхцлийг хангасан танхимд байгуулах, түүнтэй адилтгасан нөхцлийг бий болгож сургалт явуулах. Өөрөөр хэлбэл хиймэл буюу зохиомол орчинд эсвэл жинхэнэ үйлчлүүлэгчидтэй орчинд дадлагын хичээл орох нь хуульчийн мэргэжлийн ур чадварт сургахад ихээхэн түлхэц өгнө гэж үзэж байна.

6. Суралцагчдад эрхэм зорилгыг нь бий болгон өгч тэдэнд үнэт зүйлсийн баримжаалал олгож, өөрсдийг нь бие даалган, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэгч болгон төлөвшүүлэх,

7. Суралцагчдад хичээлийн жилийн эхнээс төгсөх хүртэл нь онол дадлагыг хослуулсан сургалтаар хангах. Ингэхийн тулд багшлах бүрэлдэхүүн уламжлалт заах арга барилаа өөрчилж, дадлагын хичээлд ач холбогдол өгөн мэргэжлийн ур чадварыг оюутанд эзэмшүүлэх,

8. Хууль, эрх зүйн клиник боловсрол олгох нөхцлийг бий болгоход туслалцаа дэмжлэг үзүүлэх,

9. Эрх зүйн сургалтын үйл ажиллагаанд тогтмол мониторинг хийж, үйл ажиллагааг нь сайжруулснаар сургалтын чанар нэмэгдэж, хууль зүйн салбарт чадварлаг, мэргэжлийн боловсон хүчин нийлүүлэхэд чухал түлхэц үзүүлнэ гэж үзэж байна.



**П.ЭРДЭНЭБААТАР**
ХСИС-ийн
Цагдаагийн
сургуулийн мөрдөх
албаны тэнхимийн
багш, цагдаагийн дэд
хурандаа

# МӨРДӨН БАЙЦААЛТЫН ШАТАНД НОТЛОХ БАРИМТЫГ ЦУГЛУУЛАХ, БЭХЖҮҮЛЭХЭД ДҮРС БИЧЛЭГ, ДУУ ХУРААГЧИЙГ АШИГЛАХ ТАКТИК АЖИЛЛАГАА

**Abstract:** In this abstract, I have written about the proper use of video camera and voice recorder in order to be able to collect more evidence in accordance with the rules and revelations during the investigation period.

**Keywords:** Investigation, evidence, collect, strengthen, notes, voice, recorder, video camera, equipment's, methods, tools.

Орчин цагт криминалистикийн шинжлэх ухааны үзэл баримтлал, түүн дээр үндэслэн, мөрдөн байцаах ажиллагааны нөхцөл, явц, үр дүн, объект, түүний шинж тэмдэг, үйл явдал бэхжүүлэх, шинжлэх зорилгоор дүрс, дуу гаргаж авах техник хэрэгсэл, арга зүй, арга барилын системийг өргөнөөр ашиглаж байна.[1]

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад дуу хураагч, дүрс бичлэгийг яаж ашиглаж нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх талаар саналаа солилцохыг хүссэн юм.

Нотлох баримтыг бэхжүүлэхдээ тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан соронзон болон дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, гар зураг үйлдэх, ул мөрнөөс хэв, хээ буулгаж авах зэрэг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчимд нийцсэн бусад аргыг хэрэглэнэ[2] гэж заасан байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл холбогдлыг нотлохын тулд дуу хураагч, дүрс бичлэгийн техник хэрэгслийг ашиглан нотлох баримтыг бэхжүүлэх зорилгоор практик амьдралд өргөнөөр хэрэглэж байгаа боловч тухайн бэхжүүлсэн нотлох баримт нь нотлох баримтын хэмжээнд бүрэн дүүрэн үнэлэгдэж чадахгүй байна.

Практик амьдралд дуу хураагч, дүрс бичлэгийн техник хэрэгслийг дараах чиглэлээр ашиглаж байна.

Үүнд:

1. Нийгмийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдлыг хангах хууль сахиулах үйл ажиллагааны чиглэлээр
2. Гүйцэтгэх ажлын эрэн сурвалжлалтын чиглэлээр
3. Мөрдөн байцаалтын чиглэлээр
4. Шүүхээр хэрэг таслан шийдвэрлэх чиглэлээр гэх мэт.

Эдгээр дотроос мөрдөн байцаалтын ажиллагааны чиглэлээр дуу хураагч, дүрс бичлэгийг хэрхэн

[1] Ж. Хурцгэрэл. Криминалистикийн 1. УБ.2002 164 дэх тал

[2] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

ашиглах талаар авч үзэх шаардлага практик амьдралд гарч байна.

Мөрдөн байцаалтын ажиллагаанд дуу хураагч, дүрс бичлэгийг ашиглахдаа мөрдөн байцаалтын тактикийн зорилгоор ашиглах, нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэхдээ чанараар ашиглах гэж хоёр хураан авч үздэг.

1. Мөрдөн байцаалтын тактикийн зорилгоор ашиглах гэдэг нь нотлох баримтыг бэхжүүлэх чанартай биш тухай гэмт хэргийг илрүүлэхэд тус нөлөө үзүүлэх зорилгоор ашиглахыг хэлнэ. Жишээлбэл: Нүүрэлдүүлэн байцаалтанд мэдүүлгийг бичиж авч мэдүүлгийн дагуу давхар батлуулах гэх мэт.

2. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар мөрдөн байцаагчаас явуулж буй үйл ажиллагааг зайлшгүй бэхжүүлэх үндсэн хэрэгсэл нь тэмдэглэл юм.

Мөрдөн байцаалтын тэмдэглэл байцаалтын явц, үр дүнг өөртөө тусган харуулж өгч буй процессын баримт бичиг.

Мөрдөн байцаалтын тэмдэглэл нь доорх шаардлагуудыг хангасан байх ёстой.

А. Мөрдөн байцаалтын тэмдэглэл, уг тэмдэглэлийг үйлдэх эрх бүхий албан тушаалтан бичсэн байх

Б. Тэмдэглэлд бичигдвэл зохих үйл явдлыг бодит байдлаар харуулан тусгасан байх

В. Тэмдэглэл мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн харуулсан байх

Г. Тэмдэглэл хэл бичгийн хувьд алдаагүй зөв бичигдсэн байх

Д. Тэмдэглэлд хэмжих ямар багаж хэрэгсэл ашигласан, гэрэл зураг, схем зураг, ул мөрний хэв хуулбарыг хавсаргасан байх шаардлага тавигдана.

Мөрдөн байцаалтын ажиллагааны ажиллагааны явцыг бэхжүүлэх ажлын аль хэцүү үйл ажиллагааг харуулахад дүрс бичлэг, дуу хураагчийг ашиглах явдал нь чухал тусламж болно.

Мөрдөн байцаалтын ажиллагааны сүүлийн үеийн туршлагаас үзэхэд дор дурдсан нөхцлүүдэд дүрс бичлэг, дуу хураагчийг ашиглах нь үр ашгийг өгч байна. Үүнд:

1. Мэдүүлэг өгч буй этгээдийн үнэн зөвийг мэдүүлгийн дараа нь мэдүүлгээ өөрчилж буцах, бололцоог арилгах зорилгоор дүрс бичлэг, дуу хураагчийг ашиглах

2. Гэмт хэрэгт хамтран оролцогчийг илрүүлэх зорилгоор ашиглах, гэм буруугаа үнэн зөвөөр хүлээн зөвшөөрсөн сэжигтэн, яллагдагчийн дүрс бичлэг, дуу хураагчинд бичигдсэн бичлэг нь түүний хань хамсаатныг үнэн зөв мэдүүлэг өгөхөд ач холбогдолтой.

3. Мөрдөн байцаагчаас мэдүүлгүүдийн хоорондын зөрүүг гаргах, дараагийн мэдүүлгийн хоорондын зөрүүг арилгах,

4. Хэргийн газрын үзлэгийн тэмдэглэлийг хийхэд тэмдэглэл үйлдэхэд төвөгтэй буюу бололцоогүй байгаа нөхцөлд сэжигтнийг байцаах, гэрчээс мэдүүлэг авах үед ашиглах

Гэхдээ дараа нь жинхэнэ хууль ёсны мэдүүлэг авахдаа дүрс бичлэг, дуу хураагчийг тулган шалгах замаар

байцаалтыг явуулж тэмдэглэлд тусгасан байх.

5. Мэдүүлэг өгөхөөс татгалзаж буй этгээд ямар шалтгааны улмаас бичмэл мэдүүлгийг өгөхөөс татгалзаж байгаа үед ашиглах

6. Хүнд өвчтэй хохирогч, гэрч, сэжигтэн, ялллагдагчаас мэдүүлэг авах үед хэрэв хохирогч нас барьж болох буюу бичмэл мэдүүлэг авах нь түүний эрүүл мэндэд муугаар нөлөөлж болох байвал.

Практик амьдралд мэдүүлгээсээ буцсан ихэнх хохирогч, гэрч, сэжигтэн, яллагдагч нь “Намайг айлган сүрдүүлсэн”, Хэргээ хүлээвэл эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө” гэсэн эсвэл “Тэмдэглэлийг надад уншиж сонсгоогүй шууд гарын үсэг зур” гэж тулгаад зуруулсан юм гэсэн ор үндэсгүй худлаа мэлзэх явдал олон гарч байна.

Мөрдөн байцаалтанд дүрс бичлэг, дуу хураагуур ашиглаж нотлох баримтыг бэхжүүлж авах нь мөрдөн байцаалтыг илүү зорилго чиглэлтэй явуулах, мөрдөн байцаагч, мэдүүлэг өгч буй хүн аль алиныг аль болох тайван чөлөөтэй мэдүүлэг гаргаж тодорхой авах боломжийг гаргаж өгдөг.

Мэдүүлгийг дүрс бичлэг, дуу хураагуурийн техник хэрэгслийг ашиглан бэхжүүлж авах нь тэмдэглэлийн үнэн зөвийг тусгаад зогсохгүй мэдүүлэг өгч байгаа хүний сэтгэл хөдлөл, өөрчлөлт, нүүр царайны хувирал, хир зэрэг итгэлтэй ярьж байгааг харуулж өгөх боломж нөхцлийг бүрдүүлж өгнө.

Ялангуяа насанд хүрээгүй хүний мэдүүлгийг бэхжүүлэхдээ ашиглах нь ач холбогдолтой юм.

Дүрс бичлэг, дуу хураагчийг мөрдөн байцаалтанд ашиглах явцыг дор дурдсан баталгаа заавал хийгдсэн байх ёстой.

1. Байцаалтанд дүрс бичлэг, дуу хураагч ашиглах тухай мэдүүлэг өгч буй хүнд өөрт нь урьдчилан мэдэгдэж мэдүүлгийн тэмдэглэлд дүрс бичлэг, дуу хураагчийг ашиглаж байгааг тусгасан байх

2. Дүрс бичлэг, дуу хураагчинд бичигдсэн зүйлийг арилсан, устсан,техник эвлүүлэг хийсэн бол энэ талаар тэмдэглэлд тухайн шалтгааныг тайлбарласан байх

3. Мэдүүлэгт бичигдсэн дүрс бичлэг, дуу хураагчийн хальс, бичлэгийг тэмдэглэлд хавсаргахдаа байцаалтанд оролцогч нь бичмэл тэмдэглэлийг батлан гарын үсэг зурсан байх

4. Дүрс бичлэг, дуу хураагчийн бичих тухай мэдүүлэг өгөгчид урьдчилан мэдэгдэх, заавал нүдний өмнө байлгаж бичих албагүй бөгөөд мэдүүлэг өгөгчийн чөлөөтэй мэдүүлэг өгөхөд саад учруулахгүй байх нөхцлийг хангасан байх

Дүрс бичлэг, дуу хураагч техник хэрэгслийг ашиглан мэдүүлгийг бичихдээ дор дурьдсан шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

1. Байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий субъект нэгдүгээр биеэр ярьсан удиртгал хэсгээр эхлэнэ.

2. Мэдүүлэгийг тэмдэглэл хэлбэрээр бэхжүүлэхийн хамт ямар маркын дүрс бичлэг, дуу хураагуурийн техник хэрэгсэл ашиглаж байгаа талаар дурдаж өгнө.

3. Мэдүүлгийг хаана ямар газар, ямар орчинд, ямар цаг хугацаанд эхлэн явуулж, ямар оролцогчид оролцож байгааг тодруулан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын эрхийг [3] заавал тайлбарлан өгсөн байх.

4. Мэдүүлгийг мэдүүлэг өгч байгаа хүний биеийн байцаалтын хэсгээс эхлэн бичнэ.

5. Гэрч, хохирогчийн мэдүүлгийг дүрс бичлэг, дуу хураагчаар бичиж байгаа бол мэдүүлэг өгөхөөс татгалзах буюу зориуд санаатай худал мэдүүлэг өгвөл Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254, 255 дугаар зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээнэ гэдгийг урьдчилан сануулна[4].

6. Мэдүүлэг тавигдаж байгаа асуултууд нь ойлгомжтой тодорхой байх, асуулт бүрийн дараа хариулт бичигдсэн байх.

7. Мэдүүлгийг тодорхой хугацаагаа завсарлах тохиолдолд ямар шалтгаанаар завсарласан талаараа тайлбарыг хийх.

8. Мэдүүлгийн эцэст эрх бүхий субъект он, сар, өдөр, цаг хугацааг бичих.

9. Эрх бүхий субъектийн зүгээс мэргэжлийн хүний туслалцаатайгаар бичиж байгаа бол түүний овог, нэрийг заах хэрэгтэй.

10. Мэдүүлэг өгөгчид дүрс бичлэг, дуу хураагуурт бичигдсэн мэдүүлгийг үзэж сонслоо, зөв бичигдсэн байна нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатайг асуух.

Зарим үед практик амьдралд мэдүүлэг өгч байгаа хүн гэмт хэрэгт хамааралгүй зүйлийг ярих тохиолдол гардаг тул үүнийг хэрэгт ач холбогдолгүй зүйл гэж дүрс бичлэг, дуу хураагчинд бичихгүй хасаж болохгүй юм. Харин юу ярьсан бүгдийг бүрэн бэхжүүлэн авах нь процессыг баталгаатай болгож өгнө.

Дүрс бичлэг, дуу хураагчинд бичигдсэн мэдүүлэг, тэмдэглэлд бичигдсэн мэдүүлэг хоёр хоорондоо зөрүүтэй байж болохгүй. Тэмдэглэлд дүрс бичлэг, дуу хураагч хэрэглэсэн эрх бүрий албан тушаалтан мэдүүлэг өгөгчид дүрс бичлэг, дуу хураагчийг хэрэглэх тухай мэдэгдсэн, дүрс бичлэг, дуу хураагчийн марк, загвар, бусад оролцогчдын овог, нэр, дуу дүрс бичлэгийг лацлан баталгаажуулсан талаар тодорхой тусгана. Хэрэв дүрс бичлэг, дуу хураагуурийн бичлэгийг сонсгох үед чанарын шаардлага, гэмтэл тохиолдсон бол тухай бүр тэмдэглэлд тусгана.

Энэ бүгдээс дүгнэн үзвэл мөрдөн байцаалтанд дуу хураагч, дүрс бичлэгийн техник хэрэгслийг ашиглан нотлох баримтыг бэхжүүлж авах нь байцаан шийтгэх ажиллагааг явуулж буй эрх бүхий субъект тухай мэдүүлгийг төлөвлөсөн тактикийн арга хэмжээг бүрэн чөлөөтэй хэрэгжүүлэх боломжоор хангаж, байцаалтын ач холбогдлыг өндөржүүлэх, мөрдөн байцаалтын ажиллагааны цаашдын явцад зохих нөлөө үзүүлдэг чухал хүчин зүйл юм.

Иймд доорх саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөн байцаалтанд дүрс бичлэг, дуу хураагчийг аль болохоор

[3] Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. УБ., 2002

[4] Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2002

өргөн хэрэглэх, ялангуяа хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтэн, ялагдагчаас мэдүүлэг авахад заавал ашиглаж байх.

2. Мөрдөн байцаалтанд дуу хураагуур, дүрс бичлэгийн техник хэрэгслийг ашиглан нотлох баримтыг бэхжүүлэх заавар, зөвлөмжийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.



**С.НЯМЖАВ**

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн тактик, тусгай бэлтгэлийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа

## КРАВ МАГА

Крав Мага нь цэрэг, цагдаагийн албанд зориулж анх боловсруулсан Израиль улсаас гаралтай гардан тулааны цогц систем юм. Крав мага гэдэг нь еврей хэллэг бөгөөд монгол хэл дээр орчуулбал "Бодит тулаан"[1] гэсэн утгыг илэрхийлдэг.

Крав Магагийн тухай илүү ихээр ойлгож мэдэхийн тулд дараах 7 зүйлийг толилуулья. Үүнд:


**1. Үүсэж бий болсон түүх**

1930-аад онд Европод амьдардаг еврейчүүд бусдад илт гадуурхагдаж эхэлжээ. Тиймээс тэд өөрсдийн биеэ хамгаалж сурах шаардлага гарсан юм. Ими Лихтенфельд хэмээх еврей эр Братислав хотод хэрхэн биеэ хамгаалахыг зааж эхэлжээ.Түүний зорилго нь ямар ч спортоор хичээллэж байгаагүй хүнд хамгийн богино хугацаанд бие хамгаалах анхан шатны мэдлэг, чадварыг олгох байв. Харин бокс, бөх гэх мэт тухайн үеийн бие хамгаалах спортын төрлүүдийг хурдан хугацаанд зааж, сургах боломжгүй байсан юм. Тиймээс Ими өөрийн шинэ аргачлалыг зохиож хичээл зааж эхэлжээ. Хичээл нь яваандаа улам боловсронгуй болж шинэ төрлийн бие хамгаалах урлаг бий болжээ.

**2. Дайны үед**

Үүнээс 10 гаруй жилийн дараа Европод амьдрахад хэтэрхий аюултай болсон учир Палестин уруу нүүж шинэ Израиль улсыг бий болгохын төлөө хүчин зүтгэж эхэлжээ. 1942 онд тэрээр Хаган хэмээх цэргийн бүлэглэлд элсэж, бие хамгаалах урлаг зааж эхэлжээ. Удалгүй Ими Лихтенфельд шинэ Израилийн цэргийн тусгай ангийн бэлтгэлийн баазийн даргаар томилогдов. Ингэснээр Крав Магагийн техник цэргийн тусгай анги, дараагаар нь цэргийн бусад ангиудад тархаж Израилийн армийн бүх цэргийн зайлшгүй сурах ёстой бие хамгаалах урлаг болон хувирчээ.

**3. Крав Магагийн зорилго**



Крав Магагийн гол зорилго нь хамгийн бага хугацаанд аюулыг зогсоох юм. Хамгийн бага хугацаанд аюулыг зогсоохын тулд хамгийн үр дүнтэй аргыг хэрэглэнэ. Ингэхийн тулд өндөр хурд, чадвар шаардсан гоё, сүртэй харагдах мэх сурах шаардлагагүй.

[1] Батжав Б. Бодит тулаан. УБ., 2016. 5 дах тал

### 4. Бэлтгэл



Азийн бусад орны бие хамгаалах урлагт хэрэглэдэг хатуу дэг журам, ёс зүй, тусгай бэлтгэлийн хувцас шаардлагагүй. Энгийн бэлтгэлийн хувцас өмсөөд хүний хамгийн эмзэг хэсэгт чиглэсэн цохилт, цохилтоос хамгаалах техникийг шууд давтаж эхэлнэ. Урьд нь спортоор хичээллэж байгаагүй хүнийг хэдхэн долоо хоногийн дотор л сурсан зүйлээ өөрийн биеэ хамгаалах чадварыг олгох боломжтой юм.


### 5. Хүний эмзэг цэг

Аюул учруулж буй этгээдийн хамгийн эмзэг цэгт анхаарлаа хандуулна. Ихэнх цохилтын техник нь хүний хоолой, нүд, эмзэг эрхтэнрүү чиглэдэг. Жинхэнэ эр хүн шиг зодолдохыг заахгүй ч та аюулаас өөрийгөө ямар ч аргаар хамгаалж чадна. Крав Магагийн гол зорилго нь аюулыг хамгийн богино хугацаанд зогсоож, аюултай байдлаас амьд гарах юм.

### 6. Крав Магагийн зэвсэг

Крав Магад гарт ойрхон бүх төрлийн эд, зүйлийг зэвсэг болгон ашиглахыг заадаг. Ингэснээр учирсан аюулыг хамгийн богино хугацаанд зогсоож, аюулаас аврагдах боломжтой болно. Гарт ойр байгаа түлхүүр, нүдний шил, бүс, сандал гэх мэт зүйлсийг бие хамгаалахад ашиглаж сургадаг.

### 7. Хамгаалах болон довтолгоо



Бусад бие хамгаалах урлагууд хамгаалалт болон довтолгооны техник гэж тусад нь заадаг. Хэрэв танд аюул учруулж байгаа этгээд танаас илүү бэлтгэгдсэн, илүү хурдан хөдөлгөөнтэй тохиолдолд та зөвхөн хамгаалсаар байгаад дуусна. Довтлох боломж олдохгүй. Харин Крав Магад хамгаалалт, довтолгоо нь нэгэн зэрэг явагддаг. Эсрэг этгээдийн довтолгоог хамгаалангаа, та өөрөө довтолно гэсэн үг. Гэхдээ зорилго нь хүн аюултай байдлаас амьд гарах юм.

Өнөөдөр Израиль улсын тусгай албад болон дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудын тусгай албад бие хамгаалах хамгийн сонгодог систем гэж үзэн албаны сургалтандаа нэвтрүүлжээ.

Крав Мага бол хамгийн үр дүнтэй, хамгийн энгийн боловч хамгийн хэрцгий гардан тулаан гэж үздэг ч явдал байна. Гэхдээ энэхүү гардан тулааныг сургалтаар эзэмшүүлэхэд цаг хугацаа бага шаарддагаас гадна хурд хүч шаардсан өндөр давтамжтай бэлтгэл, цэвэр үзэмжтэй техник төдийлэн шаардаггүй. Мөн хичээллэхэд та зөв

галбиртай, эсвэл эрүүл чийрэг байх албагүй. Харин хүн бүр өөр өөрийн сэтгэл зүй, бие бялдарт тохирсон ур чадварт тулгуурласан хамгаалалт хэрэглэж сурахад гол онцлог нь оршино.

Хамгийн чухал нь “ сургалтанд хамрагдах үедээ хүн бүр сэтгэл зүйн хувьд өөрөө өөрийгөө дээд хэмжээнд хүртэл дайчлах хэрэгтэй. Крав Мага гардан тулааны систем бөгөөд сэтгэл зүйн хувьд сайн бэлтгэлтэй байх нь чухал”[2] ач холбогдолтой гэж үздэг.

Манай улсад энэхүү сургалтын системийг нэвтрүүлэх нь төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг албадад хувьд хамгийн хэрэгцээ шаардлагатай сургалтын нэг болно гэж үзэж байгаа ба олон улсад тухайн чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагатай хамтран ажиллах хэрэгтэй юм.

**Ашигласан материал**

1. Хаянгарваа С. “Цэрэг, цагдаагийн сургуулиудын бие хамгаалах сургалтыг хөгжүүлэх зарим боломжийг судалсан нь, дис, 2011 он
2. Батжав Б. “Бие хамгаалах тактик”, 2003 он
3. Батжав Б. “Цагдаагийн албан хаагчийн биеийн хүч хэрэглэх тусгай бэлтгэлийн сургалтын онолын үндэс”, 2014 он
4. Чулуунхүү З., Эрдэнэчулуун Ч. “Бие хамгаалах ур ухаан, тусгай чадамжаа дээшлүүлье”, 2010 он
5. Батжав Б. “Бодит тулаан” УБ., 2016 он
6. Олон улсын “Крав Мага”-ийн холбооноос ирүүлсэн сургалтын материалууд
7. www.kravmaga.mn
8. www.IKMF

[2] Батжав Б. Бодит тулаан. УБ., 2016. 10 дах тал